

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН НУТАГТ МҮ-022627 АШИГЛАЛТЫН  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ИХ ХУРАЙ НЭРТЭЙ ГАЗАРТ ОРШИХ “ЧУЛУУТ  
АМНЫ АЛТНЫ ШОРООН ОРДЫН ХАЙГУУЛЫН ШУГАМ 10-20, ХУУРАЙН  
АЛТНЫ ШОРООН ОРДЫН ТАТМЫН ХЭСГИЙН ХАЙГУУЛЫН ШУГАМ 27-28,  
ДЭНЖИЙН ХЭСГИЙН 25-34 ХАЙГУУЛЫН ШУГАМ ХООРОНД ТӨСӨЛ”**

**2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**/ МҮ- 022627, РД 6637833/**

2024 он

## ГАРЧИГ

<b>НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2 Төслийн байршил.....	6
1.3 Үйлдвэрийн хүчин чадал, тоо хэмжээ.....	10
1.4 Үйлдвэрийн ажиллах горим.....	11
1.5 Дэд бүтэц.....	11
1) Ундны болон ахуйн усан хангамж, усны хэрэглээ.....	12
2) Зам талбайн усны хэрэглээ.....	12
3) Уурхайн усан хангамж.....	12
5) Нийт усны хэрэглээ.....	13
<b>ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	19
2.1 Байгаль орчны төлөв байдал.....	19
<b>ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b> ....	60
3.1 Төслийн гадаад болон дотоод овоолго барьж байгуулах үеийн гол нөлөөлөл.....	62
3.2 Гадаад болон дотоод овоолго байгуулснаас хойшхи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл.....	62
3.3 Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	63
3.4 Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл.....	65
3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл.....	65
3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл.....	66
3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл.....	66
3.8 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл.....	66
3.9 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл.....	67
3.11 Хуримтлагдах нөлөөлөл.....	67
<b>ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ</b> .....	69
<b>ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	70
<b>ЗУРГАА.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	72
<b>ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	73
<b>НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	74
<b>АРВА. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	75
<b>АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР</b> .....	78
<b>АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	80
<b>АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	80
<b>БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ</b> .....	82
<b>ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ</b> .....	82

## ТАЙЛАНД ОРСОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
Хүснэгт 2. 9011822879 дугаарын гэрчилгээтэй 465.49м.кв талбайн солбилцол.....	9
Хүснэгт 3. Үйлдвэрийн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа.....	11
Хүснэгт 4. Ахуйн ундны усны тооцоо.....	12
Хүснэгт 5. Тоосжилт бууруулахад шаардагдах усны хэрэглээ.....	12
Хүснэгт 6. Нийт усны тооцоо.....	13
Хүснэгт 7. Уурхайн барилга байгууламж.....	15

Хүснэгт 8. Нийт тоос / Нийт жинлэгдэгч бодис / хэмжилтийн үр дүн.....	19
Хүснэгт 9. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн.....	20
Хүснэгт 10. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн .....	20
Хүснэгт 11. Судалгааны талбайн зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл.....	24
Хүснэгт 12. Төслийн талбайн 1-р зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт.....	26
Хүснэгт 13. Хөрсний механик бүрэлдэхүүн .....	27
Хүснэгт 14. Хөрсний механик бүрэлдэхүүний шинж чанар.....	28
Хүснэгт 15. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж.....	29
Хүснэгт 16. МҮ-022627 талбайн хөрсний нянгийн бохирдол.....	30
Хүснэгт 17. Ашигт ургамлын экологи эдийн засгийн үнэлгээ .....	43
Хүснэгт 18. Бэлчээрийн ургамлын эдийн засгийн шууд үнэлгээний үзүүлэлтүүд.....	46
Хүснэгт 19. Хүмүүнсэг ургамлын эдийн засгийн шууд үнэлгээний үзүүлэлтүүд.....	47
Хүснэгт 20. Ургамлан нөмрөгт учирсан хохирол .....	47
Хүснэгт 21. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа.....	60
Хүснэгт 22. Гол нөлөөллийн дүн шинжилгээ .....	60
Хүснэгт 23. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ .....	64
Хүснэгт 24. Автомашины утааны бүрдэл найрлага .....	64
Хүснэгт 25. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл .....	67
Хүснэгт 26. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	70

## ТАЙЛАНД ОРСОН ЗУРГАН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байрзүйн зураг .....	6
Зураг 2. Төслийн талбайн засаг захиргааны зураг .....	7
Зураг 3. Төслийн талбайн байршлын зураг .....	8
Зураг 4. Хээрийн ажлын хэмжилтийн үед.....	10
Зураг 5. Баяжуулах тенологийн тоног төхөөрөмжийн холболтын схем.....	11
Зураг 6. DJI брэндийн Phantom 4 pro2 загварын дрoноор авсан зураг №1 .....	17
Зураг 7. DJI брэндийн Phantom 4 pro2 загварын дрoноор авсан зураг №2 .....	17
Зураг 8. DJI брэндийн Phantom 4 pro2 загварын дрoноор авсан зураг №3 .....	18
Зураг 9. Монгол орны Хөрс-Газарзүйн мужлалт .....	22
Зураг 10. Төслийн талбайн ургамалжил .....	35
Зураг 11. Уулын хээрийн хялганат бүлгэмдэл.....	35
Зураг 12. Уулын хээрийн агьт бүлгэмдэл .....	36
Зураг 13. Алаг өвст бүлгэмдэл.....	39
Зураг 14. Дээрхи зурагт төслийн тусгай зөвшөөрлийн хил дотор цагаанаар хамгаалалтын хашааг дүрсэлсэн, бор өнгөөр олборлох 3 блокуудыг харууллаа. ....	48
Зураг 15. Төслийн талбай дотор 40 га орчим талбайд мод бололзгоно сөөг бүрхсэн байна. ....	49
Зураг 16. Төслийн ой, ус, тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй тухай 2024.05.15 лавлагаа орууллаа. ....	50
Зураг 17. Төслийн ой, ус, тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй тухай 2024.05.15 лавлагааны зураглал орууллаа. ....	51
Зураг 18. УТХГН-ын сүлжээ.....	52
Зураг 19. Шарын голын сав газрын зураглал .....	54
Зураг 20. ОНТХГН-ын сүлжээ .....	55
Зураг 21. Засаг захиргааны зураг .....	56
Зураг 22. Хогийн савны төрөл.....	77

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



### 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл


“Оюут цахир уул” ХХК-ийн эзэмшдэг МҮ-022627 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Их хурай” нэртэй талбай нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн М-48-106 тоот хавтгайд 465.49 гектар талбайг хамран оршино.

Хүснэгт 1. Төслийн ерөнхий мэдээлэл

Нэг. Ерөнхий мэдээлэл		
1.1	Төсөл хэрэгжүүлэгч:	“Оюут цахир уул” ХХК
1.2	Регистрийн дугаар:	Регистрийн дугаар: 6637833
1.3	Улсын бүртгэлийн дугаар:	Улсын бүртгэлийн дугаар: 9011822879
1.4	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	<input type="checkbox"/> Улаанбаатар, Хан-Уул, 11-р хороо, 7 хэсэг, стадион оргил, 69 <input type="checkbox"/> Утас: 77777701, 88880047
1.5	Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	Ашигт малтмал, газрын тосны газрын ашигт малтмалын ашиглалтын МҮ-022627 тусгай зөвшөөрөл бүхий 2023 оны 10 сарын 12-ны өдрийн улсын бүртгэлийн 9011822879 тоот гэрчилгээ.
Хоёр. Төслийн талаарх мэдээлэл		
2.1	Төслийн нэр	Дархан-Уул аймгийн Хонгор сумын Их хурай нэртэй газарт “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”
2.2	Төслийн байршил	Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл нь Улаанбаатар хотоос хойш 250 км, Дархан-Уул аймгийн төвөөс зүүн хойш 60 км, Шарын гол тосгоны төвөөс зүүн тийш 15 орчим км-ийн зайд байрладаг нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105: 2001 стандартын шаардлагыг хангаж байна.




<p>2. 3</p>	<p>Төслийн талбайн байршил</p>	
<p>2. 4</p>	<p>Төслийн ерөнхий төлөвлөгөө</p>	 <pre> graph TD     A[Ашиглах аргууд] --&gt; A1[Ил арга]     A --&gt; A2[Далд арга]     A --&gt; A3[Усан доорх]          B[Үйлдвэрлэлийн аргууд] --&gt; B1["Ил арга • Бульдозер-скреперийн • Экскаватортой • Гидравлик • Хосолсон"]     B --&gt; B2["Усан доорх арга • Драгаар • Земснарjalaар • Штанган агергатаар"]     B --&gt; B3["Далд аргаар • Далд аргаар • Геотехникийн"]          C[Ашиглалтын системийн бүлгүүд] --&gt; C1["Ил арга • Тээвэртэй • Тээвэргүй"]     C --&gt; C2["Усан доорх арга • Хөрс хуулалттай • Хөрс хуулалтгүй"]     C --&gt; C3["Далд арга • Үргэлжилсэн • Баганат • Камерон"]     </pre>
<p>2. 5</p>	<p>Төслийн хүчин чадал</p>	<p>Үйлдвэрийн хүчин чадал Уурхайн хүчин чадал нь сарын 13.47 мян.м3 элс байна. Ордын хэмжээнд олборлох элсний хэмжээ нийт 80.8 мян.м3 байна. Олборлолтын явцад хуулсан хөрсийг гадаад овоолго болон дотоод овоолгод шууд байршуулах ба олборлосон элсийг элс угаах талбайд тээвэрлэн хүргэнэ. Дээрх хүчин чадалаар тус ордыг ашиглалтын 1 жилийн хугацаанд бүрэн ашиглаж дуусахаар тооцсон. Ордын нийт нөөц нь 3 хэсгээс бүрдэх бөгөөд уурхай-1, уурхай-2, уурхай-3 гэсэн уурхай олборлолтын явцад үүснэ. Уурхай нь эхний блокын хөрсийг гадаад түр овоолгод байршуулж орон зай гарч эхлэхээр дотоод овоолгод хөрсийг буулгаж хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэнэ. Нийт ашиглалтын 1 жилийн хугацаанд 544.1 мян.м3 хөрс хуулалтын ажил гүйцэтгэж, 80.8 мян.м3 элс олборлож шлихээр 43.9 кг алт олборлохоор байна.</p>

2.6	Төслийн хог хаягдал	<p>Хатуу хог хаягдал:</p> <p>Ахуйн хатуу хог хаягдлын тооцоогоор хоногт 9 кг, жилд 1485 кг орчим хаягдал гарах бөгөөд харъяа дүүргийнхээ холбогдох /ТҮК/-тэй байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэх, ачуулах асуудлыг цаг тухайд нь тогтмол шийдвэрлэхээр төлөвлөсөн байна.</p> <p>Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгана.</p> <p>Дахин ашиглах боломжтой хог хаягдал: Төрөл бүрийн цаас, картон, цаас, хуванцар сав, сав баглаа боодол, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут гэх мэт</p> <p>Бусад хог хаягдал: Түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдлууд</p> <p>Ахуйн аюултай хог хаягдал: Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал /ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн/ өдрийн гэрэл, цэвэрлэгээний бодис, зарим тусгай батерей зэргүүд хамаарна.</p> <p>Доорхи зургийн дагуу ялгаж хаях шаардлагатай</p>  <p>Шингэн хог хаягдал:</p> <p>Нийт 78 ажилтантай гэж үзвэл хоногт 2,4 м3, жилд улирлын чанартай ажиллах ба үүнээс амралт баяр ёслолын өдрийн хасаад 119 хоног ажиллах хугацаанд нийт хэрэглэх ахуйн усны хэмжээ 396 м3/жил болно. Усны хэрэглээнд нийт 65,622.56 мкуб усыг хэрэглэхээр тооцсон ба дэлгэрэнгүйг хүснэгт 14-т үзүүлсэн болно.</p> <p>Хийнхаягдал:</p> <p>Уурхайн ашиглалтын нийт хоногт 18 тн орчим/ дизель түлш зарцуулахад хөө – 256.96 тн, СО-0.000148 тн, нүүрстөрөгч– 0.000445 тн, NO2–0.00005927 тн, SO2-0.00002963тн, бензопирин-0.000474 тн буюу нийтдээ 256.96 тн хорт хий ялгарахаар байна.</p>
-----	---------------------	--


## 1.2 Төслийн байршил

“Оюут цахир уул” ХХК-ийн эзэмшдэг МҮ- 022627 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Их хурай” нэртэй талбай нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт, 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн М-48-106 тоот хавтгайд 465.49 гектар талбайг хамран оршино.




Зураг 1. Төслийн талбайн байрзүйн зураг





Зураг 2. Төслийн талбайн засаг захиргааны зураг



Зураг 3. Төслийн талбайн байршлын зураг

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 2. 9011822879 дугаарын гэрчилгээтэй 465.49м.кв талбайн солбилцол цэгийн дугаар Координат

Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
1	106° 34' 45.58"	49° 15' 8.2"
2	106° 34' 39.13"	49° 15' 9.36"
3	106° 34' 31.62"	49° 15' 7.97"
4	106° 34' 31.59"	49° 15' 7.97"
5	106° 34' 31.59"	49° 15' 7.97"
6	106° 34' 25.27"	49° 15' 8.24"
7	106° 34' 25.27"	49° 13' 55"
8	106° 34' 30"	49° 13' 55"
9	106° 34' 30"	49° 13' 46.89"
10	106° 34' 31.23"	49° 13' 46.89"
11	106° 34' 31.23"	49° 13' 35.74"
12	106° 34' 43.23"	49° 13' 35.74"
13	106° 34' 43.23"	49° 13' 46.95"
14	106° 35' 2.23"	49° 13' 46.92"
15	106° 35' 2.23"	49° 13' 35.74"
16	106° 36' 53.13"	49° 13' 35.74"
17	106° 36' 53.13"	49° 13' 51.92"
18	106° 36' 31.24"	49° 13' 51.92"
19	106° 36' 31.24"	49° 14' 21.84"
20	106° 36' 28.41"	49° 14' 22.5"
21	106° 36' 23.69"	49° 14' 21.86"
22	106° 36' 21.34"	49° 14' 21.32"
23	106° 36' 21.29"	49° 14' 20.46"
24	106° 36' 20.97"	49° 14' 14.85"
25	106° 36' 22.08"	49° 14' 6.41"
26	106° 36' 22.05"	49° 14' 6.42"
27	106° 36' 22.06"	49° 14' 6.41"
28	106° 36' 11.32"	49° 14' 11.6"
29	106° 36' 5.77"	49° 14' 12.75"
30	106° 35' 58.78"	49° 14' 14.74"
31	106° 35' 58.6"	49° 14' 14.78"
32	106° 35' 55.65"	49° 14' 14.4"
33	106° 35' 55.64"	49° 14' 14.4"
34	106° 35' 55.62"	49° 14' 14.4"
35	106° 35' 51.05"	49° 14' 15.32"
36	106° 35' 48.13"	49° 14' 17.09"
37	106° 35' 46.26"	49° 14' 19.7"
38	106° 35' 40.17"	49° 14' 24.96"



Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны

менежментийн төлөвлөгөө

39	106° 35' 37.91"	49° 14' 26.04"
40	106° 35' 31.42"	49° 14' 29.16"
41	106° 35' 26.27"	49° 14' 29.95"
42	106° 35' 23.57"	49° 14' 30.36"
43	106° 35' 16.04"	49° 14' 31.74"
44	106° 35' 9.88"	49° 14' 34.63"
45	106° 35' 5.54"	49° 14' 36.92"
46	106° 35' 1.47"	49° 14' 39.06"
47	106° 34' 59.93"	49° 14' 42.53"
48	106° 34' 59.71"	49° 14' 45.97"
49	106° 34' 58"	49° 14' 52.84"
50	106° 34' 56.8"	49° 14' 57.65"
51	106° 34' 52.42"	49° 15' 4.81"
52	106° 34' 47.11"	49° 15' 6.65"



Зураг 4. Хээрийн ажлын хэмжилтийн үед

### 1.3 Үйлдвэрийн хүчин чадал, тоо хэмжээ

“Оюут цахир уул” ХХК-ийн “Алтны ил шороон орд” төслийн уурхайн хүчин чадал нь сарын 13.47 мян.м<sup>3</sup> элс байна. Ордын хэмжээнд олборлох элсний хэмжээ нийт 80.8 мян.м<sup>3</sup> байна. Олборлолтын явцад хуулсан хөрсийг гадаад овоолго болон дотоод овоолгод шууд байршуулах ба олборлосон элсийг элс угаах талбайд тээвэрлэн хүргэнэ. Дээрх хүчин чадалаар тус ордыг ашиглалтын 1 жилийн хугацаанд бүрэн ашиглаж дуусахаар тооцсон. Ордын нийт нөөц нь 3 хэсгээс бүрдэх бөгөөд уурхай-1, уурхай-2, уурхай-3 гэсэн уурхай олборлолтын явцад үүснэ. Уурхай нь эхний блокын хөрсийг гадаад түр овоолгод байршуулж орон зай гарч эхлэхээр дотоод овоолгод хөрсийг буулгаж хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэнэ.

Нийт ашиглалтын 1 жилийн хугацаанд 544.1мян.м<sup>3</sup> хөрс хуулалтын ажил гүйцэтгэж, 80.8 мян.м<sup>3</sup> элс олборлож шлихээр 43.9 кг алт олборлохоор байна Элс угаан баяжуулах үйлдвэр нь ашиглалтын жилд 80.8 мян.м<sup>3</sup> элс угаан баяжуулах бөгөөд улирлын



Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө


чанартай явагдана. Угаан баяжуулах цех нь хоногт 10 цагаар 2 ээлжтэй 5 сарын хугацаатай ажиллах ба нийт 119 хоног ажиллана

#### 1.4 Үйлдвэрийн ажиллах горим

Уурхай нь улирлын чанартай ажиллах бөгөөд жил бүрийн 4-р сарын эхнээс 9-р сарыг дуустал ажиллана.

Хүснэгт 3. Үйлдвэрийн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа

№	Үзүүлэлт	Х.н	хэмжээ	Тайлбар
1	Жилийн календарийн хугацаа	хоног	365	
2	Жилд ногдох ажлын хоног	хоног	180	
3	ЖТлд ногдох ажлын бус хоног	хоног	7	Баяр ёслол
		хоног	8	Цагаан сарын саатал болон төлөвлөгөөт бус сул зогсолт
4	Жилд ажиллах нийт хугацаа	хоног	165	
5	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	2	
6	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10	
7	Хоногт ногдох ажлын нийт цаг	цаг	20	
8	Жилд ногдох ажлын нийт цаг	цаг	3300	



Зураг 5. Баяжуулах технологийн тоног төхөөрөмжийн холболтын схем

#### 1.5 Дэд бүтэц

“Оюут цахир уул” ХХК нь Их хуурай уурхайн барилга байгууламжийг ашиглагдаж байсан барилга байгууламжийг үргэлжлүүлэн ашиглана.

##### 1.5.1 Цахилгаан хангамж

Одоогийн хэрэглэж байгаа тус “Оюут цахир уул” ХХК нь өөрийн хэрэгцээний Yanmar YEG300 маркийн 250 кВт-ын чадалтай Дизель генератораас кабель шугам татан

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

эрчим хүчээр хангаж ажиллана. Уурхайн үндсэн цахилгаан хэрэглэгч нь уурхайн гэрэлтүүлэг, алт угаах төхөөрөмж, усны насосуд байна.

### 1.5.2 Усан хангамж

#### 1) Ундны болон ахуйн усан хангамж, усны хэрэглээ

Ахуйн хэрэглээний усны тооцоо: Уурхайд нийт 78 хүн ажиллана. Нэг хүний ус хэрэглээний норм хоногт ажлын болоод ахуйн хэрэгцээнд дунджаар 80л орчим байна. (\* - БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт –“Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”, Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон нийтийн байр – 80л/хоног/хүн) Уурхайн ахуйн усыг Шарын голоос зөөж нөөцөлж цэвэршүүлж хангана.

Хүснэгт 4. Ахуйн ундны усны тооцоо

№	Үзүүлэлтүүд	Норм, л/хоног	Хүний тоо, ш	Усны зарцуулалт		
				м3/хоног	Жилд ажиллах хоног	м3/жил
1	Уурхайн ажилчдын усны хэрэглээ	80л/ажилтан	78	6.24	119	742.56

#### 2) Зам талбайн усны хэрэглээ

БОАЖНХЯ-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалаар баталсан ус хэрэглээний нормын дагуу 1 м<sup>2</sup> зам талбайг 2.0 л усаар усална гэсэн нормоор усны хэрэгцээг тодорхойлбол. Уурхайн дотоод тээврийн зам 6000 м<sup>2</sup>, 7 хоногт 1 удаа жилийн 119 хоногт /1 жил дэхь ажиллах хоног/ усална гэж тооцлоо.

Орон нутгийн уур амьсгал, замын хөдөлгөөний эрчим, тухайн замын тоосжилтын байдлаас хамааран замын тоос дарах ажлыг 7 долоо хоног тутамд явуулна (зөвхөн өдрийн цагаар). Автоцистерн тодорхой чиглэлийн дагуу явж замын тоос дарж ус шүршинэ. Шаардлагатай тохиолдолд замд хэсэгчлэн тоос дарах ажиллагааг хэрэгжүүлнэ. Тоос дарах ажлыг тоногдсон нэг усалгааны машин гүйцэтгэнэ.

Хүснэгт 5. Тоосжилт бууруулахад шаардагдах усны хэрэглээ

Ашиглалтын жил	Жилд услах зам, м <sup>2</sup>	1 удаагийн усалгаанд шаардагдах ус, литр	Жилд услах хоног	м <sup>3</sup> /жил	Ундарга, л/сек
Жилд	6000.0	12.0	20	240.0	-

#### 3) Уурхайн усан хангамж

БОНХАЖ-ын сайдын 2015.07.30-ны А/301 тоот “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай” тушаалын 2-р хавсралтанд алтны шороон ордын 1 м<sup>3</sup> элсийг угаан баяжуулахад 4 м<sup>3</sup> ус хэрэглэнэ гэж

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

нормчилсон байна. Үүний дагуу 1:4 ус хэрэглэх ба нийт технологийн усны 80%-ийг эргүүлэн ашиглана.

Хаягдлын цөөрөмд эфель тунаж, цэвэршсэн усыг эргүүлэн технологид ашиглана. Угаалга эхлэхэд технологийн усан хангамжийг голоос бүрэн хангах ба үйлдвэрлэлийн явцад усан хангамжийн 80%-ийг эргэлтийн усаар хангаж, үлдсэн 20%-ийг усыг шүүрлийн усаар нөхөн сэлбэхээр тооцов.

Баяжуулах цех нь нийт 80.8 мян.м<sup>3</sup> элс угаан баяжуулна. Баяжуулах цех нь ашиглалтын хугацаанд нийт 64.64 мян.м<sup>3</sup> ус цэвэр ус ашиглахаар төлөвлөсөн.

Тухайн орон нутгийн цаг агаарын байдлаас шалтгаалан усан сангийн усанд ууршилт шүүрэлтээс болж алдагдал гардаг. Иймд уг алдагдлыг гадаад эх үүсвэрээс цэвэр усаар нөхөж, голын түвшнийг тогтмол барьж байх шаардлагатай.

Технологийн усан хангамжийн үйл ажиллагаа нь тунгаагуур бүхий усан сан-уст давхаргаас шүүрсэн ус хуримтлуулах усан сан –ус шахах насос –угаах төхөөрөмж гэсэн схемээр явагдана.

### 5) Нийт усны хэрэглээ

#### Хүснэгт 6. Нийт усны тооцоо

№	Үзүүлэлтүүд	Норм, л/хоног	Хүний тоо, ш	Усны зарцуулалт		
				м <sup>3</sup> /хоног	Жилд ажиллах хоног	м <sup>3</sup> /жил
1	Ахуйн усны хэрэглээ	80	78	6.24	119	742.56
2	Нийт элс угаах усны хэрэглээ	4м <sup>3</sup> /м <sup>3</sup>	80.8мян.м <sup>3</sup> элс угаана			323200.0
	Эргэлтийн системийн ус 80%					258560.0
	Усны алдагдал 20%					64640.0
	Усны алдагдлыг			48.7 <sup>1</sup> м <sup>3</sup> /хон	119	5,795.3м <sup>3</sup> /жил
	Гадаргын болон шүүрлийн усаар хангана					
3	Зам усалгаа	6000м <sup>2</sup>	2л/м <sup>2</sup>	12	20	240.0
	<b>НИЙТ</b>					<b>65,622.56</b>
	Шүүрлийн усны ундарга	48.7 м <sup>3</sup> /хон буюу 48.7м <sup>3</sup> /хон *119хон =	<sup>2</sup>	Баяжуулах үйлдвэрт шаардагдах нийт цэвэр усыг шүүрлээр хангана. 20% цэвэр усыг шүүрэл болон гадаргын усаар хангана.		

<sup>1</sup> “Оюут цахир уул” ХХК-ийн 2022-2023 оны хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, хуу-86

<sup>2</sup> “Оюут цахир уул” ХХК-ийн 2022-2023 оны хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, хуу-86

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	5,795.3м <sup>3</sup> /жил	
--	-------------------------------	--

Шүүрлийн усны ундаргыг “Оюут цахир уул” ХХК-ийн 2022-2023 оны хайгуулын ажлын үр дүнгийн батлагдсан тайлангаас шүүрэлтийн усны коэффициентийг хуудас 86-аас авлаа.


### Голоос авч ашиглаж болох усны хэмжээ

2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хээрийн судалгаагаар Шарын голын олон жилийн урсгалын хурд дундажаар 0.5- 0.7 м/с гэж тогтоогдсон байна.

Шарын гол нь төслийн талбайн урд талаар урсдаг.

Ордыг ашиглах үед шаардагдах технологийн усыг Хуурайгийн хөндийд жижиг нуураас хангах бүрэн боломжтой, гидрогеологийн хувьд таатай нөхцөлд оршино.<sup>3</sup>

Шарын голын олон жилийн урсацын анализ дата 2019 он хүртэлхи -дундаж 0.92м<sup>3</sup>/с, харин 2019-2022 он дуусталхи дата харьцуулахаар 0.72м<sup>3</sup>/с болж байна.



Зураг 3. Олон жилийн урсацын явц

### Хаягдлын сан

Угаан баяжуулах цехийн хаягдал /шлам/ хадгалах тунаах, цэвэршүүлэх байгууламжийг байгуулах талбайн ургамлын өнгөн хөрсийг хуулж, зөөж овоолсны

<sup>3</sup> “Оюут цахир уул” ХХК-ийн 2024 оны ТЭЗҮ, хуу-23

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

дараа далангийн суурийг сайтар тэгшилж, нягтруулж бэлдэнэ. Нуур далан байгуулах талбай нь харьцангуй тэгшивтэр буюу бага зэргийн хэвгий тул далангийн овоолго хийх хөрсийг сангийн эргэн тойронд тойруулан жигд тарааж тэгшлэх ба уг ажлыг далан нуурын ухашнаас гарсан хөрсөөр гүйцэтгэнэ. Далангийн овоолгод ашиглах хөрсний ширхэглэлийн хамгийн том хэмжээ нь 150 мм-ийн диаметртэй байна. Хаягдал /шлам/ хадгалах байгууламжийн сангийн ёроолоос шавар хөрсийг ялган авч, далангийн дээд ирмэгийн налуу дээр буулган, хэвтээ чиглэлд 5м өргөн, 0.3м зузаан үеэр тарааж нягтруулан шавар үеийг хийнэ. Далангийн дээд ирмэгийн налуу дээр хийх шавар үеийн зузаан нь далангийн налуутай перпендикуляр чиглэлт 1 м-ээс багагүй зузаан байна. Шавар үед ашиглах хөрсний хамгийн том ширхэглэл нь 5 мм-ээс бага байна.

Нуур даланг хавсралт зурагт заасны дагуу бохир усны /шламтай ус/, цэвэр усны гэсэн хэсэгтэй хийх ба дунд нь тусгаарлах далан байна. Тусгаарлах далан нь уурхай ашиглалтын жил ахих тусам өндөрлөгдөж явах ба далангийн тодорхой хэсэг усыг шүүх бүтэцтэй бүдүүн нарийн хайрга хийгдэнэ. Мөн тусгаарлах даланд халианы хоолой суулгаж өгнө.

Хаягдлын усан сангийн эзлэхүүнийг тооцохдоо угаан баяжуулах цехийн үйл ажиллагааг тасралтгүй 7 хоног хангах боломжийг бүрдүүлэхээр төлөвлөсөн.

$$Усан\ сан = W_{ус} * 7 = 6453.6 * 7 = 45176\ м^3$$

Цэвэр усны хоногийн усны хэрэглээ 1564 м<sup>3</sup> бөгөөд цэвэр усан сангийн багтаамж нь  $W_{цэвэр\ ус} * 7 = 1564 * 7 = 10948\ м^3$  буюу 10950-аас багагүй байна. Уурхайн усан санг хуучин ухаш үүссэн хэсэг, тогтоцыг ашиглаж үүсгэнэ.

### 1.5.3 Барилга байгууламж

Уурхайн барилга байгууламжид захиргаан5ы байр, ажилчдын болон хоолны байр, агуулах, ШТС, харуулын байр багтана.

### 1.5.4 Уурхайн тосгон

Уурхайн тосгоныг ил уурхайгаас хойд зүгт байрлуулна. Уурхайн тосгон нийт 0.5 га талбайг хамарна.

Хүснэгт 7. Уурхайн барилга байгууламж

№	Байгууламж	Хийц	Тоо хэмжээ
1	Уурхайн захиргаа	контейнер	3
2	Материалын агуулах	контейнер	2
3	Ажилчдын сууц	Стандартын дагуу тохижуулсан контейнер	30
4	Цайны газар	контейнер	2
5	Халуун ус	вагончик	2
6	Шатахуун түгээх станц	25 тн	1

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

7	Харуулын байр	вагончик	1
---	---------------	----------	---

Ил уурхайд жижиг засварын газрыг барьж байгуулна. Уурхайн машин техник, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг өөрийн засварын мэргэжилтнүүд хийж гүйцэтгэнэ. Засварын хэсэгт дугуй засвар, гагнуур, компрессор зэргийг суурилуулна.

#### **Машин техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, материалын агуулах**

Үндсэн болон туслах үйлдвэрлэлийн хэрэгцээнд ашиглагдаж байгаа техник хэрэгслийг засварлахад чиглэгдэнэ. Энэ агуулах нь 1 ш контейнер ба уурхайн засварын талбайн хойд хэсэгт байрлана. Засварын газар нь уурхайн машин техник, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг өөрийн засварын мэргэжилтнүүд хийж гүйцэтгэнэ. Засварын хэсэгт дугуй засвар, гагнуур, компрессор зэргийг суурилуулна.

#### **ШТМ-ийн агуулах**

Шатах тослох материалын агуулах нь Уурхайн тосгоноос 1 км-н зайд орших бөгөөд түлшний 25 тонны 1 ш ёмкост байна. Эдгээр агуулах байрлах газарт аянга зайлуулагчийг давхар суурилуулна. Тос, тосолгооны материалыг зориулалтын савтай нь агуулахад хадгална. ШТМ-ын гал аюулгүй байдлын шаардлага, норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.

#### **1.5.5 Холбоо дохиолол**

Уурхайн хэмжээгээр ажлын уялдаа холбоог сайжруулахын тулд хэсэг цехүүдийн дунд богино долгионуудын станцуудыг ашиглах ба уурхайг Дархан-Уул аймагтай холбохын тулд интернетийн холбоог ашиглана.

#### **1.5.6 Зам харилцаа**

Уурхайн зам харилцаанд орон нутгийн замтай 3 км орчим зам засах, тосгоноос ил уурхайн хүртэлх, ил уурхайгаас технологийн шугам, баяжуулах цех, ШТМийн агуулах руу явах зэрэг зам харилцаа багтана. Зам нь сайжруулсан шороон зам байна.

Уурхайн замд хурдыг 35 км/цагаар хязгаарлах бөгөөд уруудаж байгаа үед хурдны хязгаар 25 км/цаг байна. Ашиглалтын хугацаанд уурхайн зам нь авто тээврийг бүтээлтэй ажиллахад нөлөөлөх гол хүчин зүйл болдог. Иймээс уурхайн замд засвар үйлчилгээг тогтмол хийх шаардлагатай. Тээвэрлэлтийн үед үүсэх замын тоосыг зам услах зориулалтын машинаар тогтмол усалж, тоосгүйжүүлэх арга хэмжээг авч ажиллана.



Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



*Зураг 6. DJI брэндийн Phantom 4 pro2 загварын дрoноор авсан зураг №1*



*Зураг 7. DJI брэндийн Phantom 4 pro2 загварын дрoноор авсан зураг №2*



Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө




*Зураг 8. DJI брэндийн Phantom 4 pro2 загварын дроноор авсан зураг №3*

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

## ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1 Байгаль орчны төлөв байдал

Төслийн талбай орчимд хуулиар хамгаалагдсан газар нутаг, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байхгүй байна. Харин төслийн үйл ажиллагааны үр дүнд газар нутгийн эмзэг байдлаас шалтгаалж сөрөг нөлөө үүсэх, үүссэн сөрөг нөлөө хуримтлагдаж болзошгүй нөхцлүүд байх боломжтой байна.



Зураг 1. Төслийн талбайн районы д.т.д үнэмлэхүй өндөршлийн зураг

Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл

Жилд 43.57 кг олборлохын тулд 544.1 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 80.8 мян.м<sup>3</sup> элс угаана.

Агаарын чанар

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан нийт тоосны хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас даваагүй, хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 8. Нийт тоос / Нийт жинлэгдэгч бодис / хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	Нийт тоос /Нийт жинлэгдэгч бодис/
---	-----------------	-----------------------------------

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1	Ажлын талбай	0.87
2	Гадна талбай	0.92
Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016		0.500

Агаарын бохирдуулагч бодисын хэмжилт

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан хүхэрлэг хий болон азотын давхар ислийн хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 9. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	NO2 (Азотын давхар исэл мг/м3)	SO2 (Хүхэрлэг хий мг/м3 )
1	Ажлын талбай	0.066	0.065
2	Гадна талбай	0.085	0.115
Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016		0.200	0.450

Дуу шуугианы хэмжилт

Дуу шуугианы үзүүлэлтийг хяналтын 2 цэгийн ойр орчимд хэмжсэн ба 16 цагийн дундаж үр дүнг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.

Хүснэгт 10. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	Дуу чимээ дБ (А)
1	Ажлын талбай	65
2	Гадна талбай	60
Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016 дБ (А), 16 цагийн дундаж		60

Дүгнэлт, зөвлөмж

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

---

Төслийн эзэмшил талбай болон гадна талбайгаас агаарын хүхэрлэг хий (SO<sub>2</sub>), азотын давхар исэл (NO<sub>2</sub>), нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан хэмжилт хийж гарсан үр дүн тус бүрийг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байна.

Шуугиан гэж янз бүрийн давтамжтай өндөр, нам авианы замбараагүй хослолыг хэлнэ. ДЭМБ-аас гаргасан судалгаагаар шуугианы шалтгаантай сонсгол бууралт нь дэлхийд хамгийн түгээмэл тохиолддог, урьдчилан сэргийлэх боломжтой мэргэжлээс шалтгаалсан өвчний нэг гэж үздэг [12].

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн талбайд ногоон байгууламж хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай учир нь модлог ургамал дуу чимээний бохирдлыг бууруулаад зогсохгүй орчны агаарыг цэвэршүүлэх ач холбогдолтой. Зайлшгүй шаардлагатай биш бол машины дуут дохиог хэрэглэхгүй байхыг ажилчдад анхааруулах.

#### Хөрсөн бүрхэвч

Энэхүү бүлэгт Дархан-Уул аймгийн Хонгор сумын Их хурай нэртэй газар орших “Оюут цахир уул” ХХК -ийн Алтны ил шороон орд газарт хийсэн хөрсний хээрийн болон лабораторийн шинжилгээний үр дүнг тусгав. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн Хэнтийн муж, Хэнтийн захын тойрогт хамаарагдана (ШУА, Газарзүйн хүрээлэн, 2022).



Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл” 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

---

Лабораторийн задлан шинжилгээ: Хөрсний агрохимийн болон хүнд металлын дээжийг “Нарт Шуун Консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв.

Лабораторийн судалгааны арга зүй:

Лабораторид дараах задлан шинжилгээг хийсэн байна. Үүнд:

Хөрсний механик бүрэлдэхүүн-Качинскийн арга, %;

Хөрсний урвалын орчин- Усан ханданд ионометрийн арга;

Хөрсний ялзмаг-Тюрингийн арга %;

Хөрсний давс-ионометрийн арга;

Хөрсний цахилгаан дамжуулах чанар-ионометрийн арга, ds/m;

Хөрсний карбонатын агууламж-кальциметрийн арга %;

Хөрсний солилцох сууриуд- (Ca, Mg) комплексметрийн арга, мг-экв / 100 гр;

Хөрсний хөдөлгөөнт фосфор (P<sub>2</sub>O<sub>5</sub>)- 1% нүүрс хүчлийн аммоны уусмалд Мачигины арга, мг/100 гр хөрсөнд;

Хөрсний хөдөлгөөнт кали (K<sub>2</sub>O)- 1% нүүрс хүчлийн аммоны уусмалд дөлийн фотометрийн арга, мг/100 гр хөрсөнд;

Гэдэсний бүлгийн савханцар болон байж болох E.coli-г илрүүлэх арга (MNS 5367:2004) стандартын дагуу;

Хөрсний чанар. Хөрсөнд эрүүл зүйн нян судлалын шинжилгээ хийх араг (MNS 6341:2012) стандартын дагуу;

Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үзүүлэлтийн норм, хэмжээ (MNS 3297:1991) стандартын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

Зураглалын судалгаа: Хөрсний судалгааны ажлын хамгийн чухал мэдээлэл нь хөрсний зураглалын судалгааны арга юм. Зураглалаар хөрсний бүрхэвч, хөрсний хил хязгаарын тархалт, элэгдэл эвдрэлийн байдал зэрэг чухал үзүүлтүүдийг хөрсний зургаар энгийн байдлаар харуулах боломжтой юм. Үүний тулд дээрх аргазүйн дагуу боловсруулсан, дүгнэсэн мэдээллүүддээ үндэслэн, мөн өмнөх суурь судалгааны материалуудыг ашиглан хөрсний хэв шинжийн зургийг бэлтгэсэн.



Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Боловсруулалт: Хээрийн судалгааны ажлын үед хийсэн хөрсний морфологи шинж чанарын бичиглэл болон агрохимийн үзүүлэлтүүд, механик бүрэлдэхүүний лабораторийн шинжилгээний үр дүнг тус бүрээр үр дүнгийн хэсэгт үзүүлж, дэлгэрэнгүй тайлбар хийсэн. Хөрсний хүнд металлын лабораторийн шинжилгээний үр дүнг MNS 5850:2008 (Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ) стандарттай харьцуулан төслийн талбайн хөрсний хэвшинжийн зураг (1:100.000)-ийг хээрийн судалгааны үр дүн, Монгол улсын үндэсний атлас (2009)-ыг үндэслэн, ArcGIS 10.3 программ дээр боловсруулав.

Судалгааны үр дүн

Хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн тодорхойлоход тал хөндийн хар хүрэн хөрс тархсан байна.



Хөрсний морфологи болон хими физик шинж чанар

Хүснэгт 11. Судалгааны талбайн зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл


Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар	Дээж 1	
Байршил	Дархан-Уул аймгийн Хонгор сум Их хурай	
Координат	106°34'57.82"E	
	49°14'09.11"N	
Огноо	2023.07.02	
Өндөр	д.т.д 1068 метр	
Газрын гадарга	Төслийн талбай дотор	
Ургамлын бүрхэвч	70-80%	
Хөрсний нэр	Тал хөндийн хар хүрэн хөрс	
Хөрсний фото	Гүн	Морфологи бичиглэл



Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МУ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хөрсний морфологи бичиглэл		
	<p>Аш. 0-20 20 см</p>	<p>Хүрэн өнгөтэй, сийрэг, шилжилт тэгш биш, алгуур, ургамлын үндэстэй, бөөмөн бүтэцтэй.</p>
Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар	Дээж 2, Уулын ам	
Байршил	Дархан-Уул аймгийн Хонгор сум Их хурай	
Координат	49°13'58.62"N	
	106°35'30.73"E	
Огноо	2023.07.02	
Өндөр	д.т.д 1095 метр	
Газрын гадарга	Төслийн талбай дотор	
Ургамлын бүрхэвч	70-80%	
Хөрсний нэр	Тал хөндийн хар хүрэн хөрс	
Хөрсний фото	Гүн	Морфологи бичиглэл
	<p>Аш. 0-20 20 см</p>	<p>Хүрэн өнгөтэй, сийрэг, шилжилт тэгш биш, алгуур, ургамлын үндэстэй, бөөмөн бүтэцтэй.</p>
Хөрсний морфологи бичиглэл		

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл” 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар	Дээж 3	
Байршил	Дархан-Уул аймгийн Хонгор сум Их хурай	
Координат	49°13'37.14"N	
	106°36'18.67"E	
Огноо	2023.07.02	
Өндөр	д.т.д 1074 метр	
Газрын гадарга	Төслийн талбай дотор	
Ургамлын бүрхэвч	70-80%	
Хөрсний нэр	Тал хөндийн хар хүрэн хөрс	
Хөрсний фото	Гүн	Морфологи бичиглэл
	Аш. 0-20  20 см	Хүрэн өнгөтэй, сийрэг, шилжилт тэгш биш, алгуур, ургамлын үндэстэй, бөөмөн бүтэцтэй.

Хүснэгт 12. Төслийн талбайн 1-р зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт

№	Гүн, см	pH H <sub>2</sub> O	ЦДЧ, dS/m	Давс	Ялзмаг %	CO <sub>2</sub>	NO <sub>3</sub> , мг/100 гр	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
								Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
Дээж 1											
1	0-20	6.63	0.021	0.009	3.08	0.0	0.35	15	8	5.2	9
Дээж 2											

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурай алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны

менежментийн төлөвлөгөө

2	0-20	6.72	0.215	0.091	2.98	0.0	1.23	17	9	4.4	13
---	------	------	-------	-------	------	-----	------	----	---	-----	----

Дээж 1. Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь сул хүчиллэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж бага, шингээгдсэн сууриудын нийлбэр хэмжээ их, хялбар уусах давсны агууламж бага буюу давсжилтгүй, солилцох сууриас Са их, Mg маш их агууламжтай мөн хөдөлгөөнт фосфор, калийн агууламж маш бага байна. Хөрсний үржил шимийн түвшин дундаж байна.

Дээж 2. Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь сул хүчиллэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж бага, шингээгдсэн сууриудын нийлбэр хэмжээ их, хялбар уусах давсны агууламж бага буюу давсжилтгүй, солилцох сууриас Са их, Mg маш их агууламжтай мөн хөдөлгөөнт фосфор, калийн агууламж маш бага байна. Хөрсний үржил шимийн түвшин дундаж байна.

Хөрсний механик бүрэлдэхүүн

Хөрсний хатуу хэсгийг бүрдүүлж байгаа жижиг ширхгүүдийн хэмжээгээр нь ангилан тэдгээрийг хувиар илэрхийлснийг механик бүрэлдэхүүн гэнэ. Энгийн ширхгийн хэмжээгээр нь шороо ба чулуу гэсэн хоёр том бүлэгт хуваана. Хөрсний задлан шинжилгээнд бэлтгэхэд 1 мм-ийн шигшүүрээр шигших бөгөөд түүнээс том хэмжээтэйг чулуу, харин шигшигдэж орсон 1 мм-ээс бага ширхэгтэйг шороо гэнэ (Аваадорж бусад 2012).

Хүснэгт 13. Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Дээж авсан гүн, см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар						
		Элс		Тоос				Шавар
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 1								
1	0-20	8.5	44.4	23.5	5.7	9.5	8.4	23.6
Дээж 2								
2	0-20	6.8	43.1	24.9	7.4	10.2	7.6	25.2

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход дунд шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна. Энэхүү хөнгөн механик бүрэлдэхүүнтэй хөрс нь норж дэвтсэн үедээ хөөж, малын хөлд

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

наалдаж мөр гаргахгүй мөн хуурай үедээ сууж өрөмдөхгүй. Том ширхэгтэй бөгөөд ихэнх тохиолдолд сулхан, тогтворгүй бүтэц үүсгэдэг. Ширхгүүдийн хооронд зай томтой агааржилт сайтай усны хөдөлгөөн ихтэй. Уужим сүвтэй, гадаргадаа бусад биетийг шингээх чадвар султайгаас хур тунадас элбэгтэй жилд ургамлын хооллолтонд чухал ач холбогдолтой бодис ба анион, катион хөрсний гүнд угаагдах аюултай. Хөнгөн хөрс шингээлт багатайгаас шим тэжээлийн бодис бага агуулагдах ба байгалийн нөөц үржил шимээр ядуу юм. Хөнгөн хөрс хуурай, агааржилт сайтайгаас хавар эрт бүлээсэж, тэр хэмжээгээрээ эрт ногоо идүүлдэг сайн талтай.

Хүснэгт 14. Хөрсний механик бүрэлдэхүүний шинж чанар

Хөрсний шинж чанарын үзүүлэлт		Механик бүрэлдэхүүн		
		Элсэнцэр ба хөнгөн шавранцар	Дунд шавранцар	Хүнд шавранцар, шавар
1	Боловсруулалт	++	+	-
2	Тэжээлийн бодис агуулалт	-	+	++
3	Ургамлын тэжээлийн бодис нийлүүлэлт	-	++	+
4	Хоруу бодисын хуримтлал	-	++	++
5	Ус агуулалт	-	++	++
6	Ургамал ус нийлүүлэлт	-	+	-
7	Механик шүүлт	+	+	-
8	Физик-химийн шүүлт	-	++	+
9	Ус шүүлт	++	0	-
*++маш сайн (дээд зэрэг), + сайн (өндөр), 0 хангалттай (дунд зэрэг), - тааруу, - - нэн хангалтгүй				

Дээрх хүснэгтээс үзэхэд элсэнцэр хөрс нь тэжээлийн бодис, ус агуулалт болон физик химийн шүүлт нэн хангалтгүй, ургамлын тэжээлийн бодис нийлүүлэлт, хоруу бодисын хуримтлал, ургамлын ус нийлүүлэлтээр тааруу харин механик шүүлт сайн, хөрсний боловсруулалт, ус шүүлтээр маш сайн гэсэн үзүүлэлттэй байна.

### Хөрсний бохирдол

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг тодорхойлох зорилгоор бид хүнд металлын 2 дээж авч “Нарт Шуун Консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-д тус бүр Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu гэсэн 6 элементийг задлан шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнг дэлгэрэнгүй байдлаар доорх хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 15. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

Зүсэлтийн дугаар	Гүн, см	Хүнд металлын агууламж мг/кг					
		Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Zn /Цайр/	Cr /Хром/	Cu /Зэс/
Дээж 1	0-20	25.0	0.0	29.2	81.2	13.4	40.7
Элсэрхэг хөрс (MNS 5850: 2019)		60	1	50	100	60	60
Шавранцар хөрс (MNS5850:2019)		100	1.5	70	150	100	80
Шаварлаг хөрс (MNS 5850: 2019)		150	3	100	300	150	100

Хөрсний дээжинд хүнд металлын шинжилгээг атомын шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлсон бөгөөд гарсан үр дүнг (MNS 5850: 2019) Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас даваагүй, хөрс бохирдолгүй байна.

MNS 5850: 2019 стандарт нь хөрс бохирдуулагч бодисуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээний 3 зэрэглэлд хуваадаг. Үүнд:

Хүлцэх агууламж

Хортой агууламж

Аюултай агууламж

Хүлцэх агууламж: бохирдуулагч бодис, элементийн хөрсөнд агуулагдах хэмжээ нь хүлцэх агууламжаас дээш гарсан тохиолдолд хөрс бохирдолтын түвшинд хүрсэн гэж үзнэ. Хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь адил утгатай. Хүлцэх агууламжийг хүн ам оршин суудаг суурин газар, хөдөө аж ахуйн эдэлбэр, газар тариалан, бэлчээрийн эдэлбэр газруудад мөрдлөг болгоно.

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хортой агууламж: хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодис, элементийн хэмжээ нь хортой агууламжаас давсан тохиолдолд тухайн хөрс нь орчин тойронд байгаа амьд организм, усан давхаргад хортой аюул учруулж эхэлнэ. Хортой агууламжийг тусгай зөвшөөрөлтэй үйлдвэрлэл, уул уурхайн бүсэд бохирдуулагч бодис, элементийн хөрсөнд агуулагдах зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй адил утгаар мөрдлөг болгоно.

Аюултай агууламж: хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодис, элементийн хэмжээ нь аюултай агууламжаас давсан тохиолдолд хөрсний бохирдлыг арилгах яаралтай арга хэмжээ авах шаардлагатай. Тухайлбал саармагжуулах, ухаж зайлуулах, газар ашиглалтын үйл ажиллагааг зогсоох, оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх гэх мэт.

Хөрсний нянгийн бохирдол

Хүснэгт 16. МҮ-022627 талбайн хөрсний нянгийн бохирдол

Дээжний дугаар	Нянгийн тоо	Гэдэсний савханцрын титр		Перфрингенсийн таньц	
	MNS 6341:2012	MNS 5367:2004		MNS 6341:2012	
	Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
Дээж 3	5.8*105	1	1	0.1<	1


Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүнг (MNS 3297-1991) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарттай харьцуулахад дээрх үзүүлэлт илрээгүй буюу хөрс бохирдолгүй байна.

Одоогийн хөрсний эвдрэлтэй талбайн зураглал

2023 оны 7 сарын хэрийн судалгаагаар тус талбайд зөвшөөрөлгүй бичил алт олборлогч нар болон хил залгаа орших уурхайнууд тусгай зөвшөөрлийн хилийг зөрчин нийт 9.1 га орчим талбайг эвдрэлд өртүүлсэн байна.



Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



### Ургамлан бүрхэвч

Дархан -Уул аймгийн Хонгор сумын нутагт байгуулах төслийн талбайн ургамлан нөмрөгийн төлөв байдлын хээрийн хэмжилт судалгааг 2023 оны 7 сард хийж гүйцэтгэсэн бөгөөд хээрийн судалгаагаар төслийн талбайтай танилцах, хээрийн хэмжилт бичиглэл хийх, ургамлын суурь мэдээ материал цуглуулах, нөлөөлөлд өртсөн талбайн ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлж баталгаажуулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

### Судалгааны аргазүй

Хээрийн судалгааг хийхдээ 10м x10м талбайг сонгон авч ургамалжлын судалгааны аргазүй (Х.Буян-Орших, 2005)-н дагуу геоботаникийн бүрэн бичиглэл үйлдэж зүйлийн бүрдэлийг В.И. Грубов (1982) “Монгол орны гуурст ургамал тодорхойлох бичиг”-ээр тодорхойлж, өвслөг ургамлын арвийг О.Друдегийн хувиараар, сөөгний арвийг бодгалийг тоолох аргаар, тусгагийн бүрхэцийг нүдэн баримжааны аргаар, өндөр, үзэгдэлзүйн үе шатыг тэмдэглэж ургацын дээжийг 1м<sup>2</sup> талбайн ургамлыг газрын хөрстэй тэнцүүлэн 2-4 давталттай авна. Авсан дээжээ хатааж, жигнэн дундажлаж тухайн талбайн ургацыг тодорхойллоо.



Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт МҮ-022627 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их хурай нэртэй газарт орших “Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд төсөл”2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

---

Ургамалжлын ангилааг үйлдэхдээ Экологи - Фитоценологийн зарчим (И.Түвшинтогтох, 2006) - аар гүйцэтгэв.


Ургамлан нөмрөгийг үнэлэхдээ TNC, “Ногоон алт” төсөл, ШУА-ийн Ботаникийн Цэцэрлэгт хүрээлэнгийн эрдэмтдийн боловсруулсан ургамлын төлөв байдлыг үнэлэх аргагүйг харьцуулан хийлээ.

Төслийн талбайн ургамлан нөмрөгийн төлөв байдал

Дархан - Уул аймгийн Хонгор сумын нутагт орших төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Монгол дагуурын ойт хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Хэнтийн нурууны захын салбар уулсыг хамрах бөгөөд Хэнтийн тойргийг тал цагираг байдлаар хүрээлэн оршино. Хэнтийн нурууг тойрсон Онон, Улз, Туул, Хараа, Ерөөгийн хөндийн зурвас нутгийг хамаарна. Ургамлын аймгийн хувьд гол нь Дагуурын ойн ба уулын хээрийн төлөөлөгчдөөс, өмнөд захаар нь Монголын хээрийн төлөөлөгчдөөс бүрдэл бүхий уулархаг хээрийн ургамал зонхилно. Тус тойрогт нийт 1307 зүйл тархсан ба зөвхөн энэ тойрогт тохиолдох 50 зүйл ургамал ургана.

Дархан –Уул аймагт ургамлын аймагт 11 зүйлийн нэн ховор, 21 зүйлийн ховор ургамал тархсанаас 3 зүйл Монгол Улсын улаан номонд, 5 зүйл Монголын Ургамлын Улаан дансанд тус тус багтсан байдаг.

10-20, ХУУРАЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ТАТМЫН ХЭСГИЙН  
ХАЙГУУЛЫН ШУГАМ 27-28, ДЭНЖИЙН ХЭСГИЙН 25-34  
ХАЙГУУЛЫН ШУГАМЫН ХООРОНДОХ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ  
ИЛ АРГААР АШИГЛАХ, ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ**

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-022627

Ашигт малтмалын төрөл: Алт

Жилийн хүчин чадал: 80.8 мян.м<sup>3</sup> элс  
40.6 кг алт

ХЯНАСАН:

ЭРДЭС БАЯЛАГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Б.Хулан* Б.ХУЛАН

ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ:

МУ-ЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР:



Д.ЭРДЭНЭЧИМЭГ

ТӨСЛИЙН ШИНЖЭЭЧ:

МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР

*М.Хэрлэнбаатар*

М.ХЭРЛЭНБААТАР

МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР

*С.Эрдэнэбилэг*

С.ЭРДЭНЭБИЛЭГ

Улаанбаатар хот  
2024 он



Ашигт малтмал, газрын тосны газрын даргын  
2022 оны 12 дугаар сарын ..... –ны өдрийн  
..... дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

Батлав:

Оюут цахир уул ХХК-ийн  
захирал ..... / Б.Сүмбэр /



Хүлээн авсан:


АМГТГ-ын Уул уурхайн хэлтсийн  
дарга ..... / Т.Зууннаст /



## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН ИХ ХУРАЙ ОРДЫН 2024 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



Ашигт малтмалын төрөл: Алт (Шороон)  
Үндсэн АТЗ-ийн дугаар: MV-022627  
Нэмэлт АТЗ-ийн дугаар:



Танилцсан: Уул уурхайн хэлтсийн ахлах мэргэжилтэн

/П.Зоригт/

### БОЛОВСРУУЛСАН:

1. Ерөнхий инженер
2. Уулын инженер
3. Баяжуулагч инженер
4. Механик инженер
5. Эдийн засагч



**ГАРЧИГ**

<b>ОРШИЛ</b> .....	<b>1</b>
<b>ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	<b>2</b>
<b>БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА</b> .....	<b>4</b>
I.1. Төслийн зорилго .....	4
I.2. Төсөл хэрэгжүүлэх эрх зүйн орчин.....	4
I.2.1. Төсөл боловсруулагчийн мэдээлэл.....	<b>Error! Bookmark not defined.</b>
I.2.2. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл .....	4
I.3. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө .....	4
I.4.  Орд ашиглах тусгай зөвшөөрөл.....	5
I.5. Ордын нөөцийн баталгаажуулалт .....	6
I.6. Төслийн цар хүрээ .....	7
I.7. Төсөл судалгааны аргачилал .....	7
I.8. Төсөл хэрэгжих ордын товч тодорхойлолт .....	7
I.8.1 Ордын байршил.....	7
I.8.2. Физик газар зүй .....	8
I.8.3. Байгаль цаг уур.....	8
I.8.4. Зам харилцаа, дэд бүтэц .....	9
<b>БҮЛЭГ II. ОРДЫН ГЕОЛОГИ, АШИГТ МАЛТМАЛ</b> .....	<b>9</b>
II.1. Геологийн судалгааны түүх.....	9
II.3. Гүний чулуулаг .....	12
II.4. Тектоник .....	14
II.5. Ордын гидрогеологи .....	15
II.6. Ашигт малтмал .....	16
II.7. Хайгуулын ажлын аргачлал ба гүйцэтгэсэн ажлын хэмжээ.....	16
II.8. Ордын технологийн туршилт, шинж чанар .....	18
II.9. Алтны сорьц тогтоох шинжилгээ .....	19
II.10. Ордын нөөцийн тооцоо.....	19
<b>БҮЛЭГ III. УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ, ХҮЧИН ЧАДАЛ</b> .....	<b>21</b>
III.1. Ордын уул техникийн нөхцөл.....	21
III.2. Ашиглалтын технологи, механикжуулалтын бүтэц .....	22
III.3. Ил уурхайн хажуугийн тогтворжилт, ашиглалтын системийн параметрууд.....	23
III.4. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо .....	26
III.5. Ил уурхайн ашиглалт, уулын ажлын төлөвлөлт .....	29
III.5.1. Уурхайн ажиллах горим .....	31
III.5.2. Ил уурхайн нээлт.....	32
III.5.3. Ил уурхайн уулын ажлын төлөвлөлт.....	33
III.5.4. Уулын ажлын зохион байгуулалт .....	33
III.6. Үндсэн процесст ашиглах техник, тоног төхөөрөмж.....	36
III.6.1. Ухаж-ачих процесс.....	36
III.6.2. Хөрс хуулалт, элс олборлолтын ажил .....	37
III.6.3. Уурхайн тээвэр .....	40
III.6.4. Овоолгын ажил.....	42
III.6.5. Элс овоолох (агуулахын) ажил .....	44
III.6.6. Хаягдлын сан /Тунах болон цэвэр нуур байгуулах ажил/ .....	46
<b>БҮЛЭГ IV. БАЯЖУУЛАЛТЫН ТЕХНОЛОГИ</b> .....	<b>46</b>
IV.1. Ордын элсийг угаан баяжуулсан технологийн туршилт.....	46
IV.1.1. Бодисын найрлагын судалгааны дүгнэлт.....	46
IV.1.2. Алт агуулсан элсний угаагдах шинж чанар.....	47
IV.1.3. Алт агуулсан элсийг баяжуулсан технологийн туршилтын үр дүн .....	47
IV.2. Баяжуулах технологийн сонголт, үндэслэл.....	50
IV.2.1. Угаан баяжуулах элсний тооцоо ба хүчин чадал .....	50



IV.2.2. Технологийн горим .....	50
IV.2.3. Технологийн тооцоо .....	51
IV.2.4. Тоо-чанарын тооцоо.....	52
IV.2.5. Ус-булингын тооцоо .....	56
IV.3. Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөлт.....	60
IV.4. Хаягдал гаргалтын тооцоо .....	61
IV.5. Баяжуулах хэсгийн тоног төхөөрөмжийн сонголт, тооцоо .....	61
IV.6. Хаягдлын сан.....	66
<b>БҮЛЭГ V. ДЭД БҮТЭЦ.....</b>	<b>67</b>
V.1.1. Уурхайн тосгон.....	67
V.1.3. ШТМ-ийн агуулах .....	68
V.2. Холбоо дохиолол.....	68
V.3. Зам харилцаа.....	68
V.4. Цахилгаан хангамж.....	68
V.4.1. Уурхай, баяжуулах хэсэг, захиргааны цахилгаан хэрэглэгчид .....	68
V.4.2. Аянгаас хамгаалах байгууламж .....	70
V.5. Усан хангамж, усны хэрэглээ, төлбөр.....	71
V.6. Дулаан хангамж.....	71
<b>БҮЛЭГ VI. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ .....</b>	<b>72</b>
VI.1. Удирдлага, зохион байгуулалт .....	72
VI.2. Ажиллах хүчин, хүний нөөц .....	72
<b>БҮЛЭГ VII. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ .....</b>	<b>74</b>
VII.1. Хөдөлмөрийн аюулгүй байдлын арга хэмжээ.....	74
VII.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зааварчилгаа.....	76
VII.3. Аваар ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	77
VII.4. Ил уурхайн аюулгүй ажиллагаа .....	78
VII.5. Элс угаан баяжуулах хэсгийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй .....	79
VII.5.1. Угаан баяжуулах цехийн аюулгүй ажиллагаа:.....	81
VII.5.2. Галын аюулгүй ажиллагаа .....	81
VII.6. Цахилгааны аюулгүй ажиллагаа .....	81
VII.7. Усан хангамжийн аюулгүй ажиллагаа .....	82
VII.8. Ажилчдын нийгмийн асуудал, эрүүл мэндийг сахин хамгаалах .....	82
VII.9. ХАБЭА хууль эрх зүйн орчин .....	84
VII.10. Аюулын үед хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх төлөвлөгөө .....	85
VII.11. Хамгаалах хэрэгсэл .....	87
VII.12. Үзлэг оношилгоо, сургалтын зардал .....	88
VII.13. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийт зардал .....	88
VII.14. Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага .....	89
<b>БҮЛЭГ VIII. БАЙГАЛЬ ОРЧИН .....</b>	<b>90</b>
VIII.1. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгүүд.....	90
VIII.2. Байгаль орчныг хамгаалах удирдлагын тогтолцоо .....	90
VIII.3. Байгаль орчныг хамгаалах хууль эрх зүйн орчин .....	92
VIII.4. Түүх соёлын дурсгалт зүйлс.....	94
VIII.5. Нөхөн сэргээлтийн бодлого .....	95
VIII.6. Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ .....	95
VIII.7. Хог хаягдлын хяналт, удирдлага, зохион байгуулалт .....	96
VIII.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	96
VIII.9. Нөхөн сэргээлтийн ажил .....	96
VIII.9.2. Биологийн нөхөн сэргээлт .....	99
VIII.9.3. Ургамалжуулалт хийсэн талбайг арчилж хамгаалах.....	99
VIII.10. Байгаль орчин хамгаалах зардал.....	99
VIII.11. Төслийн хаалтын бодлого .....	100
VIII.11.1. Төслийн хаалтын зардал .....	100

VIII.11.2. Мониторингийн зардал.....	101
<b>IX БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХЭСЭГ</b> .....	102
IX.1. Хөрөнгө оруулалт.....	102
IX.1.2. Элэгдлийн зардал.....	104
IX.2. Ашиглалтын зардлын тооцоо.....	105
IX.2.1. Цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэл, ХАОАТ.....	105
IX.2.2. Дизель түлш, тос маслын зардал.....	106
IX.2.3. Сэлбэг хэрэгслийн зардал.....	107
IX.2.4. Ус ашиглалтын зардал.....	108
IX.2.4. Ашиглалтын зардал.....	109
IX.2.5. Улс, орон нутгийн татвар, төлбөр, шимтгэл.....	109
IX.2.6. Удирдлага, аж ахуйн зардал.....	111
IX.2.7. Байгаль орчин хамгаалах болон уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн зардал.....	111
IX.2.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийт зардал.....	113
IX.2.9. Бүтээгдэхүүний өөрийн болон бүрэн өөрийн өртөг.....	114
IX.3. Алтны зах зээлийн судалгаа.....	114
IX.4. Үр ашгийн тооцоо.....	119
IX.5. Мэдрэмжийн шинжилгээ.....	120
<b>ДҮГНЭЛТ</b> .....	123
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ</b> .....	124

### ХҮСНЭГТ

<i>Хүснэгт 1. Техник-эдийн засгийн үндэслэлийн мэдээлэл</i> .....	2
<i>Хүснэгт 2. Техник эдийн засгийн үндэслэлийн эдийн засгийн үзүүлэлтүүд</i> .....	3
<i>Хүснэгт 3. Ил уурхайн үйл ажиллагааны ажлын төлөвлөлт</i> .....	5
<i>Хүснэгт 4. Ашиглалтын талбайн цэгүүдийн солбилцол</i> .....	5
<i>Хүснэгт 5. Технологийн дээжийн ширхэг, мөхлөг</i> .....	18
<i>Хүснэгт 6. Технологийн дээжийн мөхлөг</i> .....	18
<i>Хүснэгт 7. Хуурай, Чулуут алтны шороон ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт</i> .....	20
<i>Хүснэгт 8. Уурхайн механикжуулалтын бүтэц</i> .....	23
<i>Хүснэгт 9. Доголын хажуугийн өнцөг (“Гипроруда”-гийн баримтлал)</i> .....	23
<i>Хүснэгт 10. Ил уурхайн хажуу ба доголудын налуугийн өнцгийн баримжаа хэмжээ (“Гипроруда”-гийн баримтлал)</i> .....	24
<i>Хүснэгт 11. Ашиглалтын системийн элементүүд</i> .....	25
<i>Хүснэгт 12. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо</i> .....	27
<i>Хүснэгт 13. Уурхайнуудыг ашиглах дараалал</i> .....	30
<i>Хүснэгт 14. Ашиглалтын жилийн уулын ажлын хэмжээ, төлөвлөлт</i> .....	31
<i>Хүснэгт 15. Ажлын горим</i> .....	32
<i>Хүснэгт 16. Хуулах шимт хөрс хуулах талбайн хэмжээ ашиглалтын жилд</i> .....	34
<i>Хүснэгт 17. Овоолгын төлөвлөлт</i> .....	34
<i>Хүснэгт 18. Уурхайд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмжүүд</i> .....	36
<i>Хүснэгт 19. Хөрс хуулалт ажиллах Doosan DX520LC экскаваторын</i> .....	38
<i>Хүснэгт 20. Элс олборлолтонд ажиллах Doosan DX300 экскаваторын</i> .....	39
<i>Хүснэгт 21. Хөрс хуулалт, элс олборлолтод ажиллах экскаваторуудын</i> .....	39
<i>Хүснэгт 22. Howo 371 маркийн автосамосвалын техникийн үзүүлэлт</i> .....	40
<i>Хүснэгт 23. Автосамосвалын бүтээл, ажиллах мото цагийн үзүүлэлт</i> .....	41
<i>Хүснэгт 24. Овоолгын төлөвлөлт</i> .....	43
<i>Хүснэгт 25. SD-32 Shantui маркийн бульдозерийн техникийн үзүүлэлт</i> .....	43
<i>Хүснэгт 26. Шимт хөрс хуулах, овоолго дээр ажиллах бульдозерийн бүтээлийн тооцоо</i> .....	44
<i>Хүснэгт 27. Баяжуулах хэсэгт Luigong 856H ажиллах утгуурт ачигчийн үзүүлэлт</i> .....	45
<i>Хүснэгт 28. Luigong 856H маркийн утгуурт ачигчийн бүтээлийн тооцоо</i> .....	45
<i>Хүснэгт 29. Нийт мот.цагийн тооцоо</i> .....	46

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024

Хүснэгт 30. Элсний сорьцын угаагдах шинж чанарын үзүүлэлтүүд	47
Хүснэгт 31. Алт агуулсан анхдагч дээжийг шлюз болон сэгсрэх ширээгээр баяжуулсан туршилтын үр дүн	49
Хүснэгт 32. Баяжуулах хэсгийн ажлын горим	52
Хүснэгт 33. Ашиглалтын жилийн тоо-чанарын тооцооны үр дүн	55
Хүснэгт 34. Ашиглалтын жилийн ус шламын нэгдсэн хүснэгт	58
Хүснэгт 35. Ашиглалтын жилийн усны балансын тооцоо	59
Хүснэгт 36. Угаан баяжуулалтанд хэрэглэгдэх усны зарцуулалт	59
Хүснэгт 37. Элс баяжуулахад шаардагдах усны хэмжээ	60
Хүснэгт 38. Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө	60
Хүснэгт 39. Элсийг угаан байжуулах үйлдвэрийн хаягдлын хэмжээ	61
Хүснэгт 40. Баяжуулах хэсгийн усны хэрэглээ	61
Хүснэгт 41. Хоригт цоргын ажиллын горим	62
Хүснэгт 42. Хоригт цоргын техникийн үзүүлэлт	63
Хүснэгт 43. Материалын ширхэглэлээс хамаарсан шлюзны тооцооны параметрууд	64
Хүснэгт 44. Нам дүүргэлтийн шлюзийн техникийн үзүүлэлт	64
Хүснэгт 45. Сэгсрэх ширээний техникийн үзүүлэлт	64
Хүснэгт 46. R150-ES-06 насосны техникийн үзүүлэлт	65
Хүснэгт 47. Эргэлтийн усны насосны техникийн үзүүлэлт	65
Хүснэгт 48. Баяжуулалтад ашиглах тоног төхөөрөмж	65
Хүснэгт 49. Уурхайн барилга, байгууламж	67
Хүснэгт 50. Цахилгаан хэрэглэгчдийн суурь болон тооцооны актив	69
Хүснэгт 51. Шаардагдах усны хэмжээ	71
Хүснэгт 52. 1 м3 ус ашигласны төлбөр	71
Хүснэгт 53. Ажилчдын орон тоо	73
Хүснэгт 54. Төслийн нийт ажилчдын тоо	73
Хүснэгт 55. ХАБЭА -тай холбоотой стандартууд	84
Хүснэгт 56. Нэг ажилтны ХАБЭА-ны хувцас, төг/жил	88
Хүснэгт 57. ХАБЭА-н нийт зардал, /сая.төг/	89
Хүснэгт 58. Байгаль орчныг хамгаалах МУ-ын хууль, тогтоомжууд	92
Хүснэгт 59. Байгаль орчныг нөхөн сэргээх стандартууд	93
Хүснэгт 60. Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, зардал	98
Хүснэгт 61. Байгаль орчин хамгаалах зардал	100
Хүснэгт 62. Хөрөнгө оруулалт	103
Хүснэгт 63. Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэл, сая төгрөгөөр	105
Хүснэгт 64. Орон тоо, цалингийн тооцоо	105
Хүснэгт 65. Төслийн ажиллах хүчин	106
Хүснэгт 66. Төслийн ажиллах хүчний цалингийн зардал, сая төгрөгөөр	106
Хүснэгт 67. Төслийн ажиллах хүчний НДШ-ийн зардал, сая төгрөгөөр	106
Хүснэгт 68. Төслийн ажиллах хүчний ХАОАТ-ын зардал, сая төгрөгөөр	106
Хүснэгт 69. Тоног төхөөрөмжийн ажиллах хугацаа	107
Хүснэгт 70. Түлш зарцуулалт, мян.л	107
Хүснэгт 71. Шатах, тослох материалын зардал, сая төгрөгөөр	107
Хүснэгт 72. Сэлбэгийн зардал, сая төгрөгөөр	108
Хүснэгт 73. Дугуй болон бусад зардал, сая төгрөгөөр	108
Хүснэгт 74. Үйлдвэрийн усны хэрэглээ	108
Хүснэгт 75. Үйлдвэрийн усны зардал, сая төгрөгөөр	108
Хүснэгт 76. Ил уурхайн ашиглалтын зардал	109
Хүснэгт 77. Баяжуулах хэсгийн зардал	109
Хүснэгт 78. Төсөвт төлөх татвар төлбөр, шимтгэлүүд, сая төгрөгөөр	110
Хүснэгт 79. Аж ахуйн зардал, сая төгрөгөөр	111
Хүснэгт 80. Захиргаа, аж ахуйн зардал, сая төгрөгөөр	111
Хүснэгт 81. Байгаль орчныг хамгаалах зардал, сая төгрөгөөр	112

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024



Хүснэгт 82. Нүүлгэн шилжүүлэх зардал, сая төгрөгөөр	112
Хүснэгт 83. Ажилгүйдлийн тэтгэмж, мян.төгрөгөөр	112
Хүснэгт 84. Байгаль орчин хамгаалах болон уурхайн хаалт,	113
Хүснэгт 85. ХАБЭА-н нийт зардал, сая төгрөгөөр	113
Хүснэгт 86. Бүтээгдэхүүний өөрийн болон бүрэн өөрийн өртөг	114
Хүснэгт 87. Бүтээгдэхүүн гаргалт, борлуулалт	120
Хүснэгт 88. Үр ашигийн тооцоо	120
Хүснэгт 89. Төслийн мэдрэмжийн шинжилгээний үзүүлэлтүүд	121
Хүснэгт 90. Өнөөгийн цэвэр ашиг, NPV-ийн өөрчлөлт	121
Хүснэгт 91. Дотоод өгөөжийн нормийн өөрчлөлт /IRR/	122

### ЗУРАГ

Зураг 1. Ордын байршлын ерөнхий зураг	8
Зураг 2. Уурхай хоёр доголоор гүнзгийрэх үеийн уурхайн хажуугийн хананы дизайн	25
Зураг 3. Ордын элсний давхаргын 3D загварчлал	29
Зураг 4. Уулын ажлын төлөвлөлт	31
Зураг 5. Тусгай зөврөөлийн хил	35
Зураг 6. Ил уурхайн дизайн	35
Зураг 7. Уурхайн эцсийн байдал /нөхөн дүүргэлт хийснээр/	36
Зураг 8. Дээжийг илюз болон сэгсрэх ширээгээр баяжуулах	49
Зураг 9. Захиалагчид санал болгож буй схем	50
Зураг 10. Элс угаан баяжуулах технологийн схем	51
Зураг 11. Элс баяжуулах технологийн ус-шлагын схем	57
Зураг 12. Баяжуулах технологийн тоног төхөөрөмжийн холболтын схем	62
Зураг 13. Скруббер-бутара СБ80 маркийн баяжуулах төхөөрөмж	62
Зураг 14. Сэлбэг, материалын агуулах	67
Зураг 15. Удирдлага, зохион байгуулалтын схем	72
Зураг 16. Хөрөнгө оруулалтын эзлэх хувь	104
Зураг 17. Мэдрэмжийн шинжилгээ /Өнөөгийн үнэ цэнэ NPV/	122
Зураг 18. Мэдрэмжийн шинжилгээ /Дотоод өгөөжийн норм IRR/	122

### ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Байгууллагын тусгай зөвшөөрөл
3. Нөөц бүртгэх тухай ҮГ газрын даргын тушаал
4. Ордын хайгуулын ажлын үр дүнг хэлэлцсэн тухай Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт
5. ТЭЗҮ даргын тушаал
6. ТЭЗҮ хэлэлцсэн тухай Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт

## ОРШИЛ

Оюут цахир уул ХХК нь 2021 оноос уул уурхай, гадаад, дотоод уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдааны үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд оноос 2021-2022 оны хооронд Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугам хооронд 2022-2023 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр хийж гүйцэтгэсэн нөөцөд тулгуурлан ТЭЗҮ боловсруулан, 2024 оноос тус алтны шороон ордод үйл ажиллагаа явуулахаар ажиллаж байна

ЭБЭХ-ний сайдын 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 74 тоот тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан.

- Уурхайн загварыг техник, тоног төхөөрөмжийн тооцоонд тулгуурлан уурхайн элс олборлох хүчин чадлыг 80.8 мян.м<sup>3</sup>/жил байх ба уулын ажлыг 1 жил ил уурхайн аргаар олборлохоор тооцсон.
- Техник, тоног төхөөрөмж, нөөц, олборлолтын хэмжээтэй уялдуулан эдийн засгийн тооцоог хийсэн.

Тус уурхай нь ашиглалтын жилд нийт 80.8 мян.м<sup>3</sup> элс олборлон, 40.6 кг алт химийн цэврээр борлуулах ба хөрөнгө оруулалтаа 3.6 сарын дотор нөхөж шинээр 82 ажлын байр бий болох юм. Нийт улс, орон нутгийн төсөвт 1694.43 сая төгрөгийн татвар, хураамж, төлбөр төлөхөөр тооцоолоод байна.

**ТОДОРХОЙЛОЛТ****Хүснэгт 1. Техник-эдийн засгийн үндэслэлийн мэдээлэл**

Үзүүлэлт	Тодорхойлолт
<i>Ерөнхий мэдээлэл</i>	
Аж ахуйн нэгжийн нэр	Оюут цахир уул ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011822879
Уурхайн байршил	Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Их хуурайн орд нь Улаанбаатар хотоос хойш 250 км-т Дархан-Уул аймгаас 60 км, Шарын гол сумын төвөөс зүүн тийш 15 км-т байдаг.
Уурхайн нэр	Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордын ил уурхай
Төслийн үндэслэл	Алтны шороон ордыг ил аргаар ашиглан алтыг олборлон, борлуулах
Ил уурхайн хүчин хүчин чадал	Төслийн хүчин чадлаар Их хуурайн алтны шороон орд нь жилд 80.8 мян.м <sup>3</sup> элс олборлон, баяжуулж химийн цэврээр 40.62 кг алт гарган авч борлуулна.
Ил уурхайн технологи	Экскаватор-автосамосвалын хослол бүхий автотээвэртэй дотоод овоолготой ашиглалтын систем
Төслийн зорилт, үр дүн	82 хүнийг ажлын байраар ханган, тэдгээрийн өрхийн орлого, амьжиргааны түвшинг сайжруулах,
Алтны агуулга, гарц, %	Ашиглалтын жилд 593 мг/м <sup>3</sup> -ын дундаж агуулгатай, химийн цэврээр 43.9 кг алт олборлон, 92.6% металл авалттай, химийн цэврээр 40.62 кг алт баяжуулан авч, борлуулна.
Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд	- Doosan DX-520 маркийн экскаватор - Doosan DX-300 маркийн экскаватор - HOWO-371 маркийн автосамосвал - SD-32 маркийн бульдозер
Баяжуулах цехийн үндсэн тоног төхөөрөмжүүд	- 865Н маркийн утгуурт ачигч - Скруббер-бутара СБ 80 иж бүрдэл - Д-250 технологийн ус тэжээх насос - ЭЦВ12-250-105 Эргэлтийн усны насос

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024



**Хүснэгт 2. Техник эдийн засгийн үндэслэлийн эдийн засгийн үзүүлэлтүүд**

Д.д	Үзүүлэлт	Нэгж	Үзүүлэлтүүд
1	Ордын геологийн нөөц (B+C), химийн цэврээр	кг	43.9
2	Үйлдвэрлэлийн нөөц	кг	43.9
3	Төслийн хугацааны нийт хөрс хуулалт	мян.м <sup>3</sup>	563.8
4	Төслийн хугацааны элс олборлолт	мян.м <sup>3</sup>	80.8
5	Хөрс хуулалтын дундаж коэффициент	м <sup>3</sup> / м <sup>3</sup>	7.0
<b>Уул – тээврийн үндсэн техник, тоног төхөөрөмж</b>			
6	Doosan DX-520 маркийн эксковатор	ш	1
	Doosan DX-300 маркийн эксковатор		1
7	Автосамосвал: HOWO-371 маркийн автосамосвал	ш	4
8	Бульдозер: SD-32	ш	1
<b>Баяжуулах хэсгийн тоног төхөөрөмж</b>			
	Утгуурт ачигч: LUIGONG 865H		1
	Скруббер-бутара СБ 80		1
	СКО-1		1
	IS200-150-250 технологийн ус тэжээх насос		2
	ЭЦВ12-250-105 Эргэлтийн усны насос		2
10	<b>Нийт хөрөнгө оруулалт</b>	<b>сая.төг</b>	<b>2,050.9</b>
11	Барилга байгууламж, дэд бүтэц	сая.төг	260.6
	Ажиллах горим:		
	Жилд ажиллах боломжит хоногийн тоо	хоног	180
14	- Ээлжийн тоо	ээлж	2
	- Ээлжийн үргэжлэх хугацаа	цаг	12
15	Ашиглалтын систем: автотээвэртэй, дотоод овоолготой ашиглалтын систем	-	-
16	Ажиллагсдын тоо:	хүн	82
17	- Ажиллагсдын дундаж цалин	мян.төг	4,207.32
18	Жилийн нийт зардал	сая.төг	6,097.26
19	1м <sup>3</sup> элс олборлох өөрийн өртөг	Төг	37,542.69
20	1м <sup>3</sup> уулын цулын өөрийн өртөг	Төг	4,707.84
21	1м <sup>3</sup> элс баяжуулах өөрийн өртөг	Төг	5,295.91
22	1гр алт гаргах бүрэн өөрийн өртөг	Төг	150,100
23	Өгөөжийн дотоод норм IRR	%	81
24	Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа	сар	3.6

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024

## БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### I.1. Төслийн зорилго

Оюут цахир уул ХХК нь өөрийн эзэмшлийн MV-022627 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглалтын үйл ажиллагаа эхлүүлэхээр техник-эдийн засгийн үндэслэл боловсруулан, хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

### I.2. Төсөл хэрэгжүүлэх эрх зүйн орчин

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын баримт бичгийн 1.2 дах заалтад “Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт техник, технологи, инновацыг дэмжих замаар ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэх” гэж заасан байна.

#### I.2.1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Оюут цахир уул ХХК нь Монгол улсын 9011822879 тоот улсын бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээ, MV-022627 ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй бүхий тус тус компани нь 2020 оноос гадаад, дотоод худалдааны үйл ажиллагаа эрхэлж байгаад 2021 оноос геологи, хайгуул, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. 2023 оноос Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт Их хуурайн алтны шороон ордод үйл ажиллагаа явуулахаар ажиллаж байна.

### I.3. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглаж, элсийг угаан баяжуулах хэсгийн зураг болон ажилчдын байрны талбай, хаягдалын сангийн зураг болон дэд бүтцийн ажлын зохион байгуулалтыг хийнэ.

Уурхай болон угаан баяжуулах хэсэгт төсөл хэрэгжүүлэгч компани техник, тоног-төхөөрөмжүүдийг худалдан авч ажиллуулах юм.

Оюут цахир уул ХХК-ийн ордын ил аргаар ашиглах төсөл нь дараах үе шатуудаас бүрдэнэ.

#### 1. Бэлтгэл шат

- Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах,
- Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ ,
- Техник, тоног-төхөөрөмжийг худалдан авах,

#### 2. Барилга байгууламж болон тоног төхөөрөмжийн угсралт,

- Дэд бүтэц, барилга байгууламж, газар шорооны ажил эхэлнэ.
- Эрчим хүчний дэд станцын сүлжээний холболт,
- Техник, тоног-төхөөрөмжийн угсралтын ажлыг хийх,

#### 3. Уурхайн ажил

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024

- Уурхайн нээлт
- Хөрс хуулалт, элс олборлолт.
- Угаан баяжуулах хэсгийн ажил тус тус явагдана.

### Хүснэгт 3. Ил уурхайн үйл ажиллагааны ажлын төлөвлөлт

№	Ажлын нэр	Сарууд							
		4/1	4/10	5/1	5/5	5/10	7/25	8/25	10/15
1	Дэд бүтэц, барилга байгууламж, газар шороо, зам засах ажил хийгдэнэ								
	Эрчим хүч, холбоо, дохиоллын угсралт, суурилуулалт								
2	Тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах								
3	Уулын бэлтгэл ажил хийх								
4	Уурхайг нээж, хөрс хуулалтын ажлыг эхлүүлнэ								
5	Хөрс хуулалт, элс олборлолт								
6	Хаягдлын сан барих								
7	Цэвэр болон эргэлтийн усны тоног төхөөрөмжүүдийг суурилуулж, усан хангамжийн сүлжээг байгуулах								
8	Баяжуулах ажил								

#### I.4. Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Ашигт Малтмал, Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газраас Оюут цахир уул ХХК-д Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Их хуурай нэртэй 465.49 га талбай бүхий ашигт малтмал ашиглах MV-022627 дугаар бүхий гэрчилгээг 2023 оны 10 сарын 12-ны өдөр олгосон.

#### Хүснэгт 4. Ашиглалтын талбайн цэгүүдийн солбилцол

№	Уртраг	Өргөрөг
1	106° 34' 45.58"	49° 15' 8.2"
2	106° 34' 39.13"	49° 15' 9.36"
3	106° 34' 31.62"	49° 15' 7.97"
4	106° 34' 31.59"	49° 15' 7.97"
5	106° 34' 31.59"	49° 15' 7.97"
6	106° 34' 25.27"	49° 15' 8.24"
7	106° 34' 25.27"	49° 13' 55"
8	106° 34' 30"	49° 13' 55"
9	106° 34' 30"	49° 13' 46.89"
10	106° 34' 31.23"	49° 13' 46.89"
11	106° 34' 31.23"	49° 13' 35.74"
12	106° 34' 43.23"	49° 13' 35.74"
13	106° 34' 43.23"	49° 13' 46.95"
14	106° 35' 2.23"	49° 13' 46.92"
15	106° 35' 2.23"	49° 13' 35.74"

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024



16	106° 36' 53.13"	49° 13' 35.74"
17	106° 36' 53.13"	49° 13' 51.92"
18	106° 36' 31.24"	49° 13' 51.92"
19	106° 36' 31.24"	49° 14' 21.84"
20	106° 36' 28.41"	49° 14' 22.5"
21	106° 36' 23.69"	49° 14' 21.86"
22	106° 36' 21.34"	49° 14' 21.32"
23	106° 36' 21.29"	49° 14' 20.46"
24	106° 36' 20.97"	49° 14' 14.85"
25	106° 36' 22.08"	49° 14' 6.41"
26	106° 36' 22.05"	49° 14' 6.42"
27	106° 36' 22.06"	49° 14' 6.41"
28	106° 36' 11.32"	49° 14' 11.6"
29	106° 36' 5.77"	49° 14' 12.75"
30	106° 35' 58.78"	49° 14' 14.74"
31	106° 35' 58.6"	49° 14' 14.78"
32	106° 35' 55.65"	49° 14' 14.4"
33	106° 35' 55.64"	49° 14' 14.4"
34	106° 35' 55.62"	49° 14' 14.4"
35	106° 35' 51.05"	49° 14' 15.32"
36	106° 35' 48.13"	49° 14' 17.09"
37	106° 35' 46.26"	49° 14' 19.7"
38	106° 35' 40.17"	49° 14' 24.96"
39	106° 35' 37.91"	49° 14' 26.04"
40	106° 35' 31.42"	49° 14' 29.16"
41	106° 35' 26.27"	49° 14' 29.95"
42	106° 35' 23.57"	49° 14' 30.36"
43	106° 35' 16.04"	49° 14' 31.74"
44	106° 35' 9.88"	49° 14' 34.63"
45	106° 35' 5.54"	49° 14' 36.92"
46	106° 35' 1.47"	49° 14' 39.06"
47	106° 34' 59.93"	49° 14' 42.53"
48	106° 34' 59.71"	49° 14' 45.97"
49	106° 34' 58"	49° 14' 52.84"
50	106° 34' 56.8"	49° 14' 57.65"
51	106° 34' 52.42"	49° 15' 4.81"
52	106° 34' 47.11"	49° 15' 6.65"

**Ордын Төв цэгийн солбицол:** 106° 35' 35" 49° 14' 35"

### **I.5. Ордын нөөцийн баталгаажуулалт**

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордын 2022-2023 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр алтны нөөцийн тайланг боловсруулж, Эрдэс

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024

Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2023 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны ХХ-09-04 тоот дүгнэлт, Үндэсний геологийн албаны даргын 2023 оны 08-р сарын 28-ны өдрийн н/63 тоот тушаалаар тухайн ордын нөөцийг ашигт малтмалын улсын нөөцийн бүртгэлд бүртгэсэн байна. Ордын нөөцийг бодитой (В) зэрэглэлээр химийн цэврээр **13.77 кг**, боломжтой (С) зэрэглэлээр химийн цэврээр 30.09 кг, ордын хэмжээнд бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр химийн цэврээр **43.86 кг**-аар хүлээн авсан бөгөөд Этолл майнинг ХХК нь уг нөөцөд тулгуурлан ордыг ил уурхайгаар аргаар ашиглах ТЭЗҮ-ийг боловсруулсан.

### **I.6. Төслийн цар хүрээ**

Их хуурай алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл нь ил уурхай байгуулан хөрс хуулалт, элс олборлолт явуулах, олборлосон элсийг угаан баяжуулах үндсэн ажил, хөрсний гадаад, дотоод овоолго байгуулах, ашиглалтын эхэнд шимт хөрсийг хуулах, овоолон хадгалах, угаалгын хаягдлыг тунааж дахин ашиглах зэрэг туслах процессуудыг хэрэгжүүлэн ажиллаж, байгаль орчинг унаган төрхөнд дөхүүлэн нөхөн сэргээлт хийн ажиллах юм.

### **I.7. Төсөл судалгааны аргачилал**


Оюут цахир уул ХХК-ийн захиалгаар Их хуурай алтны шороон орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг Этолл майнинг ХХК-ийн инженерүүд Ашигт малтмалын газрын даргын 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 1/1455 тоот тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу боловсруулсан.

Төсөлд Монгол Улсад мөрдөж буй холбогдох хууль, аюулгүй ажиллагааны дүрмийн заалтууд, уул уурхайн практикт мөрдлөг болгодог төсөл зохиомжийн норм, норматив болон тус талбайд хийгдсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланд тулгуурлан уурхайн төслийн үндэслэл, тооцоонд хэрэглэдэг аналитик, график, графо-аналитик, загварчлал, оновчлол, программчлал, компьютерын зураглал, програмчилсан тооцооны аргуудыг хэрэглэсэн.

### **I.8. Төсөл хэрэгжих ордын товч тодорхойлолт**

#### ***I.8.1 Ордын байршил***

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордын талбай нь баруун зах Шарын голын нүүрсний уурхайн тосгоноос 15 км-т, Дархан хотоос 60 км-т, Улаанбаатар хотоос 250 км-т оршино. Шарын голын тосгон нь Улаанбаатар-Дарханы цардмал замтай сайжруулсан шороон замаар холбогддог.



*Зураг 1. Ордын байршлын ерөнхий зураг*

### **1.8.2. Физик газар зүй**

Уг талбай нь засаг захиргааны хувьд Дархан уул аймгийн Хонгор сумын нутагт харьяалагдах бөгөөд Шарын голын хөндийн дагуу байрлалтай ба Хуурайн алтны шороон ордын дунд хэсэгт байрлах үргэлжлэл юм.

**Уул зүйн** байрлалаараа Хангай-Хэнтийн их мужийн Хэнтийн уулархаг мужийн баруун хойд салбар болох дунд ба бэсрэг уулсын гадаргуу зонхилсон хэсэгт оршино. Тус талбайн хэмжээнд хамгийн өндөр өргөгдсөн цэг талбайн зүүн хойт захад орших Хар Ямаат уулын орой далайн түвшнээс дээш 1399.1 м-т, хамгийн нам дор газар Бурхант толгойн талбайн баруун хэсэгт 960 м-ийн өндөрт өргөгдсөн бөгөөд өндөржилтийн харьцангуй зөрүү нь 430-аад метр хүрнэ.

### **1.8.3. Байгаль цаг уур**

**Уур амьсгал:** Цаг уурын мужлалаар 2-р бүсийн (улсын ангиллаар) өвөл 1-р сард – 37хэм хүртэл хүйтэрч, зун 7-р сард +35 хүртэл дулаардаг, халуун хүйтний ихээхэн хэлбэлзэл бүхий эх газрын эрс тэс уур амьсгалтай нутагт багтана. Жилд унах хур тундасны дундаж хэмжээ 244 мм. Салхины чиг хойноос буюу баруун хойноос ихэвчлэн 3,5 м/сек хурдтай байна. Хаврын улиралд салхины хурд 18 м/сек хүртэл ширүүсч, шороон шуурга болдог. Газрын хөрс 10-р сарын эцэс хүртэл гэгсгэлэн байх ба энэ хугацаанд уулын ажил явуулах боломжтой. Хөрсний хөлдөлт 2,0 м хүрэх ба зарим голын хөндийд арал маягийн тархалттай олон жилийн цэвдэг тохиолдоно.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024

**Ус зүй:** Ус зүйн хувьд Орхон голын ай савд багтдаг, манай талбайн урдуур Шарын гол зүүн урдаас баруун хойш чигт урсан өнгөрдөг бөгөөд манай талбай нь шарын голын дагуу байрлалтай, усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн бүс нутагт тооцогддог.

#### **1.8.4. Зам харилцаа, дэд бүтэц**

Эдийн засаг, дэд бүтцийн хувьд манай орны эдийн засаг, зам харилцаа, дэд бүтцийн хөгжлөөрөө тэргүүлэх гол муж болох Дархан-Сэлэнгийн дүүрэгт багтах бөгөөд ялангуяа уул уурхайн олборлох үйлдвэр түлхүү хөгжсөн нутаг юм.

Талбайн баруун зах Шарын голын нүүрсний уурхайн тосгоноос 15 км-т, Дархан хотоос 60 км-т, Улаанбаатар хотоос 250 км-т оршино. Шарын голын тосгон нь Улаанбаатар-Дарханы цардмал замтай сайжруулсан шороон замаар холбогддог.

Улаанбаатар-Дархан-Шарын гол сумыг холбосон төмөр замтай ба төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон. Шарын гол суманд Мобикомын үүрэн телефон ашиглалтанд орсон бөгөөд манай судалгааны талбайд сүлжээтэй.

Жилийн аль ч улиралд ажлын талбайд 12 км хүртэл сайжруулсан шороон замаар хүрч очих бөгөөд алтны шороон орд ашиглаж буй олон уурхайнууд нь хоорондоо хол бус зайтай байрлана. Нутгийн оршин суугчид нь мал аж ахуй, газар тариалан эрхлэхээс гадна уул уурхайн олборлолтын үйлдвэрүүдэд ажилладаг.

Нүүрс ба алт олборлолт дагнасан уул уурхайн үйлдвэрүүд олон жил ажиллаж байгаа учир энэ чиглэлийн мэргэжил, дадлага туршлагатай ажиллах хүчний хангалттай нөөцтэй нутаг юм.

## **БҮЛЭГ II. ОРДЫН ГЕОЛОГИ, АШИГТ МАЛТМАЛ**

### **II.1. Геологийн судалгааны түүх**

Тус бүс нутгийн геологийн судалгааг өнгөрсөн зууны эхэнд, өөрөөр хэлбэл 1900-1919 онуудад “Монголор” нийгэмлэгийн ажиллагаагаар эхэлсэн гэж үздэг.

1940-өөд оны сүүлчээс геологийн маршрутын болон бага масштабтай талбайн судалгаанууд дэс дараатай хийгдэж эхэлсэн байна. Шербаков С.А /1946-1947/

1959-1960 онуудад Арсентьев Ю.М Ботезату В.А /1959-1960/ нар Шарын голын сав газарт 1: 500 000-ны масштабтай геологийн зураглалын ажил гүйцэтгэжээ.

1957-1959 онд А.В. Бурыблин, 1960-1961 онд И.Б. Полушик, В.А. Горохов нарын удирдан явуулсан 1: 200 000 масштабтай эрэл-зураглалын ажилд манай судалгааны талбай бүрэн хамрагдсан.

1961-1962 онд А.А.Кулеш, Б.Д. Ковалевский нар 1: 200 000 масштабтай эрэл-зураглалын ажил. Дээрх судалгаануудын үр дүнд тус бүс нутгийн давхаргазүйн анхны ангилал хийгдэн геологийн тогтоц, ашигт малтмалын байршилын зүй тогтлын талаархи цэгцтэй мэдээлэл бүрджээ

1968-1969 онд Ю.П. Цыпуков 1: 50 000-ны масштабтай эрэл зураглалын ажилууд гүйцэтгэсэн. Эдгээр судалгааны ажил явуулсаны үр дүнд уг районы геологийн тогтоц, ашигт малтмалын хэтийн төлвийн талаар анхны ангилал, мэдээллийг хийсэн байна.

Мөн үүнтэй зэрэгцээ нүүрс ба төмрийн хүдэр, барилгын материалын түүхий эдийн төрөлжсөн судалгаануудаар хэд хэдэн орд, илрэл нээн илрүүлж, хайгуул хийсний зарим нь одоо үйлдвэрлэлийн аргаар олборлогдож байна.



1973-1975 онуудад Т. Семейхан Хойт Хэнтийн алтны хүдрийн бүсийн хэмжээнд 1:500 000-ны металлогений судалгааны ажил явуулж, районы хэмжээнд хоёрдогч кварцит, пропилит зэрэг хувирлууд нь алтны хүдэржилттэй холбоотой, Орхон-Сэлэнгийн бүсэнд алт мөнгөний формацын бага гүний орд байж болно гэдэг дүгнэлт хийжээ.

1976-1978 онд В.Жамсранжав нар 1: 50 000 масштабтай зураглалын ажил явуулжээ. Уг судалгаагаар Дархан, Бууралтай, Ерөө голын свитийн хуудсуудыг Мандалын серид хамруулан нэгтгэсэн бөгөөд гүний чулуулгуудын цогцолборуудыг дотор нь фаз, фазад нарийвчлан хувааж, хими-геологи, найрлага зүйн судалгаа, шинжилгээгээр баталгаажуулалт хийсэн байна.

1984-1991 онуудад Шарын голын алтны хүдрийн зангилаанд алтны эрэл, хайгуулын ажил нилээд эрчимтэй хийгджээ.

Судалгааны талбайн хэмжээнд 1984-1991 онуудад Шарын голын алтны хүдрийн зангилаанд алтны эрэл, хайгуулын ажил нилээд эрчимтэй хийгджээ.

1984-1987 онд Д.Гунгааням, Ш.Чулуунбаатар нар Шарын голын сав газрын алтны үндсэн болон шороон илрэлүүдэд хийсэн нарийвчилсан эрэл, эрэл үнэлгээний ажлаар тус талбайд орших алтны шороон илрэлд С+Р зэрэглэлээр үнэлгээ өгсөн байдаг.

1986-1988 онуудад В. Довжид нарын судалгаагаар Шарын гол ба түүний цутгалуудад хийгдсэн алтны шороон ордын нарийвчилсан хайгуулын ажлын нөөцийн тооцоо.

1988-1992 онуудад У. Ганбаатар нар Хараа голын сав газрын дунд, Шарын голын сав газрын доод хэсэгт 1988-1991 онуудад явуулсан алтны шороон илрэлүүдэн эрлийн ажлын үр дүнгийн тайлан. “Эрдэс” ХК.

1990-ээд оны үед Г.Дэжидмаа нар Хойд Хэнтийн алтны хүдрийн бүсийн хэмжээнд металлогений судалгаа явуулж, урьд хийгдсэн бүх ажлын үр дүнг нэгтгэн алтжилтын зураг зохиожээ.

1994 онд П.Батчулуун нар Хойт Хэнтийн алтны хүдрийн бүсийн 1:200000-ны масштабтай геологийн зургуудыг шинэчлэн зохиосон байна.

1992-1993 онуудад Б. Батром нар 1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд манай талбай бүрэн хамрагдсан юм. Энэ ажлуудын үр дүнд тус дүүргийн геологийн тогтоц, ашигт малтмалын байршлын зүй тогтлын асуудал өнөөгийн түвшинд шийдэгдэж, хэтийн төлөвийн үнэлгээ өгөгдөн, цаашдын судалгааны үндсэн чиглэл тогтоогдсон байна.

Дээрхи геологи хайгуулын ажлын үр дүнгээр нээгдсэн Их Шарын гол, Бурхант, Их өвөлжөө, Хавчуу, Хүйтэн, Шаазгайт, Наран, Буянт гэх мэтийн олон орд газруудад алт олборлолтын үйлдвэрүүд ажиллаж байгаа ба зарим нь төгсгөлийнхөө шатанд явж байна.

Түүнчлэн 1990 оноос хойш “Алт” хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотойгоор Шарын голын бүсийн хэмжээнд алтны эрэл хайгуулын ажил эрчимтэй явагдах болсон бөгөөд судалгааны талбайн ойролцоо Бурхант, Шарын гол, Хуурай, Зоолуухар алтны шороон хуримтлалын ордууд тогтоогдож олборлолтын ажлыг явуулж байна. Энэ бүгд тус бүс нутгийн хувьд ирээдүйд уул уурхайн үйлдвэрлэл хөгжих хэтийн төлөвтэй болохыг харуулж байгаа юм.

Хуурай алтны шороон ордын дээд хэсэгт 2005 онд “Монголын гэгээ” ХХК хайгуулын ажлыг гүйцэтгэж, улмаар “Монгол газрын ховор элемент” ХХК олборлолтын ажлыг явуулж байна.

2022-2023 онуудад “Оюут цахир уул” ХХК-ийн геологич И.Гүррагчаа, У.Энхтайван, Э.Баярцэнгэл нар Хуурай, Чулуут алтны шороон ордын дунд хэсэгт хайгуулын ажил гүйцэтгэж нөөц тооцсон болно.

## **II.2. Дүүргийн геологийн тогтоц**

Монгол орны газарзүй-геологийн мужлалаар тус талбай нь Хэнтийн дүүрэг нутгийн геодинамикийн янз бүрийн нөхцөлд үүсч хуримтлагдсан хэд хэдэн насны тунамал хурдсаас гадна гүний бүрдлийн түрмэл ба судлын чулуулгууд тархсан, идэвхитэй тектоник үйл явцын нөлөөгөөр атриат болон тасралтат эвдрэлийн стрүктүрүүд эрчимтэй хөгжсөн геологийн тогтоцын хувьд нийлмэл хэсэг юм.

Дүүргийн хувьд дунд кембрийн-доод ордовикийн настай хараагийн сери гэж нэрлэгддэг тунамал-хувирмал хурдсын зузаалаг, дээд юра-доод цэрдийн том хэмхдэслэг тунамал ба дөрөвдөгчийн сэвсгэр хурдас, дунд хожуу ордовикийн настай баянголын бүрдлийн болон түрүү девоны гүний чулуулгууд тархсаныг нас болон гарал үүслийн төрлөөр нь дараахи байдлаар ангилан авч үзлээ.

### **II.2.1. Давхарга зүй**

#### ***Дунд кембрий-доод ордовик. Хараа формац ( $E_2-O_1hr$ )***

Хараа формацийн тунамал хувирмал чулуулаг Хойд Монголын атриат мужийн Хойд Хэнтийн захын өргөгдлийн хэмжээнд каледоны миогеосинклиналь хөгжлийн үеийн бүтэц-хэлбэршлийн бүсэнд үүсэн хөгжсөн байна.

Манай судалгааны талбайн хувьд энэ формацийн хурдас маш бага тархалттай бөгөөд талбайн баруун хойт хэсэгт зөвхөн жижиг үлдэц байдлаар тэмдэглэгдсэн. Энд хараагийн серийн доод давхаргын хурдас ногоон саарал, хааяа тод ногоон саарал, саарал өнгөтэй хавтаслаг, заримдаа цул томоос дунд ширхэгтэй, хээрийн жоншт граувакк элсжингээс зонхилон бүрдэнэ. Элсжингийн дотор шаварлаг болон цахиурлаг занар, филлит, метаалевролитын нимгэн үеүүд тохиолдоно. Тэдгээр нь ихэнх тохиолдолд Баянголын гүний интрузивийн үйлчлэлийн нөлөөгөөр хил заагийн метаморфизмд хүчтэй орж анхдагч шинж төрхөө алдан гялтгануурт ба талст занар, метаэлсжин, хоёрдогч кварцит, эвэржин, заримдаа мигматит болтол хувирсан байхаас гадна кварц-карбонатын хялгасан судлуудаар хэрчигдсэн байдаг.

Хараа формацийн чулуулгийн найрлага, хувирлын зэрэг, хурдас хуримтлалын онцлогийг Бууралтай формац ( $V-C_1$ )-тай жишихэд харьцангуй залуу төрхтэй тул түүний насны доод хязгаар нь доод кембрийгээс хойш байх болно. Тус талбайн хэмжээнд хараагийн сери нь зөвхөн Шарын гол формацийн ( $J_3-K_1sg$ ) молассаар хучигдсан байх боловч дунд-дээд ордовикийн настай Бороо гол бүрдлийн интрузивээр зүсэгдэн түүн дотор үлдэц байдлаар тохиолддог тул насны дээд хязгаарыг доод ордовик гэж үздэг.

Хараа формацийн хувирмал хурдастай алтны хүдэржилт гарал үүслийн хувьд холбоотой гэсэн таамгийг олонх эрдэмтэд дэвшүүлдэг бөгөөд тухайн талбайд ч ингэж үзэх үндэслэл бий. Уг хурдсын үлдэцүүд өргөн тархсан Хүйтний гол, Шарын голын эх, Хавчуугийн ам зэрэг газарт түүнтэй орон зайн холбоотой алтны олон тооны шороон ордууд нээгдэн олборлогдож байгаагаас гадна уг хурдаст тохиолдож байгаа цахирын судал, мэшилүүд болон гидротермаль-метасоматоз хувирлын бүсүүдээс авсан сорьцуудад хийгдсэн шинжилгээнд алт

байнга ямар нэг хэмжээгээр илэрдэг явдал энэ таамаглал үндэслэлтэй гэдгийг батлаж байгаа юм.

### ***Дээд юра-доод цэрд. Шарын гол формац (J<sub>2</sub>-K<sub>1</sub>sg)***

Шарын гол формацын тунамал хурдас тус талбайн баруун хойд буланд, Бурхантын хөндийн ойролцоо бага хэмжээтэйгээр илэрсэн бөгөөд энэ нь Шарын голын грабены урд захын хэсэг юм.

Энд хөрзөн, хайргажин, элжин, аргиллитаас бүрдсэн хучаас хурдас ихэнхдээ мөлгөрдүү гүвээ, толгод үүсгэсэн сул асгарга маягаар дайралдах бөгөөд газрын гадарга дээр хадан гарш тааралдахгүй. Энэ формац нь ерөнхийдөө Шарын голын хотгорыг дүүргэсэн жижиг нуур-голын гаралтай нарийн хэмнэлт үеллэг хурдсаас тогтох бөгөөд түүний доод хил нь тухайн үеийн гадаргууг хучин байрлах ба дээд хязгаар нь ямар нэгэн хурдсаар гүйцэд хучигдалгүйгээр ихэнх хэсэгтээ ул сууриа хүртэл угаагдалд орсон тул нийт зузааныг нь тогтоох боломж бага юм. Зэргэлдээ талбайн Бууртын ам зэрэг газруудад жижиг дэнж үүсгэсэн миоцений коллюви, пролювийн шаварлаг хурдсаар захлан хучигдаж, зарим хэсэгтээ орчин үеийн элюви, делювийн сэвсгэр хурдсаар дарагдсан нь тэнд хийгдсэн алтны шороон ордын хайгуулын малталт ба цооногуудад илэрч байжээ.

Шарын голын нүүрсний уурхайн орчимд тогтоогдсон харьцангуй бүрэн зүсэлтэнд нийт зузаан нь 800 м хүрдэг бөгөөд түүнийг өмнөх судлаачид литологийн бүтцээр нь 3 дэд формацд хуваажээ. Энэ нь Хойт Монголын нүүрс агуулсан ижил насны хурдсын зүсэлтүүдтэй бүрэн нийцдэг.

Өмнөх судалгаагаар Шарын гол формацын доод дэд формац ба доод цэрдийн хурдсны зарим үе давхарга алт агуулдаг нь тогтоогдсон бөгөөд тэдгээрийг хэрчиж үүссэн жижиг жалга, судгуудад алтны чөлөөт хуримтлал явагдаж, улмаар бага гүний, жижиг шороон ордууд үүссэн гэж үздэг. Шар хөтөл, Бурхантын хөндий, Хэрээт, Тарвагатай зэрэг амуудад үүссэн алтны хуримтлал үүнийг батлаж байна.

## **II.3. Гүний чулуулаг**

### **Дунд-дээд ордовикийн Бороо гол гүний бүрдэл (O<sub>2</sub>-3b)**

Хойд Хэнтийн дүүрэгт сүүлийн жилүүдэд хийгдсэн 1:50 000-ны масштабтай геологийн зураглал ба эрлийн ажлаар дунд-дээд ордовикийн настай интрузийг шинээр ялган бороо голын гүний бүрдэл хэмээн нэрлэжээ. Энэ бүрдлийн 2 фазын дарааллаар бүрэлдэн тогтсон том хэмжээтэй тарамцгийн хэсэг манай лицензийн талбайн урдуур хойгуур байрладаг.

Бороо голын гүний бүрдлийн **I фаз (v-vδ O<sub>2</sub>-3b)** нь үндсэндээ суурилаг ба дундлаг найрлагатай хоорондоо фацийн шилжилттэй габбро габбродиорит, диоритын эгнээний чулуулгаас бүрдэнэ. Тэдгээр нь хоорондоо фацийн хил заагтай, өөрөөр хэлбэл хэдэн метрийн өргөн шилжилтийн бүсүүд үүсгэнэ. Энэ фазын чулуулгууд ихэвчлэн дунд мөхлөгт шигтгээлэг бүтэцтэй байх ба габброгийн дотор том толболог хэлбэртэй эвэр хуурмагийн фенокристаллууд ажиглагддаг. Мөн залуу дэл судал, жижиг биетүүдээр зүсэгдэхдээ нилээд хүчтэй мигматитжилт ба гибриджилтэнд орж, зарим дэл судлын чулуулгууд нь өөрсдөө мигматитжилтанд өртсөн байдаг. Тус талбайд I фазын чулуулгийн биетүүд хараагийн серийн хувирмал чулуулгийг уран гарч, өөрөө II фазынхаа боржин ба түрүү девоны хүчиллэг маагмын биетүүдээр зүсэгдсэн байна.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024

**II фаз (γD<sub>2</sub> O<sub>2-3b</sub>)** нь боржиндиоритоос эхлэн плагиоборжин, лейкоборжин, шүлтлэгдүү боржинг дамжсан өргөн эгнээ үүсгэх бөгөөд гол төлөв шүлтлэгдүү найрлагатай, шигтгээлэг бүтэцтэй дунд-том талстлаг төрлүүдээс бүрддэг. Энэ нь бага, дунд гүний нөхцөлд үүссэнийг гэрчилж байгаа юм. II фазын чулуулгийн олон тооны жижиг штокууд эхний фазынхаа биетүүдийг урж, тэдгээрийн хил заагаар олон тооны апофизүүд үүсгэдэг ба фаз хоорондын хил үүсгэн, эхний фазын чулуулгаа гибриджүүлэн, цайваржуулж дахин хайлалтанд оруулсан ул мөрүүд бараг бүх тогтоогдсон хил заагууд дээр ажиглагддаг. Мөн хил орчимдоо төдийгүй дунд хэсэгтээ ч I габрролог чулуулгийн үлдэцүүдийг дотроо агуулдаг бөгөөд хил заагийн дотоод хэсэгтээ өөрөө мэдэгдэхүйц хэмжээгээр бараантсан байдаг. Харин хил заагийнхаа орчимд талжилтын байдалд нь онцын өөрчлөлт ажиглагддаггүй. Цөөн тохиолдолд эдгээр нь хоорондоо тектоник хил заагтай байна. II фазын боржинлог чулуулгууд нь химийн найрлагаараа шүлтлэг, хүчиллэг эгнээнд багтдагийг өмнөх судлаачид олон тооны шинжилгээгээр баталсан юм.

Бороо голын гүний бүрдлийн биетүүд хараагийн сери ба түүнээс өмнөх үүслийн хурдас чулуулгуудыг зүсч, хүчтэй эвэржилт болон бусад хувиралд орсон үлдцүүдийг агуулдаг. Үүнд тулгуурлан уг бүрдлийг доод ородовикоос хойш үүссэн гэж үздэг. Мөн энэ бүрдлийн чулуулгийн биетүүдийн угаагдлын гадаргуу нь доод карбоны тунамал хурдсаар хучигдан түүрүү девоны хүчиллэг маагмын биетүүдээр зүсэгдэж, өөрөө хүчтэй гибриджилт ба хил заагийн бусад хувиралд орж, дотроо түүний олон тооны дэл судлуудыг агуулсан байдаг нь насны дээд хязгаарыг тогтоох баримт болдог.

Харин уг бүрдлийн чулуулгийн үнэмлэхүй насыг тогтоосон баримт ховор юм. Бороо голын бүрдлийн чулуулгийн нэг онцлог нь динамометаморфизмтай зэрэгцээ эрчимтэй бутрал, катаклазжил ба милонитжих хувиралд өртсөн байдаг. Мөн түүнээс гадна энэ бүрдлийн чулуулгийн хараагийн серийн хурдсыг зүссэн гадаад, дотоод хил заагийн бүсэнд явагдсан идэвхитэй гидротермаль-метасоматит хувирлын шинж тэмдгүүд нь үнэт, өнгөт металлын хүдэржилт үүссэн байх боломжтой гэсэн дүгнэлтэнд хүргэж байгаа юм.

### **Дунд девоны интрузив (εγD<sub>2</sub>)**

Дунд девоны бүрдлийн гүний болон бэсрэг гүний чулуулгийн жижиг шток ба судлын биетүүд тус талбайд нилээд өргөн тархжээ.

Судаачид Тариат-Дарханы өргөгдөл ба Хойт Хэнтийн бүтэц-хэлбэршлийн бүсийн ороген хөгжлийн үе шат буюу девоны галвын эхэнд баянголын гүний хагарал идвэхжиж, түүнийг дагаж шүлтлэгдүү лейкоборжингийн олон тооны шток хэлбэрийн биетүүд болон судлууд үүссэн гэж үздэг. Энэ бүрдлийн **гол фаз (εγD<sub>2</sub>)** нь дунд мөхлөгт шүлтлэгдүү лейкоборжин, плагиоборжин, сулавтар гнейсжсэн жижиг мөхлөгт биотитот боржингоос бүрддэг.

Манай талбайн урд хэсэгт тод шараас улаан өнгөтэй, жигд бус мөхлөгт, шүлтлэгдүү боржингоос голлон тогтсон шток хэлбэрийн хэд хэдэн жижиг биет илэрчээ. Эдгээрээс хамгийн том нь Хар Ямаатын тарамцаг бөгөөд энэ нь ерөнхийдөө баянголын гүний хагарлыг дагаж зүүн хойшоо сунасан зууван хэлбэртэй, ихэнх хил нь тектоник хагарал дагасан шулуун, борооголын бүрдлийн гүний чулуулаг ба хараагийн серийн тунамал хурдасны үлдэгдэл биетийг зүссэн хэсэгтээ муруйж тахиралдсан байдаг. Хараагийн серийн хурдас ба бороо голын бүрдлийн чулуулгийг зүссэн хил зааг орчимдоо агуулагч чулуулгаа маш хүчтэй эвэршүүлж,



гнейсжүүлсэн байх ба гнейсжилтийн бүсийн өргөн 1,0 км хүрдэг. Хар Ямаатын тарамцгийн боржин нь дотоод хил заагтаа жижиг ширхэгтэй болж гнейсчлэгдэн, хувиралд орж өнгөт эрдсийн агуулга нь ихэссэн байх ба төв хэсэгт шүлтлэгдүү, жигд мөхлөгт лейкоборжин захаар нь дунд ширхэгтэй шигтгээлэг шүлтлэгдүү боржин зонхилдог. Энэ боржингууд нь бүгдээрээ ягаавтар, улаан ягаан, махан улаан өнгөтэй, шигтгээлэгдүү боржингийн кварц нь 3-7 мм хэмжээтэй дугуй мөхлөгүүдтэй бөгөөд цэхэр саарал, хар саарал өнгөтэй. Шигтгээлэг боржингууд нь 1 см хэмжээтэй калийн хээрийн жоншны (50%) призмлэг талстуудаас тогтдог. Ердийн дунд ширхэгтэй лейкоборжин нь ягаавтар өнгөтэй, калийн хээрийн жонш (30-35%), кварц (30-35%), олигоклаз (25% орчим), биотит ба эвэр хуурмаг (5-10%) тус тус агуулдаг.

Штокуудын цулын захаар ерөнхийдөө зүүн хойшоо суналтай лейко-боржингийн маш олон дэл судал тохиолдох бөгөөд алслагдах тусам цөөрдөг. Эдгээр нь ихэнх тохиолдолд шулуун бус тахиралдаж муруйсан хэлбэртэй байна. Дунд девоны бүрдлийн судлын серид жижиг ширхэгт боржин аплит, боржингийн магнаг, цахирын судлууд хамаарагддаг. Эдгээр нь гол фазынхаа болон баянголын бүрдлийн чулуулгуудыг зүсч, эгц шулуун хил зааг үүсгэдэг.

Судлуудын 80% нь боржингийн магнаг, 15% нь цахир, 5% нь боржин аплитаас тогтдог. Магнаг судлууд нь ихэвчлэн үндсэн фазынхаа боржин дотор, цахирын судлууд гадна нь ерөнхийдөө зүүн хойш сунасан байрлалтай тархжээ. Магнаг судлуудын өргөн 0,1-0,5 м, урт нь 1-1,5 м-ийн хооронд хэлбэлздэг ба зарим тохиолдолд боржин аплиттай фацийн шилжилттэй байдаг. Магнаг судлуудад исэлдсэн хоосон нүх их байх бөгөөд тэдгээр нь пирит болон цагаан тугалга, вольфрам, танталын эрдсүүдийн исэлдэлтээс үүссэн байдаг.

Цахирын судлууд талбайн зүүн урд хэсэгт, Хар ямаат уулын зүүн хажуугаар голлон тархсан ба 0,1-1,0 м өргөн, 1,5-1000 м урттай, ерөнхийдөө зүүн хойшоо сунаж тогтсон байна. Тэдгээрийн ихэнх нь сульфидүүд болон алт агуулсан байх бөгөөд агуулагч чулуулгууд нь цахиржих ба березитжих хувирлын 0,1-1,0 м өргөн бүс үүсгэдэг. Ер нь Шарын голын хүдрийн зангилаа ба судалгааны талбайн хэмжээнд энэ интрузийн жижиг биетүүд сульфидын эрдэсжилттэй нарийн судал, судал хэлбэрийн биетүүд агуулдаг бөгөөд тэдгээрт цахиржил, цайваршил ба сульфиджил зэрэг гидротермаль-метасоматит хувирлын шинж ажиглагддаг. Урьд нь пермийн настай гэдэг байсан энэ интрузийг 1:50 000-ны зураглал хийсэн геологчид (В. Жамсранжав, Б. Пүрэвсүрэн, Б. Батром нар) дунд-дээд девонд хамааруулсан юм. Тэгэхдээ дунд кембрий-доод ородовикийн хараагийн сери ба түүнээс өмнөх үүслийн бүх чулуулгуудыг зүсч, доод карбоны настай өрмөгтэйн давхаргадсаар хучигдан, перм-доод триасын гүний бүрдлийн шток, дэл судлуудаар зүсэгдсэн байдаг үндэслэлд тулгуурласан байна. Мөн энэ бүрдлийн чулуулгийн зүүн урд үргэлжлэл болох Хараа-Зуун модны риолитын биетийн үнэлэхүй насыг 195-350 сая жил гэж тодорхойлсон (А. Кампе) нь девоныг бүхэлд нь дээд силурын дээд хэсгийг хамарч байна.

Гэвч Хойт Монголын ариат мужид силурын настай интрузив одоогоор тогтоогдоогүй байгаа юм. Харин манай урд Ноён уулын талбайд 1:50 000-ны зураглал хийсэн геологч С.Төмөр риолитын фацийн чулуулаг нь дунд-дээд девоны фаун, флороор батлагдсан ажнайн формацын ул суурийн хөрзөнгөөр хучигдсаныг тогтоон, түүний насны дээд хязгаарыг дунд девоноос өмнөх үеийн гэж үзжээ. Бид дээрхи баримт, үндэслэлүүдэд тулгуурлан энэ интрузивийн насыг дунд девонд хамааруулсан юм.

#### **II.4. Тектоник**

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024

Судалгааны талбай нь Хойт Монголын атираат мужийн Хойд Хэнтийн өргөгдлийн баруун хойт захын хэсэгт байрлана. Энэ өргөгдөл нь зэргэлдээ байрлах Тариат-Дарханы өргөгдлөөс баянголын гүний хагарлаар зааглагддаг бөгөөд түрүү каледоны үед эх газрын царцдаст шилжиж геодинамик идэвхжлийн бүхий л үе шатыг дамжин хөгжиж иржээ. Тус талбайн хэмжээнд каледоны атриажлийн, мезозойн идэвхжлийн болон тавцангийн (платформын) структурийн бүрдлүүдэд хамаарах хурдас чулуулгууд илэрсэн байна. Каледоны структурийн бүрдлийг миогеосинклиналийн, инверс-орогены, хожуу ороген үеийн гэсэн, дараалсан 2 үеийг биеэ даасан нэг нэг бүтэц-хэлбэршлийн давхаргуудад авч үздэг байна.

## **II.5. Ордын гидрогеологи**

“Дэнж, Хуурай, Чулуут” алтны шороон орд нь гидрогеологийн мужлалаар Хангай-Хэнтийн гидрогеологийн мужийн Орхон голын сав газрын хэмжээнд түүний баруун гар талын цутгалуудын нэг болох Шарын голын сав газарт байрлана. Ордын талбай нь гидрогеологийн хувьд маш тааламжтай нөхцөлд оршино.

Хэнтийн нуруунаас эх авсан Шарын гол нь Хуурай алтны шороон ордын урд талаар урсдаг, тайван урсгалтай 0.5-0.8м/сек, гольдролын өргөн нь 5.0м, гүн нь 0.6-1.0м, мөн түүний баруун цутгал болох Хуурайгийн гол нь түр зуурийн урсгалтай ба судалгааны талбайн зүүн өмнөд хэсгийг дайран өнгөрдөг бөгөөд цас борооны үед урсац нь 0.5-2.0м/сек хүрдэг. Хуурайгийн голдээд эхэн хэсэгтээ байнгын урсгалтай ба дунд хэсэгтээ ирээд урсгал нь гүн руугаа шурган ордог ба манай тусгай зөвшөөрөлтэй талбайд байнгын урсгал байхгүй.

Ус нь цэнгэг эрдэсжилт нь 0.17-0.22г/л, хатуулаг нь 1.2-3.2 мг/экв, ундны ба техникийн усны шаардлагыг хангадаг. Иймд ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэгцээнд бүрэн ашиглах боломжтой юм. Ордын гидрогеологийн нөхцөл нь геоморфологийн онцлог, геологийн тогтоц, жилд унах тунадасны хэмжээнээс хамааралтай байдаг.

Хуурайгийн гол нь 12-р сарын дунд үеэс дараа оны 3-р сарын сүүлч хүртэл хагас хөлдөж 4-р сараас 12-р сар хүртэл тогтмол урсгалтай байдаг нь олборлолт явуулах цаг хугацааны таатай нөхцөл бүрдүүлнэ.

Гадаргын ус нь 1.5-2.0м-ийн гүнд татмын хэсэгт тогтмол шингэх байдлаар байх тул ямарч цаг хугацаанд ашиглах боломжтой бөгөөд бие даасан уст давхарга юм. Хайгуулын ажлын явцад уст давхаргын түвшингийн дээд хязгаарын хэмжээнүүдэд ажиглалт хийж тэмдэглэв. Энэ ажлын үр дүнд гадаргын уст давхаргын үе нь татмын хэсэгт биш зарим нэг шугамын захын малталтуудад 0.2-0.4м-ийн зузаанаас хэтрэхгүй бөгөөд орд нь голын тохойрсон хэсэгт байрлах ба голын хуучин гольдрол буюу меандр маягийн хэсэгт энэ нь ажиглагддаг. Ерөнхийдөө голын усны түвшин ашигт давхаргын байрлаж байгаа гүнээс дээш байх ба хайгуулын малталтын явцад дэнжийн хэсгүүдэд усны түвшин илрэхгүй байгаа нь тогтоогдсон.

Усны химийн найрлага нь гидрокарбонат, кальций-магнийн агуулгатай цэнгэг ус юм. Цэнгэг устай тул бүх зориулалтаар ашиглах боломжтой.

Хуурай алтны шороон ордыг ашиглах үед хөрсний ус багатай тул уурхайн машин, техник ажиллахад хүндрэл багатай гэж тооцож байна. Энэ нь уулын ажил гүйцэтгэхэд хүндрэл учруулж байгаа хэдий ч технологийн хэрэглээнд голоос авах усны хэмжээг багасгаж, хөрсний усыг зохих хэмжээгээр ашиглах нөхцөлтэйг харуулна.

Ордыг ашиглах үед шаардагдах технологийн болон ахуйн хэрэлээний усыг Хуурайгийн

хөндийд өмнөх олборлолтын үед үүссэн жижиг нуураас хангах бүрэн боломжтой, гидрогеологийн хувьд таатай нөхцөлд оршино.

### **II.6. Ашигт малтмал**

Хайгуулын тусгай зөвшөөрлийн Их хурай талбай нь Хойт Хэнтийн алтны хүдэржилтийн бүсийн Шарын голын алтны хүдрийн талбайн баруун өмнөд хэсэгт Хүйтэн-Шаргын голын алтны зурваст багтана. Энэ хүдрийн талбай нь Хойт Хэнтийн алтны хүдрийн бүсийн Орхон-Сэлэнгийн зэс-молибдений, Тариат-Дарханы төмрийн, Баян голын төмөр-никель-кобальтын хүдэржилтийн бүсүүдтэй хиллэж буй уулзвар газарт байрлана. Иймээс тус бүс нутагт явагдаж ирсэн геологийн судалгаануудын үр дүнд төрөл бүрийн металл ашигт малтмал болон алтны олон тооны орд илрэлүүд нээгдэн хайгуул хийгдсэний зарим нь ашиглагдаж байгаа ба ашиглалтанд бэлтгэгджээ.

### **II.7. Хайгуулын ажлын аргачлал ба гүйцэтгэсэн ажлын хэмжээ**

1992 онд Эрдэс ХК 400-800м х 20-40м торын нягтралтай хайгуулын ажлыг цохилтот өрөмдлөгөөр гүйцэтгэж, 673 мг/м<sup>3</sup> алтны агуулгатай шороон ордыг илрүүлэн нөөцийг C<sub>2</sub>+P<sub>1</sub> зэргээр 235.6кг /шлих/ гэж тогтоосон юм.

ОЮУТ ЦАХИР УУЛ ХХК XV-021736 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайд 2022-2023 онуудад 50-400 х 20-40 м-ийн торын нягтралтай хайгуулын ажлыг цохилтот өрөмдлөгөөр гүйцэтгэж, 10, 12, 14, 16, 20, 25, 26, 27, 27.5, 28, 28, 30, 32-р хайгуулын шугамуудыг өрөмдөж, 3.6-33.2 м гүнтэй 103 цооног 1286.6 т/м өрөмдлөгийн ажил гүйцэтгэж, Чулуут ам болон Хуурай ордод бага гүний /татмын/, дунд гүний /дэнжийн/ ордын нөөцийг тогтоосон юм.

#### **Хайгуулын ажлын аргачлал**

Хайгуулын ажилд дараахь аргуудыг хэрэглэсэн юм. Үүнд:

- Цохилтот өрөмдлөг /УКС-22М/
- Цооногийн сорьцлолт
- Топо геодезийн ажил
- Лабораторийн ажлууд
- Суурин боловсруулалт
- 

#### **Өрөмдлөгийн ажил**

Цохилтот өрөмдлөгийн ажлыг УКС-22М маркийн өрөмдлөгийн төхөөрөмжөөр 8-н дюмийн бэхэлгээний яндан хэрэглэн явуулсан. Нэвтрэлтийн ахицыг 0.4 м-ээр явуулж байсан.

Цооногийн ханыг муфтэн холбоо бүхий 219мм диаметр бүхий бэхэлгээний яндангаар бэхэлж өрөмдсөн бөгөөд усгүй хурдсанд өрөмдлөгийг явуулахдаа шлам үүсгэх зорилгоор цооног руу 10-20 л ус хийж байв. Нэвтрэлтийн гүнийг бэхэлгээний яндангийн суултаар хэмжсэн. Цүүцдэлтийг явуулахдаа ажлын троссон дээр хийсэн тэмдэглэгээг баримтлан дээжлэлтийн ахицыг тодорхойлсон ба өрөмдлөгийг бэхэлгээний янданг түрүүлүүлэх аргаар явуулж байлаа. Энэ нь алт агуулсан үе давхаргад өрөмдөх үед цооногт нуралт үүсч, дээж дэх алтны агуулгыг өндөрсгөх нөхцлийг таслан зогсоож, үнэн зөв мэдээлэл авахад сайн нөлөө

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024

үзүүлсэн. Устай үеүдэд хөөрөлт тогтоогдсон бөгөөд бэхэлгээний янданг 1.0 м хүртэл түрүүлүүлэн суулгаж өрөмдсөн. Цооногийг өрөмдөж дуусгасан эсэхийг ул суурийн чулуулаг дахь сүүлчийн 2-3 дээжийн угаалтын үр дүнд шлихийн алтны тэмдэгт илрэхгүй байгаагаар тодорхойлсон.

Өрөмдлөгийн ажлын чанарын шалгалтыг хийхдээ цооног болгонд желонкны ажиллагааг шалгаж, резинийг солих, цүүцний өргөний хэмжээнд байнгийн хяналт тавьж, хэмжилтээр цүүцний өргөн 1.0 см-ээс их элэгдсэн тохиолдолд гагнуур шавж зохих хэмжээнд хүргэх, мөн яндангийн дотоод диаметрээр тодорхойлсон дээжний онолын эзэлхүүн бодит эзэлхүүнтэйгээ тохирч байгаа эсэхийг шалгах замаар явуулав. Цооногийг өрөмдөх явцад угаагдсан материалын ахиц тус бүрээр дээжний цуглуулга хийсэн.

### ***Цооногийн сорьцлолт***

Өрөмдлөгийн цооногоос сорьцолтыг явуулахдаа Р-8Ж-4У маркийн желонк хэрэглэсэн. Бүх цооногийг бүрэн сорьцолсон бөгөөд ингэхдээ 0.2-0.4 м-ийн ахицаар явуулсан. Желонкдох үед желонкны бүлүүрийг 2-3 удаа явуулаад, гаргаж ирэн суллах хоолой руу оруулж үүний дор байрлах ендовка /зумп/-ын 2/3 хэсгийг дүүргэх бөгөөд шлам их үед хэд хэдэн зумпэнд сулласан. Желонкийг сулласны дараа түүнийг болон суллах хоолойг усаар угааж цэвэрлэж байв. Желонк хоосон гарч ирвэл сорьцолтын ахицыг желонкдож дууссан гэж үзсэн. Зумпэнд орсон ус, шлам тогтворжсон үед желонкдсон хурдсын хэмжээг хэмжин баримтжуулалтын дэвтэрт тэмдэглэж байсан ба энэ хэмжээ нь онолын хэмжигдэхүүнээс их зөрөөгүй бол дэвтэрт онолын хэмжигдэхүүнээр авсан. Сорьцолтын зайлалтыг гар аргаар зумпэнд гүйцэтгэж, баяжмалын угаалгыг тэвшээр хийж гүйцэтгэсэн. Цооног тус бүрт алттай давхаргыг угааж дууссаны дараа эфелийн хяналтын угаалга хийгдэж шалгалтын дэвтэрт үр дүнг тэмдэглэсэн. Желонкийн ажиллагааг болон угаалгыг зэс болон тугалган үрлээр цооног бүрт шалгаж байсан.

Сорьцын онолын эзэлхүүнийг башмакны гадаад диаметрт элэгдэл тооцсон голчоор тооцож, мөн жинхэнэ эзэлхүүн нь онолын эзэлхүүнээс бага байсан учраас нөөцийн тооцоог бодохдоо онолын эзэлхүүнээр алтны агуулгыг тооцсон. Дээжийн онолын эзэлхүүн 0.4 м-ийн ахилтын дээжлэлтэнд 0.016 м<sup>3</sup> байсан.

### ***Лабораторийн ажлууд***

Цооногоос авсан бүх дээжийг хээрийн нөхцөлд болон өөрийн лабораторид боловсруулсан. Хээрийн нөхцөлд хатаасан хар шлихийг үлээж алтыг ялган авч жигнэлтийг хийсэн.

Шлихийг боловсруулахдаа:

- Соронзон ялгалт хийх
- Хөнгөн фракцийг үлээж ялгах
- Алтыг жигнэх
- Жигнэсэн алтыг тусгай зориулалтын саванд хийж сейфэнд хадгалах
- Угаалгын журнал дээр жигнэлтийн үр дүнг буулгаж, нөөцийн тооцоонд орох үзүүлэлтийг тооцох гэсэн дарааллаар явуулсан.



Алтны жигнэлтийг өөрийн компанийн ВЛР-200 маркийн жин дээр хийсэн. Жигнэсэн алтыг тус бүрд нь цаасан дугтуйнд хийж дээр нь хайгуулын шугамын дугаар, уул өрмийн ажлын дугаар, сорьцын дугаар, ахиц, алтны тэмдэгтийн тоо, жинг тэмдэглэсэн.

Ордын хэмжээнд 1750 ширхэг дээж авч боловсруулсанаас 109 ширхэг нь алттай болох нь хээрийн нөхцөлд угаалга, үлээлгийн явцад тогтоогдсон.

#### Алттай дээжинд хийсэн хяналтын жигнэлт.

Хуурай, Чулуут алтны шороон ордод хайгуулын ажлыг хийн цохилтот өрөмдлөгийн аргаар хийх явцад 109 ширхэг алттай дээж авсан бөгөөд нийт алттай дээжнийхээ 85% буюу 93 ширхэг дээжинд гадаад хяналтын жигнэлтийг Ханлаб ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторийн жин дээр хийсэн.

#### II.8. Ордын технологийн туршилт, шинж чанар

Орд нь хүдрийн найрлага, технологийн шинж чанарын хувьд Хуурай чулуутын ордтой адил юм. Ордын алт агуулагч хурдас нь дунджаар 1.2 м зузаантай бөгөөд шаварлаг хольц 3% агуулна. Шаварлаг хольц нь лаборатори-технологийн туршилтаар усанд уусан задрах чанар сайтай болох нь тогтоогдсон. Хээрийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтаар алт агуулагч хурдасны ширхэг мөхлөгт хийсэн судалгаагаар 30-35% нь хайрга, дайрга, 65-70% нь; 5-10 см зузаантай шаврын жижиг үеүүд агуулсан элс, элсэнцэр эзэлдэг. Ордын хучаас хурдасны бүтэц бүрэлдэхүүнийг ширхэг мөхлөгийн хувьд судалсан байдлаас авч үзвэл 20 орчим хувь нь хайрга, дайрга, 80% шаварлаг элсэнцэрээс тогтоно. Орчин үеийн гольдролынхоо хэсэгт байршилтай илрэх алт бүхий давхарга нь уст давхаргынхаа доор байрлалтай байдаг. Хучдас хурдас болон алт агуулагч элсэнд хийсэн нягт сийрэгжилтийн итгэлцүүрийг 2 дээжинд тодорхойлсоноор хучдас хурдасанд 1, 2, элсэнд 1, 3 байв. Алтны ширхэг мөхлөгийн шигшүүрийн /торон/ судалгааг хүснэгт № 1-д, Хуурайгийн дунд хэсэгт хийсэн хайгуулын ажлын үед авсан алтанд; хүснэгт № 2-д “Монголын Гэгээ” ХХК-ний Хуурай чулуутын алтны шороон ордын дээд хэсгээс хайгуулын үед авсан технологийн дээжийн алтны ширхэг мөхлөгийн судалгааг тус тус харьцуулан үзүүлэв.

#### Хүснэгт 5. Технологийн дээжийн ширхэг, мөхлөг

Авсан газар	Хэмжих нэгж	Алтны мөхлөг ангилалаар /мм/					Бүгд
		-0.125	0.25+0.125	0.5+0.25	1.0+0.5	-2.0+1	
цооног	мгр	1.82	145.71	505.76	316.66	69.76	1039.71
	%	0.3	14.0	48.6	30.4	6.7	100

#### Хүснэгт 6. Технологийн дээжийн мөхлөг

Авсан газар	Хэмжих нэгж	Алтны мөхлөг ангилалаар /мм/					Бүгд
		-0.125	0.25+0.125	0.5+0.25	1.0+0.5	-2.0+1	
Тех туршилт	гр	15.0	212	257	206	84	794
	%	1.9	26.7	34.9	25.9	10.6	

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024

Дээрхи хүснэгтүүдээс харвал ордын алтны том, дунд мөхлөгтэй хэсэг нь +0.5- 3.0 мм нь 88% жижиг мөхлөг болох -0.25 мм нь 12% байна. Уг ордын алтны элэгдлийн зэрэг нь сайн, том, дунд ширхэг мөхлөгтэй алт зонхилж, жижиг тоосонцор алт бага хувьтай байгаа болон шаварлаг хольц бага, усанд уусан задрах чанараар сайн байгаа явдал нь бидний хийсэн хагас үйлдвэрийн туршилтын үр дүн, алт агуулагч хурдасны бүтэц бүрэлдэхүүн зэргээс шалтгаалан Скрubber Screen80 маркийн тоног төхөөрөмжийн тусламжтайгаар нэг удаагийн угаалга баяжуулалтаар олборлож болохыг хайгуул судалгаа, хагас үйлдвэрийн туршилтаар харуулсан байна. Хучдас хурдсанд болон алт гольдролдоо гол, горхины усны татралт урсалтын нөлөөгөөр хэрхэн хуримтлагдан бий болсон байдал нь тод ялгагддаг. Уг хурдасны нягтралшилт сайн учир олборлолтын үед карьерийн хананд нуралт, гулсалт бага тохиолдох сайн талтай. Хуурайгийн алтны шороон ордын дунд хэсэгт судалгааны талбайд мөнх цэвдэг байхгүй бөгөөд зөвхөн улирлын чанартай хөлдөлт 0-3.0м-г тохиолдоно. Дээж боловсруулалтын явцад хар тунадас үүсгэгчийг лабораторийн судалгаанд өгч эрдсийн судалгаа хийлгэсэн үр дүнгээс үзвэл: гол эрдэс нь магнетит, ильменит, гранат, монацит, сфен, циркон, рутил, апатит, касситирит, пирит зэрэг хүдрийн эрдсүүд тодорхойлогдсон боловч эдгээр нь агуулга маш бага учир үйлдвэрлэлийн ач олбогдолгүй бөгөөд зөвхөн алт нь үйлдвэрлэлийн ач холбогдолтой болох нь лабораторийн ба хагас үйлдвэрийн туршилтаар тогтоогдсон болно. Манай ордтой зэрэгцээ хиллэн орших Хуурай чулуутын алтны шороон ордод хийсэн петрографийн судалгаа болон бидний хээрийн нөхцөлд Хуурайгийн дээд эсгийн алтны шороон талбайд хийсэн хээрийн судалгаагаар + 100 мм -ээс +3 мм хүртлэх ангилалд боржингийн бүлгийн чулуулгууд, боржин, боржин-диорит, габбро-диорит; занар, элсэн чулуу, алевролит зэрэг чулуулгийн хэмхэдэс зонхилж байгаа бол +2.5 мм-ээс доошхи ангилалд хээрийн жонш, кварц зэрэг эрдэсийн хэмхэдэс зонхилж байна. Алт нь: Алтан шаргал өнгөтэй аяа ногоовтор шар туяатай, зонхилох мөхлөг нь дунд зэрэг мөлгөржилттэй, алтны ихэнх мөхлөгийн гадаргуу тэгшивтэр, хааяа овон товон, нүх сүвэрхэг бөгөөд зарим мөхлөг кварц болон төмрийн усан исэлтэй ургалт үүсгэсэн, төмрийн усан ислээр хучигдсан байх тохиолдол ажиглагдана. Алт нь хэлбэрийн дараах байдлаар ангилагддаг.

- хумхиа хэлбэрийн алт 50%
- хуудаслаг хэлбэрийн алт 40%
- ялтаслаг хэлбэрийн алт 10%

### ***II.9. Алтны сорьц тогтоох шинжилгээ***

Геологийн Төв лабораториар хийлгэсэн алтны сорьцын шинжилгээ 915.2-ийн сорьцтой гэж тогтоогдсон байна.

### **II.10. Ордын нөөцийн тооцоо**

Геологийн тогтоцын шинж чанар, ашигт малтмалын нөөцийн хэмжээгээрээ Хуурай, Чулуут алтны шороон орд нь Монгол улсад мөрдөгдөж байгаа “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын дагуу боловсруулсан шороон ордод хэрэглэх аргачилсан зөвлөмжид заасны дагуу III бүлгийн буюу ашигт малтмалын давхаргын өргөн, зузаан нь тогтворгүй, металлын жигд бус тархалттай, харьцангуй баян болон ядуу хэсгүүд нь салаавчилсан тогтоцтой, жижиг хэмжээтэй ордод хамаарна.

Хайгуулын ажил явуулсан Хуурай, Чулуут алтны шороон ордын жишгийг ашиглан ордын хил заагийг тогтоон, бодитой В болон боломжтой С зэргээр нөөцийн тооцоог хийлээ.

Нөөцийн тооцоогоор Хуурай, Чулуут алтны шороон ордын хэмжээнд бодитой В зэргээр дунджаар 13.5м зузаан, 164178.4м<sup>3</sup> хөрс хуулалттай, дунджаар 1.3м зузаан, 15265.2м<sup>3</sup> элсэнд 986мг/м<sup>3</sup> /шлих-хязсан/ алтны дундаж агуулгатай, 13.77кг /хими.цэвэр/ алт, боломжтой С зэргээр дунджаар 7.6м зузаан, 406175.0м<sup>3</sup> хөрс хуулалттай, дунджаар 0.9м зузаан, 47915.0м<sup>3</sup> элсэнд 686мг/м<sup>3</sup> /шлих-хязсан/ алтны дундаж агуулгатай, 30.09кг /хими.цэвэр/ алтны нөөц тооцлоо. Үүнээс Хуурай ордын бага гүний татмын хэсэгт бодитой В зэргээр дунджаар 5.4м зузаан, 10559.2м<sup>3</sup> хөрс хуулалттай, дунджаар 1.6м зузаан, 3073.2м<sup>3</sup> элсэнд 228мг/м<sup>3</sup> /шлих-хязсан/ алтны дундаж агуулгатай, 0.64кг /хими.цэвэр/ алт, боломжтой С зэргээр дунджаар 5.3м зузаан, 10746.0м<sup>3</sup> хөрс хуулалттай, дунджаар 1.7м зузаан, 3510.0м<sup>3</sup> элсэнд 199мг/м<sup>3</sup> /шлих/ алтны дундаж агуулгатай, 0.64кг /хими.цэвэр/ алтны нөөц, Хуурай ордын дунд гүний дэнжийн хэсэгт бодитой В зэргээр дунджаар 15.1м зузаан, 153619.2м<sup>3</sup> хөрс хуулалттай, дунджаар 1.2м зузаан, 12192.0м<sup>3</sup> элсэнд 1177мг/м<sup>3</sup> /шлих-хязсан/ алтны дундаж агуулгатай, 13.13кг /хими.цэвэр/ алт, боломжтой С зэргээр дунджаар 14.3м зузаан, 219813.0м<sup>3</sup> хөрс хуулалттай, дунджаар 1.2м зузаан, 18063.0м<sup>3</sup> элсэнд 1138мг/м<sup>3</sup> /шлих-хязсан/ алтны дундаж агуулгатай, 18.81кг /хими.цэвэр/ алтны нөөц, Чулуут аманд боломжтой С зэргээр дунджаар 4.9м зузаан, 175616.0м<sup>3</sup> хөрс хуулалттай, дунджаар 0.7м зузаан, 26342.0м<sup>3</sup> элсэнд 441мг/м<sup>3</sup> /шлих-хязсан/ алтны дундаж агуулгатай, 10.64кг /хими.цэвэр/ алтны нөөц тооцлоо.

XV-021736 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд ямар нэгэн өөр төрлийн ашигт малтмал байхгүй, нөөц өсөх боломжгүй юм.

### Хүснэгт 7. Хуурай, Чулуут алтны шороон ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

блокийн дугаар	хайгуулын шугамын дугаар	зузаан (м)		дундаж агуулга мг/м.куб		блокийн талбай м.кв	эзлэхүүн м.куб		металл, кг			
		хучдас	элс	хяз-гүй	хяз-сан		хучдас	элс	шлих		хими.цэвэр	
									хяз-гүй	хяз-сан	хяз-гүй	хяз-сан
Чулуут												
C-1	10 /1985/	7.2	1.2	477		2010.00	14472.0	2412.0	1.15		1.05	
C-2	10/1985/-10	6	1.0	740	670	4850.0	29100.0	4850.0	3.59	3.25	3.28	2.97
C-3	10-12	4.4	0.8	713	626	7560.00	33264.0	6048.0	4.31	3.78	3.95	3.46
C-4	12-14	4.2	0.8	314		7260.0	30492.0	5808.0	1.83		1.67	
C-5	14-16	4.0	0.6	276		7400.0	29600.0	4440.0	1.22		1.12	
C-6	16-20	5.2	0.4	144		5400.0	28080.0	2160.0	0.31		0.28	
C-7	20	6.8	0.4	131		1560.0	10608.0	624.0	0.08		0.07	
<b>нийт С зэргээр</b>		<b>4.9</b>	<b>0.7</b>	<b>474</b>	<b>441</b>	<b>36040.0</b>	<b>175616.0</b>	<b>26342.0</b>	<b>12.49</b>	<b>11.63</b>	<b>11.43</b>	<b>10.64</b>
Хуурай /бага гүн/												
I-C-1	27	5.4	1.8	209		1470.0	7938.0	2646.0	0.55		0.51	
I-B-2	27-27.5	5.4	1.6	241	228	1970.0	10559.20	3073.2	0.74	0.70	0.68	0.64
I-C-3	27.5	5.2	1.6	168		540.0	2808.00	864.0	0.15		0.13	
<b>нийт В зэргээр</b>		<b>5.4</b>	<b>1.6</b>	<b>241</b>	<b>228</b>	<b>1970.0</b>	<b>10559.2</b>	<b>3073.2</b>	<b>0.74</b>	<b>0.70</b>	<b>0.68</b>	<b>0.64</b>
<b>нийт С зэргээр</b>		<b>5.3</b>	<b>1.7</b>	<b>199</b>		<b>2010.0</b>	<b>10746.0</b>	<b>3510.0</b>	<b>0.70</b>		<b>0.64</b>	
<b>нийт В+С зэргээр</b>		<b>5.4</b>	<b>1.7</b>	<b>219</b>	<b>213</b>	<b>3980.0</b>	<b>21305.2</b>	<b>6583.2</b>	<b>1.44</b>	<b>1.40</b>	<b>1.32</b>	<b>1.28</b>

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024

Хуурай /дэнж/												
П-С-1	27	12.0	0.4	620		1600.0	19200.0	640	0.40		0.36	
П-С-2	30/1986/-27	12.6	1.2	990		1630.0	20538.0	1956.0	1.94		1.77	
П-С-3	30-30/1986/	14.7	1.1	1273		9250.0	135975.0	10175.0	12.95		11.85	
П-В-4	32-30	15.1	1.2	1389	1177	10160.0	153619.2	12192.0	16.93	14.35	15.49	13.13
П-С-5	32	15	1.8	1349	997	2940.0	44100.0	5292.0	7.14	5.27	6.53	4.83
<b>нийт В зэргээр</b>		<b>15.1</b>	<b>1.2</b>	<b>1389</b>	<b>1177</b>	<b>10160.0</b>	<b>153619.2</b>	<b>12192.0</b>	<b>16.93</b>	<b>14.35</b>	<b>15.49</b>	<b>13.13</b>
<b>нийт С зэргээр</b>		<b>14.3</b>	<b>1.2</b>	<b>1242</b>	<b>1138</b>	<b>15420.0</b>	<b>219813.0</b>	<b>18063.0</b>	<b>22.43</b>	<b>20.56</b>	<b>20.52</b>	<b>18.81</b>
<b>нийт В+С зэргээр</b>		<b>14.6</b>	<b>1.2</b>	<b>1301</b>	<b>1154</b>	<b>25580.0</b>	<b>373432.2</b>	<b>30255.0</b>	<b>39.35</b>	<b>34.91</b>	<b>36.01</b>	<b>31.94</b>
Хуурайн ордын хэмжээнд												
<b>нийт В зэргээр</b>		<b>13.5</b>	<b>1.3</b>	<b>1157</b>	<b>986</b>	<b>12130.0</b>	<b>164178.4</b>	<b>15265.2</b>	<b>17.67</b>	<b>15.05</b>	<b>16.17</b>	<b>13.77</b>
<b>нийт С зэргээр</b>		<b>13.2</b>	<b>1.2</b>	<b>1072</b>	<b>985</b>	<b>17430.0</b>	<b>230559.0</b>	<b>21573.0</b>	<b>23.12</b>	<b>21.26</b>	<b>21.16</b>	<b>19.45</b>
<b>нийт В+С зэргээр</b>		<b>13.4</b>	<b>1.2</b>	<b>1107</b>	<b>986</b>	<b>29560.0</b>	<b>394737.4</b>	<b>36838.20</b>	<b>40.79</b>	<b>36.31</b>	<b>37.33</b>	<b>33.22</b>
нийт талбайн хэмжээнд												
<b>нийт В зэргээр</b>		<b>13.5</b>	<b>1.3</b>	<b>1157</b>	<b>986</b>	<b>12130.0</b>	<b>164178.4</b>	<b>15265.2</b>	<b>17.67</b>	<b>15.05</b>	<b>16.17</b>	<b>13.77</b>
<b>нийт С зэргээр</b>		<b>7.6</b>	<b>0.9</b>	<b>743</b>	<b>686</b>	<b>53470.0</b>	<b>406175.0</b>	<b>47915.0</b>	<b>35.62</b>	<b>32.88</b>	<b>32.59</b>	<b>30.09</b>
<b>нийт В+С зэргээр</b>		<b>8.7</b>	<b>1.0</b>	<b>843</b>	<b>759</b>	<b>65600.0</b>	<b>570353.4</b>	<b>63180.2</b>	<b>53.29</b>	<b>47.93</b>	<b>48.76</b>	<b>43.86</b>

### БҮЛЭГ III. УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ, ХҮЧИН ЧАДАЛ

Оюут цахир уул ХХК-ийн төлөвлөж байгаагаар Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг жилд 80.8 мян.м<sup>3</sup> элс олборлон, баяжуулж химийн цэврээр 40.62 кг алт гарган, борлуулахаар төлөвлөж байна. Энэ хүчин чадлаар алтны шороон ордын үйлдвэрлэлийн нөөцийг 1 жилийн хугацаанд ашиглахаар байна.

#### III.1. Ордын уул техникийн нөхцөл

Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордын гадаргуугийн орчин нь хуурай, намаг болон ой мод, хад асга байхгүй уурхайн овоолгууд байрлуулах тээвэр хийх, усан сан байгуулах жижиг хэмжээний тосгон байрлуулах зэрэгт чөлөөт талбай хүрэлцээтэй орчин нутгийн болон төр засгийн тусгай эдэлбэрийн талбайд харъяалагдахгүй байгаль орчныг эвдлэн өөрчлөхөд улсад болон орчны хүн ам байгальд ноцтой хохирол учруулахгүй бүсэд оршиж байна.

Гадаргуугийн орчин үеийн дүр төрх нь мезозойн эринээс уламжлан ирсэн геологийн хөгжилтэй шууд холбоотой бөгөөд шинэхэн тектоникийн үйл ажиллагаа гол үүрэг гүйцэтгэсэн байна.

Уул нурууд ба тэдгээрийн хоорондох хөндийнүүдийн ерөнхий тогтоц зүүн хойшоо, өргөргийн дагуу чигтэй Шарын голын гүний хагарлын дагуу байрлалтай байдаг бөгөөд эдгээр нь зүүн хойш, хойш чиглэлтэй хагарлуудаар хэсэгчлэгдэн юра-цэрдийн үед дунд зэрэг уулархаг гадаргуу ба тэдгээрийн хоорондох томоохон хотгорууд үүсжээ. Тэдгээр



хотгоруудын нэг нь Шарын голын грабен бөгөөд чийглэг дулаан уур амьсгалтай нөхцөлд энд нуур намгийн гаралтай нүүрс агуулсан шаварлаг хурдас хуримтлагдсан байна.

Мөн энэ үед алтны үндсэн хүдэржилт бүхий өгөршсөн хурдас чулуулгууд болон хүдрийн биетүүд элэгдэл, зөөгдөлд орж, ийм грабен- синклиналиудад тунаш хуримтлалын эхэн үе ба хэсэг хугацааны тасалдлын дараа үүссэн хэрзэн чулуулгууд нь алтны шороон хуримтлал агуулжээ.

Ийнхүү бүхэлдээ тэгшрэлийн гадаргууд шилжсэн талбай дээд цэрдээс миоцены үед тогтвортой өргөгдөл голлосон угаагдал, зөөгдлийн бүс байсан бололтой. Плиоцений эхнээс тектоникийн идэвхжилт сулран пенепленжиж эхлэсэн бөгөөд хуурай халуун уур амьсгал зонхилж байснаас өгөршлийн гадаргуу үүссэн байна. Плиоцены сүүлчээс тектоник хөдөлгөөн дахин идэвхжихэд бага зэрэг өргөгдөлд орж, дээр дурьдсан өгөршил угаагдан улаан өнгийн шаварлаг хурдас хуримтлагдсан байна.

Дөрөвдөгч-орчин үед уур амьсал чийглэг болж, урсгал усны үйл ажиллагаа идэвхжин, одоогийн хөндийнүүдэд орчин үеийн аллювийн хурдас хуримтлаж эхэлсний зэрэгцээ гадаргуугийн өгөршил ба хажуугийн гулсалт, идэгдэл хүчтэй явагдаж, бэл-хормойн хуримтлалтай хажуунууд болон бичил доворхог гадаргуу үүсэн, тэдгээр нь орчин үеийн хуурай сайр, гуу жалгуудаар хэрчигдэн, талбайн өнөөгийн дүр төрх бүрдсэн байна.

### **Ордын гидрогеологи**

Талбайн хувьд гидрогеологийн үндсэн нөхцөлийг нь гол ус агуулагч үе нь, аллювиаль хурдсанд агуулагдана. Ус агуулагч аллювиаль хурдас нь Шарын голын хөндийн татмын хэмжээнд өргөн тархсан, хажуугийн урсацаас Хавчуугийн гол урсан орж ирдэг. Шарын голын ордын усжилтын зэрэг нь эрчимтэй усжилттай, усжилттай, усжилтгүй гэж хуваагддаг. Усжилттай хэсэгт Шарын гол, Хавчуугийн гол хамаарагддаг. Ус агуулагч хурдас нь бага хэмжээний валунтай элс агуулсан хайрга хайрганцар хурдаснаас бүрддэг.

Гидрогеологийн цооногоос авсан мэдээллээр шүүрүүлэх чадамж 1,67-3,36 л/сем/м. Газрын доорхи усны химийн шинжилгээгээр 0.2-0.4 г/л эрдэсжилтийн хэлбэлзэлтэй цэнгэг ус гэдэг нь тогтоогдсон.

Аллювын хурдсан дахь газрын доорхи ус нь нүүрс хүчил, хүчил, шүлт, сульфат зэрэг шинж чанарт автагдаагүй байна. Усны сорьцны химийн шинжилгээний үр дүнгээр компонентуудын агууллага, усны тархалтын хүч, хэмжээ, зөвшөөрөгдсөн хэмжээнээс хүрэлцээтэй доогуур урьдчилан тооцсон техникийн нөхцөлийн хэмжээгээр байх бөгөөд газрын доорхи усны хүчилтөрөгчийн тархалтанд автагдаагүй байна.

### **III.2. Ашиглалтын технологи, механикжуулалтын бүтэц**

Ордын уул техник, элсний технологийн шинж чанар зэрэг суурь нөхцөл болон захиалагч байгууллагын техникийн даалгаврын дагуу ордыг ил аргаар ашиглахад экскаватор-автосамосвалын хослол бүхий автотээвэртэй, гадаад болон дотоод овоолготой ашиглалтын систем ашиглалтын систем сонгов.

Тус ордын нийт нөөц нь талбайн баруун хойд хэсэгт хойноос урагш сунаж тогтсон 1.6 км урт, 20 м өргөн, дээрээ дундажаар 5 м хучдас бүхий, 0.63 м зузаантай, төв хэсэгт зүүн хойд чиглэлд 130 м орчим урт, 30 м өргөн, 5.8 м хучдастай, 1.27 м зузаантай, зүүн урд хэсэгт баруунаас зүүн зүгт сунаж тогтсон 660 м урт, 40 м өргөн, 14.1 м хучдастай, 0.95 м зузаан элс

бүхий 3 хэсэг 15 блокоос бүрдэж байна. Ордын ашигт давхаргын зузаан ордын хэмжээнд харьцангуй жигд үзүүлэлттэй, давхарга нь хэвтээ, хэвгий уналтай ба хучдас давхаргын зузаан бага байгаа нь уул техникийн таатай нөхцөлийг бүрдүүлж байна. Уг ордын геологийн ерөнхий сунаж тогтсон тогтоцод үндэслэн тээвэртэй, дотоод овоолго болон гадаад түр овоолготой байхаар ашиглалтын систем сонгон авсан. Дээрх ангилалтын системд тодруулсанчлан уг алтны шороон ордыг ил аргаар, экскаватор өөрөө буулгагчийн тээвэрлэлттэй хослолоор олборлохоор сонгон авлаа.

Ордыг ашиглах технологи нь түр гадаад овоолготой, дүүргэлт бүхий дотоод овоолгоор уурхайн хөрс хуулалт, элс олборлолтын болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюулгүй, эдийн засгийн үр ашигтай, ашигт малтмалын нөөцийг зохистой ашиглахын зэрэгцээ төлөвлөгөөт бүтээлийг хангах ёстой.

### Хүснэгт 8. Уурхайн механикжуулалтын бүтэц

Ажлын төрөл	Процессууд, тоног төхөөрөмж		
	Хөрс хуулалт	Экскавац	Шидэлт
Экскаватор		Тээвэрлэлт	Бульдозер
Элс олборлолт	Экскавац	Тээвэрлэлт	Овоолго
	Экскаватор	Автосамосвал	Утгуурт ачигч

### Ш.3. Ил уурхайн хажуугийн тогтворжилт, ашиглалтын системийн параметрууд

#### Уурхайн хажуугийн тогтворжилт

Ил уурхайн хажуу, доголын тогтворжилтын нөхцөл нь геологийн тогтоц, чулуулгийн бат бөх чанар, тектоник эвдрэл, усжилт зэргээс хамаарна. Хуурай, Чулуут, Дэнж хэсгийн алтны шороон ордын хөрсний чулуулаг нь элс, элсэнцэр, алевролит, элсэн чулуу, хайрга, хайрганцар, шавранцар зэрэг байна. Хучдас хурдсанд болон алт гольдролдоо гол, горхины усны татралт урсгалтын нөлөөгөөр хуримтлагдсан бөгөөд хурдасны нягтралшилт сайн учир олборлолтын үед карьерийн хананд нуралт, гулсалт бага тохиолдох сайн талтай. Ордын агуулагч чулуулгийн шинж чанараас хамааруулж уурхайн хажуугийн өнцөг, доголын хажуугийн өнцөг зэргийг ОХУ-ын Гипроруда хүрээлэнгийн баримтлалаар сонголоо.

### Хүснэгт 9. Доголын хажуугийн өнцөг (“Гипроруда”-гийн баримтлал)

Чулуулгийн бүлэг	Бүлгийн тодорхойлолт	Чулуулаг	Доголын өндөр, м	Доголын хажуугийн өнцөг		
				Ажлын догол	Ажлын бус	
					Дан	Нэгтгэж нийлүүлсэн
	Бат бөх чулуулаг	Маш бөх тунамал, хувирмал ба бялхмал чулуулаг	15-20	<90	70-75	65-70

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024


	σш>80 мПа	Бөх, бага зэрэг цавшилтай ба бага зэрэг өгөршсөн тунамал, хувирмал ба бялхмал чулуулаг	15-20	<80	60-65	55-60
		Бөх, цавархаг ба бага зэрэг өгөршсөн тунамал, хувирмал, ба бялхмал чулуулаг	10-15	<75	55-60	60-55
<b>I</b>	Дунд зэрэг бөх чулуулаг σш=8-80 мПа	Өгөршлийн бүсийн тунамал, хувирмал, бялхмал чулуулаг, хажууд харьцангуй тогтвортой (шохойн чулуу, элсэн чулуу алевролит ба бусад цахиурлаг холбоостой чулуулаг, конгломерат, гнейс, порфирит боржин, туф) чулуулаг	10-15	70-75	50-55	45-50
		Нэлээд өгөршсөн тунамал, хувирмал, ба бялхмал чулуулаг ба хажууд эрчимтэй өгөршдөг (аргилит, алевролит, занарлаг ба бусад) чулуулаг	10-15	60-70	35-45	35-40
<b>II</b>	<u>Сул, холбоос муутай чулуулаг</u> <u>σш&lt;8 мПа</u>	<u>Шаварлаг чулуулаг, бүтэн задарсан бүх чулуулгийн зүйл</u>	<u>10-15</u>	<u>50-60</u>	<u>45-50</u>	<u>35-40</u>
		Элс-шаварлаг чулуулаг	10-15	40-50	35-45	30-40
		Элс-хайргархаг чулуулаг	10-15	<40	30-40	25-35

### Хүснэгт 10. Ил уурхайн хажуу ба доголудын налуугийн өнцгийн баримжаа хэмжээ (“Гипроруда”-гийн баримтлал)

Чулуулгийн бат бөхийн тодорхойлолт	Чулуулгийн бат бөхийн коэффициент (проф. М.М.Протодьяконовын шаталбар)	Ил уурхайн доголын хажуугийн өнцөг, град	Ил уурхайн гүнээс хамаарах хажуугийн налуугийн өнцөг, град			
			90	180	240	300
Дээд зэргийн бат бөх ба маш бөх чулуулаг	15-20	75-85	60-68	57-65	53-60	48-54
Бөх ба бөхдүү чулуулаг	8-14	65-75	50-60	48-57	45-53	42-48
Дунд зэрэг бөх чулуулаг	3-7	55-65	43-50	41-48	39-45	36-43
<u>Зөөлөндүү ба зөөлөн чулуулаг</u>	<u>1-2</u>	<u>40-55</u>	<u>30-43</u>	<u>28-41</u>	<u>26-39</u>	<u>24-36</u>
Зөөлөн ба шороо	0.6-0.8	25-40	21-30	20-28	-	-

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024

Ордын агуулагч чулуулгийн бат бөхийн үр дүнгээр уурхайн хажуугийн өнцөг, доголын хажуугийн өнцөг зэргийг ОХУ-ын Гипроруда хүрээлэнгийн баримтлалаар тодорхойлоход, ил уурхайн хажуугийн тогтворжилтыг хангах ил уурхайн хажуугийн өнцөг  $45^{\circ}$ , доголын налууугийн өнцөг  $50^{\circ}$  байна. Уурхайн дундаж гүнзгийрэл 5 м орчим, мөн тэсэлгээгүйгээр хөрс хуулалтын ажил явагдах зэрэг хүчин зүйлсийг тооцоолон уурхайн дизайн болон тооцоонд урьдчилсан байдлаар авч тооцлоо. Уурхайн гүнзгийрэл нь ихэнхи тохиолдолд 5 м орчим байх ба энэ үед уурхайн гүнзгийрэл нь 1 доголоор явах ба зарим хэсэгт 15 м хүртэл гүнзгийрэх үед 2 доголоор нэмэгдэнэ. 15 м хүртэлх гүнзгийрэх үед эхний догол нь 5 м өндөртэй, доголын хажуугийн өнцөг  $60^{\circ}$  байна. Харин доод догол нь 10 м өндөртэй, доголын хажуугийн өнцөг мөн  $60^{\circ}$ , догол хоорондын бермийн зай нь 5 м байна. Энэ үед уурхайн хажуугийн өнцөг нь  $48^{\circ}$  болж байна.



**Зураг 2. Уурхай хоёр доголоор гүнзгийрэх үеийн уурхайн хажуугийн хананы дизайн**

Уурхайн ашиглалтын явцад уурхайн ус таталт, шүүрүүлэлтийн ажлыг сайн хийж, уурхайн ёроолын түвшинд байлгах хэрэгтэй.

### **Ашиглалтын системийн параметрууд**

Ашиглалтын системийн сонголт, хөрс болон элсний зузаан зэргээс хамааруулж ашиглалтын системийн параметруудийг дараах байдлаар сонголоо.

#### **Хүснэгт 11. Ашиглалтын системийн элементүүд**

Д/д	Ашиглалтын системийн элементүүд	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Доголын өндөр, $H_d$	М	0.4-2 хүртэлх
2	Ажлын бус доголын өндөр, $H_{абд}$	М	4-15 хүртэлх
3	Уурхайн хажуугийн өнцөг,	град	48
6	Аюулгүйн бермийн өргөн, $b_{аб}$	М	5
7	Доголын хажуугийн өнцөг, $\alpha_d$	град	55
8	Автозамын өргөн	М	8
9	Замын налуу	%	80
10	Ажлын талбайн бага өргөн, $B_{атmin}$	М	25

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024



Хөрс хуулалт. Чулуут, Хуурай, Дэнжийн хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордын алт агуулагч элсний давхаргын дээр 4-15 м буюу дунджаар 8.7м-ийн зузаантай хучаас хөрсний үе байна. Алт агуулагч элсийг хаягдалгүй олборлохыг чухалчлан дунджаар 27.95%-ийн бохирдолтой нь хуулахаар тооцов. Хөрс хуулалтанд Doosan DX-520 маркийн экскаватор нь Ново 371 маркийн автосамосвалд хөрсийг ачиж дотоод овоолгод буулгаж ажиллана.

Олборлолт. Ордын олборлолтын доголын өндөр буюу элсний зузаан нь 0.4-1.6 м, дунджаар 0.96 м байна. Мөн Doosan DX-300 маркийн экскаватор нь 50 тн даацтай автосамосвалд элсийг ачиж, баяжуулах хэсгийн овоолгод буулгана.

Овоолго. Хөрс хуулалтын 8.5 % буюу 45.34 мян.м<sup>3</sup> хөрсийг гадаад овоолгод үлдсэн 91.5% буюу 498.76 мян.м<sup>3</sup> хөрсийг дотоод овоолгод буулгаж овоолно.

#### Хөрсний тээвэр

- Дотоод овоолгийн тээвэр нь тээвлэлтийн зай бага байх
- Хөрс хуулалтын зардал бага
- Ашиглалтын явцад дотоод овоолгод хөрсийг шидэх болон тээврээр дотоод овоолго хийх зэрэг техникийн нөхөн сэргээлтийг давхар явуулдаг.

Ордын нөөцийн блокууд дахь тогтоосон хөрсний зузаан 4-15.1 м дунджаар 8.7 м байна. Төсөлд ашиглахаар төлөвлөж буй экскаваторын янз бүрийн өндөртэй мөргөцөгт ажиллах боломжийг судалж, экскаватортой хөрсний тээвэртэй болон тээвэргүй ашиглалтын системийг хөрсний мөргөцгийн зузаанаас шалтгаалан ашиглахаар сонгож авлаа. Ордын хучаас хөрсийг элсний давхарга хүртэл экскаватораар хуулж, гадаад, дотоод овоолго хийх бөгөөд элсийг автосамосвалд ачиж угаах төхөөрөмжийн талбайд хүргэнэ. Хөрс хуулах, элс олборлох болон овоолгын ажил нь хөрс хуулж шидэх, ачиж тээвэрлэх – элсийг ачиж тээвэрлэх - хоосон орон зайд шидэж дотоод овоолго үүсгэх гэсэн дараалсан процессуудын үргэлжилсэн цикл байна. Тунаах нуурыг уурхайн доод орон зайд буюу хуучин байсан ухаш хэсэгт байршуулан ашиглахаар тооцлоо. Ил уурхайг AutoCAD программ дээр зурлаа.

Ажлын талбайн өргөн: Ил уурхайд ажиллах экскаватор болон автосамосвалын техникийн үзүүлэлтүүдээс шалтгаалан ордын ил уурхайн ажлын талбайн хамгийн бага өргөн нь нөөц тооцсон блокийн хэмжээнээс шалтгаалан 25 м-ээс багагүй байна.

### **III.4. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо**

Ашиглах буюу уурхайн хүрээ хязгаар доторх нөөцөөс ашиглалтын үеийн хаягдал бохирдлыг тооцож үйлдвэрлэлийн /үйлдвэрлэх/ нөөцийг тооцно. Тус ордын тогтоцын хувьд олон салаа сарнисан давхаргагүй, нэг нийлмэл давхаргатай нь ордыг ашиглах таатай нөхцөлийг бүрдүүлэх бөгөөд ерөнхийдөө хэвтээ, уналын өнцөг харьцангуй бага байгаа нь бохирдолтын хэмжээг бага байлгах давуу талтай. Бохирдуулж элсээ олборлож байгаа тул ашиглалтын хаягдалыг тооцсонгүй.

Ашиглалтын үеийн бохирдол нь:

1. Ул, таазны бохирдол
2. Хажуугийн хананы бохирдол зэргээс бүрдэнэ.
3. Элсийг олборлох үед элсний тааз, уланд 10 см-ийн хөрс үлдээж, хажуугаас призмээр бохирдуулж олборлоно.



**Хүснэгт 12. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо**

Д/Д	Ордын батлагдсан геологийн нөөц									Бохирдолт				Үйлдвэрлэлийн нөөц									
	Нөөцийн зэрэглэл ба блоккийн дугаар	Блоккийн талбай, мян.м2	Хучаас хөрсний зузаан	Элсний зузаан	Хучаас хөрс, м3	Элс, м3	Дундаж агуулга, мг/м3	Алт, шликхээр, кг	Алт, химийн цэврээр, кг	Ул таазны бохирдол (10 см), мян.м3	Боргын бохирдол мян.м3	Бохирдлын хувь, %	Нийт бохирдл, м3	Үйлдвэрлэлийн нөөцийн блоккийн дугаар	Хуулах хөрсний зузаан, м	Олборлох элсний зузаан, м	Хөрс хуулалт, мян.м3			Элсний хэмжээ, мян.м3	Дундаж агуулга, мг/м3	Алт, кг /шлихээр/	Алт, кг /химийн цэврээр/
																	Шимт хөрс	Шимт бус хөрс	Нийт				
<b>ХУУРАЙ /ДЭНЖ/ УУРХАЙ-1</b>																							
1	II-B-4	10160	15.12	1.2	153,619.2	12,192.0	1,177	14.3	13.1	2.03	2,987.9	24.52	2,989.9	II-B'-4	15.02	1.4	3.05	149.56	152.60	15.2	945	14.35	13.13
2	II-C-1	1600	12	0.4	19,200.0	640.0	620	0.4	0.4	0.32	252.7	39.53	253.0	II-B'-1	11.9	0.6	0.48	18.56	19.04	0.9	444	0.40	0.36
3	II-C-2	1630	12.6	1.2	20,538.0	1,956.0	990	1.9	1.8	0.33	772.9	39.53	773.2	II-B'-2	12.5	1.4	0.49	19.89	20.38	2.7	710	1.94	1.77
4	II-C-3	9250	14.7	1.1	135,975.0	10,175.0	1,273	13.0	11.9	1.85	2,075.1	20.41	2,076.9	II-B'-3	14.6	1.3	2.78	132.28	135.05	12.3	1,057	12.95	11.85
5	II-C-5	2940	15	1.8	44,100.0	5,292.0	997	5.3	4.8	0.59	2,091.3	39.53	2,091.9	II-B'-5	14.9	2	0.88	42.92	43.81	7.4	714	5.27	4.83
В зэргээр		10160	15.12	1.20	153,619.2	12,192.0	1,177	14.3	13.1	2.0	2987.9	24.52	2,989.9	В зэргээр	14	0.0	7.7	363.2	370.9	38.4	908	34.9	31.9
С зэргээр		15420	14.26	1.17	219,813.0	18,063.0	1,138	20.6	18.8	3.1	5192.0	28.76	5,195.0										
Бүгд		25580	14.60	1.18	373,432.2	30,255.0	1,154	34.9	31.9	5.1	8179.8	27.05	8,184.9	Бүгд	14	0.0	7.7	363.2	370.9	38.4	908	34.9	31.9
<b>ХУУРАЙ /БАГА ГҮН/ УУРХАЙ-2</b>																							
6	I-B-2	1970	5.36	1.56	10,559.2	3,073.2	228	0.7	0.6	0.39	599.6	19.52	600.0	I-B'-2	5.26	1.76	0.59	9.77	10.36	3.7	191	0.70	0.64
7	I-C-1	1470	5.4	1.8	7,938.0	2,646.0	209	0.6	0.5	0.29	494.3	18.69	494.6	I-B'-1	5.3	2	0.44	7.35	7.79	3.1	176	0.55	0.51
8	I-C-3	540	5.2	1.6	2,808.0	864.0	168	0.1	0.1	0.11	208.9	24.20	209.1	I-B;-3	5.1	1.8	0.16	2.59	2.75	1.1	135	0.15	0.13
В зэргээр		1970	5.36	1.56	10,559.2	3,073.2	228	0.7	0.6	0.39	599.57	19.52	600.0	В зэргээр	5	2.0	1.2	19.7	20.9	7.9	178	1.4	1.3

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024

С зэргээр	2010	5.35	1.75	10,746.0	3,510.0	199	0.7	0.6	0.40	703.24	20.05	703.6												
Бүгд	3980	5.35	1.65	21,305.2	6,583.2	213	1.4	1.3	0.80	1,302.81	19.80	1,303.6	Бүгд	5.3	2.0	1.2	19.7	20.9	7.9	178	1.4	1.3		
<b>ЧУЛУУТ УУРХАЙ-3</b>																								
9	С-1	2010	7.2	1.2	14,472.0	2,412.0	477	1.2	1.1	0.40	967.3	40.12	967.7	В'-1	7.1	1.4	0.60	13.67	14.27	3.4	340	1.15	1.05	
10	С-2	4850	6	1	29,100.0	4,850.0	670	3.2	3.0	0.97	1,944.9	40.12	1,945.8	В'-2	5.9	1.2	1.46	27.16	28.62	6.8	478	3.25	2.97	
11	С-3	7560	4.4	0.8	33,264.0	6,048.0	626	3.8	3.5	1.51	1,349.7	22.34	1,351.2	В'-3	4.3	1	2.27	30.24	32.51	7.4	511	3.78	3.46	
12	С-4	7260	4.2	0.8	30,492.0	5,808.0	314	1.8	1.7	1.45	1,381.2	23.81	1,382.7	В'-4	4.1	1	2.18	27.59	29.77	7.2	254	1.83	1.67	
13	С-5	7400	4	0.6	29,600.0	4,440.0	276	1.2	1.1	1.48	1,402.0	31.61	1,403.5	В'-5	3.9	0.8	2.22	26.64	28.86	5.8	210	1.22	1.12	
14	С-6	5400	5.2	0.4	28,080.0	2,160.0	144	0.3	0.3	1.08	865.2	40.11	866.3	В'-6	5.1	0.6	1.62	25.92	27.54	3.0	103	0.31	0.28	
15	С-7	1560	6.8	0.4	10,608.0	624.0	131	0.1	0.1	0.31	250.0	40.12	250.3	В'-7	6.7	0.6	0.47	9.98	10.45	0.9	93	0.08	0.07	
В зэргээр														В зэргээр	5	1.0	10.8	161.2	172.0	34.5	337	11.6	10.6	
С зэргээр		36040	4.87	0.73	175,616.0	26,342.0	441	11.6	10.6	9.73	8.91	31.01	8,167.5											
Бүгд		36040	4.87	0.73	175,616.0	26342.0	441	11.6	10.6	9.73	8.91	31.01	8167.5	Бүгд	4.8	1.0	10.8	161.2	172.0	34.5	337	11.6	10.6	
<b>НИЙТ</b>																								
Нийт (В)		12130.0	13.53	1.26	164178.4	15265.2	986	15.0	13.8	2.4	3587.4	23.52	3589.8	В зэргээр	8.6	1.2	19.7	544.1	563.8	80.8	593	47.9	43.9	
Нийт (С)		53470.0	7.60	0.90	406175.0	47915.0	686	32.9	30.1	13.2	5904.1	29.36	14066.2											
Нийт (В+С)		65600.0	8.69	0.96	570353.4	63180.2	759	47.9	43.9	15.6	9491.5	27.95	17656.0	Бүгд	8.6	1.2	19.7	544.1	563.8	80.8	593	47.9	43.9	

Элсний бохирдлыг тооцохдоо хэсэг болон нөөцийн блок тус бүр дээр ул, тааз болон уурхайн хажуугийн бохирдлыг тооцлоо. Нийт бохирдлын хэмжээг тооцсоноор уурхайн хэмжээнд бохирдлын хэмжээ дунджаар 27.95% байна.



*Зураг 3. Ордын элсний давхаргын 3D загварчлал*

### **III.5. Ил уурхайн ашиглалт, уулын ажлын төлөвлөлт**

Уурхайн сарын хүчин чадал нь дунджаар 90.7 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, олборлох элсний хэмжээ нийт 13.5 мян.м<sup>3</sup> байна.

Олборлолтын явцад хуулсан хөрсийг гадаад овоолго болон дотоод овоолгод шууд байршуулах ба олборлосон элсийг элс угаах талбайд тээвэрлэн хүргэнэ.

Дээрх хүчин чадлаар тус ордыг ашиглалтын 1 жилийн хугацаанд бүрэн ашиглаж дуусахаар тооцсон. Ордын нийт нөөц нь 3 хэсгээс бүрдэх бөгөөд Уурхай-1 ба Дэнж, Уурхай-2 ба Хуурай, Уурхай-3 ба Чулуут гэсэн уурхай олборлолтын явцад үүснэ. Уурхай нь эхний блокын хөрсийг гадаад түр овоолгод байршуулж орон зай гарч эхлэхээр дотоод овоолгод хөрсийг буулгаж хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэнэ.

Нийт ашиглалтын 1 жилийн хугацаанд нийт 544.1 мян.м<sup>3</sup> хөрс хуулалтын ажил гүйцэтгэж, 80.8 мян.м<sup>3</sup> элс олборлож химийн цэврээр 43.9 кг алт олборлохоор байна.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024




## Хүснэгт 13. Уурхайнуудыг ашиглах дараалал

Д/Д	Уурхайн нэр	Үйлдвэрлэлийн нөөц блокийн дугаар	Блокын талбай, мян.м2	Хөрс хуулалт, мян.м3			Элсний хэмжээ, мян.м3	Дундаж агуулга, мг/м3	Алт, кг /шлихээр/	Алт, кг /химийн цэврээр/
				Шимт хөрс	Шимт бус хөрс	Нийт хөрс				
1	Уурхай- 2 ба Хуурай	I-B'-2	1.97	0.59	9.77	10.4	3.7	191.1	0.7	0.6
		I-B'-1	1.47	0.44	7.35	7.8	3.1	176.3	0.6	0.5
		I-B-3	0.54	0.16	2.59	2.8	1.1	135.3	0.1	0.1
		Дүн	3.98	1.19	19.71	20.91	7.89	177.65	1.4	1.3
	Уурхай- 1 ба Дэнж	II-B'-1	1.60	3.05	18.56	19.0	0.9	444.4	0.4	0.4
		II-B'-2	1.63	0.48	19.89	20.4	2.7	709.5	1.9	1.8
		II-B'-3	9.25	0.49	132.28	135.1	12.3	1057.0	13.0	11.9
		Дүн	12.48	4.02	170.72	174.47	15.87	962.8	15.3	14.0
	Нийт дүн	16.46	5.2	190.4	195.4	23.8	702.2	16.7	15.3	
2	Уурхай- 1 ба Дэнж	II-B'-4	10.16	3.05	149.56	152.6	15.2	1000.0	15.2	13.9
		II-B'-5	2.94	0.88	42.92	43.81	7.38	714.3	5.27	4.8
		Дүн	13.10	3.9	192.5	196.4	22.6	906.5	20.5	18.7
	Уурхай- 3 ба Чулуут	B'-1	2.01	0.60	13.67	14.3	3.4	340.4	1.15	1.1
		B'-2	4.85	1.46	27.16	28.6	6.8	477.9	3.25	3.0
		Дүн	6.86	2.1	40.8	42.9	10.2	432.3	4.40	4.0
		Нийт дүн	19.96	5.99	233.31	239.30	32.74	759.1	24.9	22.7
	3	Уурхай- 3 ба Чулуут	B'-3	7.56	2.3	30.2	32.5	7.4	419.0	3.1
B'-4			7.26	2.2	27.6	29.8	7.2	253.9	1.8	1.7
B'-5			7.40	2.2	26.6	28.9	5.8	175.3	1.0	0.9
B'-6			5.40	1.6	25.9	27.5	3.0	102.6	0.3	0.3
B'-7			1.56	0.5	10.0	10.5	0.9	93.5	0.1	0.1
Дүн			29.2	8.8	120.4	129.1	24.3	260.7	6.3	5.8
4	Бүгд дүн	65.60	19.7	544.1	563.8	80.8	593	47.9	43.8	

Ил уурхайг 1 жилийн хугацаанд дараах дарааллаар ашиглахаар төлөвлөсөн. Ордын нийт нөөц нь 3 хэсгээс бүрдэх бөгөөд 2-р улиралд Хуурай, Дэнжийн хэсгүүд, 3-р улиралд ба Дэнж, Чулуутын хэсэг, 3,4-р улиралд Чулуут хэсэг гэсэн дарааллаар олборлолтын үйл ажиллагаа явагдана. Уурхай нь эхний хэсгийн хөрсийг гадаад түр овоолгод байршуулж орон зай гарч эхлэхээр дотоод овоолгод хөрсийг буулгаж хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэнэ.

**Хүснэгт 14. Ашиглалтын жилийн уулын ажлын хэмжээ, төлөвлөлт**

№	Улирал	Сарууд	Олборлолтонд өртөх талбай, мян.м <sup>2</sup>	Овоолгод дарагдах талбай, мян.м <sup>2</sup>	Нийт ашиглалтанд өртөх талбай, мян.м <sup>2</sup>	Кхх, м <sup>3</sup> /м <sup>3</sup>	Нийт хөрс хуулагт, мян.м <sup>3</sup>	Үүнээс: Шимт хөрс хуулагт, мян.м <sup>3</sup>	Үүнээс: Хөрс хуулагт, мян.м <sup>3</sup>	Элсний эзлэхүүн, мян.м <sup>3</sup>	Дундаж агуулга, мг/м <sup>3</sup>	Алтны нооц (Шлих), кг	Алтны нооц (Х.Цэвэр), кг
1	2-р улирал	4 сар	5.47	2.81	8.28		46.98	1.64	45.34	6.74	593	3.99	3.66
2		5 сар	10.93	Нөхөн дүүргэлт хийнэ.	10.93	7.0	93.97	3.28	90.7	13.47	593	7.99	7.31
3		6 сар	10.93		10.93	7.0	93.97	3.28	90.7	13.47	593	7.99	7.31
<b>Нийт</b>		<b>(4-6 сар)</b>	<b>27.33</b>	<b>2.81</b>	<b>30.14</b>	<b>7.0</b>	<b>234.91</b>	<b>8.20</b>	<b>226.7</b>	<b>33.68</b>	<b>0.59</b>	<b>19.97</b>	<b>18.3</b>
4	3-р улирал	7 сар	10.93	Нөхөн дүүргэлт хийнэ.	10.93	7.0	93.97	3.28	90.7	13.47	593	7.99	7.31
5		8 сар	10.93		10.93	7.0	93.97	3.28	90.7	13.47	593	7.99	7.31
6		9 сар	10.93		10.93	7.0	93.97	3.28	90.7	13.47	593	7.99	7.31
<b>Нийт</b>			<b>32.80</b>		<b>32.80</b>	<b>7.0</b>	<b>281.9</b>	<b>9.84</b>	<b>272.1</b>	<b>40.42</b>	<b>593</b>	<b>23.97</b>	<b>21.9</b>
7	4-р улирал		5.47		5.47	7.0	46.98	1.64	45.3	6.74	593	3.99	3.66
<b>Нийт</b>			<b>5.47</b>		<b>5.47</b>	<b>7.0</b>	<b>46.98</b>	<b>1.64</b>	<b>45.3</b>	<b>6.74</b>	<b>593</b>	<b>3.99</b>	<b>3.66</b>
<b>Нийт</b>		<b>(7-10 сар)</b>	<b>65.60</b>		<b>71.07</b>	<b>7.0</b>	<b>563.8</b>	<b>19.7</b>	<b>544.1</b>	<b>80.84</b>	<b>593</b>	<b>47.93</b>	<b>43.9</b>



**Зураг 4. Уулын ажлын төлөвлөлт**

**III.5.1. Уурхайн ажиллах горим**

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

Ордыг ил уурхайн аргаар дотоод овоолготой ашиглалтын системээр улирлын чанартай ашиглах юм. Баяжуулалтын технологиос хамааран уурхайн олборлолтын ажлыг улирлын чанартай явуулна. Уулын ажлыг газар гэсэх үеэс цас орох хүртэл буюу 4-сарын 1-ээс 11-р сарын 1 хүртэл явуулах боломжтой гэж үзлээ. Уулын бэлтгэл ажлыг 4-р сарын 10-ээс 30 хүртэл, хөрс хуулах ажлыг 5-сарын 01-оос 10-р сарын 1 хүртэл, элс олборлох ажлыг 5-р сарын 1-ээс 10-р сарын 1 хүртэл, элс угаах ажлыг 5-р сарын 10-ээс 10-р сарын 15 хүртэл явуулах боломжтой. Эхний 20 хоног бэлтгэл ажил хийгдэнэ. Тус орд нь улирлын чанартай ажиллах бөгөөд уулын ажил нь ашиглалтын жилд ойролцоогоор 6 сарын хугацаатай ажиллана.

Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 2 ээлжээр 12 цагаар ажиллана. Хоолны болон ээлж солилцох хугацаа ээлж тус бүрт 1 цагаар тооцов. Уулын ажлын горимыг дараахи хүснэгтэд үзүүлэв.

Үйлдвэрлэлийн бусад усан сан бүрдүүлэх, цахилгаан станц, насос суурилуулах, цахилгааны шугам татах, гэрэлтүүлэг, баяжуулах төхөөрөмж угсарч монтажлах г.м туслах ажлуудыг үйлдвэрийн тухайн үеийн ажлын зохион байгуулалтаар хийнэ.

**Хүснэгт 15. Ажлын горим**

№	Горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга	Тайлбар
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365	Жилийн хуанлийн хоног.
2	Өвлийн улирлын сул зогсолт	хоног	182	10-р сарын 15-ээс 4-р сарын 10-н хүртэл.
3	Жилийн ажиллах хуанлийн хоног	хоног	198	4-р сарын 10-ээс 10-р сарын 15-н хүртэл.
4	Баяр ёслолын амралт	хоног	7	Хөдөлмөрийн тухай шинэчилсэн найруулга хууль 97.1.4, 97.1.5, 97.1.6 тус тус заалтанд үндэслэсэн.
5	Цаг агаарын саатал	хоног	5	Байгалийн аюулт үзэгдэл.
6	Засвар үйлчилгээ	хоног	7	Төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус.
7	Бэлтгэл ажил	хоног	14	Уурхайн бэлтгэл ажлын хоног.
8	Хөрс хуулалтын ажлын хоног	хоног	165	Элсний давхаргыг нээх хугацаа тооцсон.
9	Элс олборлолтын ажлын хоног	хоног	165	Бодит хөрс хуулах ажлын хоног.
10	Элс угаах ажлын хоног	хоног	120	Бодит элс угаах ажлын хоног.
11	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	2	Хоногт ажиллах ээлжийн тоо.
12	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12	Ээлжиндээ уртасгасан цагаар 10 цаг ажиллана.
13	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.85	Бүтээлийн норм 85%-тай байна.
14	Нэг ээлжин дэх цэвэр ажлын цаг	цаг	10.2	Бодит нэг ээлжиндээ цэвэр ажиллах цаг.
15	Хоногт ажиллах бодит цаг	цаг	20	Бодит хоногт ажиллах цаг.
16	Жилд ажиллах бодит цаг	цаг	2448	Бодит жилд ажиллах цаг.

### III.5.2. Ил уурхайн нээлт

Уулын ажилд Их хуурай бүх блокууд өртөх бөгөөд алттай давхаргын зузаан ордын хэмжээнд хучаас хөрсний зузаан дунджаар 8.7 м орчим, элсний давхаргын зузаан дунджаар 0.96 м байна. Нөөцийн блокуудаас харахад ордын дундаж агуулга 593 мг/м<sup>3</sup> байна. Мөн ТЭЗҮ-ийг боловсруулахын өмнө Оюут цахир уул ХХК-ийн инженер, геологич нартай зөвшилцсөний үндсэн дээр Хуурай хэсгийн I-B'-2 блокоос уурхайн нээлтийн ажлыг эхлүүлэхээр төлөвлөлөө.

Уурхайн нээлтийн ажлаар 45.34 мян.м<sup>3</sup> хөрс хуулж уурхайн гадна талд түр овоолго үүсгэнэ. Нээлтийн ажлаар 6.74.м<sup>3</sup> элсийг олборлоно.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

Уурхайн ашиглалтын системээс хамаарч хөрсний шидэлт хийх үед нээгч малталт шаардлагагүй боловч элс олборлох үед тээврийн автосамосвалыг хөрсний доод түвшинд байршуулах шаардлагатай тул нээгч малталт байх шаардлагатай.

Нээгч траншейн байршлыг сонгохдоо:

- Нөөцийн хэсэгшлүүдийн блокуудын захад байршуулна, /байнгын траншей болох боломжийг ихэсгэнэ/
- Гадарга нам дор байх, /траншейн эзлэхүүн багасна /

Оюут цахир уул ХХК нь ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай дахь тогтоосон нөөцийг ашигласнаар нөөцийн урсацууд тус бүрийг хамарсан ухаш үүснэ. Карьерыг календарь төлөвлөгөөнд тусгасан дарааллаар ашиглана. Нээлт явуулах газрыг нөөц тогтоосон Хуурайн алт хэсгийн I-B'-2 блокийн хэсгээс нээж ашиглах бөгөөд тус хэсгийг олборлож дууссаны дараа Дэнж хэсгийн II-B'-1-5, блокуудад олборлолтын ажиллагаа үргэлжилж явагдахаар төлөвлөлөө.

Тухайн уурхайн малталт явуулахдаа үйлдвэрлэлийн нөөцийн блокийн хүрэнээс эхлэн хөрсийг экскаватороор ухаж шидэлт хийнэ. Хөрсний шидэлт хийхдээ эхний шидэлтүүдийг уурхайн хүрээ дагуулан түр овоолго хийж, элсний давхрагыг олборлоход чөлөөтэй дотор зай талбай ихссэн үед дотоод овоолгоор дүүргэлт хийн нөхөн сэргээлтээ хамт хийн уулын ажил явагдана. Экскаватор эхний шидэлтээр уурхайн хүрээний гадна түр овоолго хийж, элс олборлох орон зай үүссэний дараа техникийн нөхөн сэргээлт хийгдэн дотоод шидэлтээр дотоод овоолго үүсгэж явна.

### **III.5.3. Ил уурхайн уулын ажлын төлөвлөлт**

Бэлтгэл ажлын хүрээнд ил уурхай, технологийн ус болон хаягдлын далан, угаах төхөөрөмжийн талбайн шимт хөрсийг хуулах, баяжуулах үйлдвэрийн элсний нөөцийг бэлтгэх, далан болон баяжуулах үйлдвэрийн талбайг байгуулах угсрах зэрэг ажлууд орно.

Уурхайн үндсэн процесст хөрс хуулах, гадаад, дотоод овоолго үүсгэх, элс олборлож тээвэрлэн угаах скрубберт хүргэх, элс угаан баяжуулах зэрэг ажлууд багтана.

Уурхайн туслах ажлууд нь үндсэн процессын тасралтгүй ажиллагаа болон хэвийн ажиллах нөхцлийг хангахад чиглэсэн шимт хөрс хуулж хадгалах, зам талбай засах, тунаах нуур байгуулах зэрэг бусад ажлууд орно.

Шимт хөрсний овоолгыг төслийг хэрэгжүүлж дуусах явцад болон нөхөн сэргээлтийн ажилд хэрэглэнэ. Уг шимт хөрсний овоолгыг ил уурхайн хүрээг даган байршуулна.

Уурхайн ашиглалтын хугацаа нь 1 жил байх бөгөөд захиалагчийн саналын дагуу нөхөн сэргээлтийн ажлыг уулын ажлын хамт хийж гүйцэтгэнэ. Уурхайн техникийн болон биологийн нөхөн сэргээлт нь дотоод овоолготой байх учир хагас жилд багтана гэж үзлээ.

### **III.5.4. Уулын ажлын зохион байгуулалт**

Их хуурай алтны шороон ордыг ил аргаар, хөрсний тээвэртэй болон тээвэргүй хосолсон ашиглалтын системээр ашиглах бөгөөд уурхайд хөрс хуулж-овоолох, тээвэрлэж-овоолох, элс олборлох, олборлосон элсийг угаан баяжуулах гэсэн үндсэн процессууд явагдана. Мөн уурхайн ажлыг тасралтгүй хэвийн явуулахын тулд туслах ажлууд хийгдэнэ.

Уулын ажлын ахилт нь Хуурайн хэсгий I-B'-2 блокоос орлоор ахина. Хөрс хуулах болон элс олборлох ажлууд нь хоорондоо уялдаа хамааралтай дараалан хийгдэх учраас доголын хувьд орлын өргөн нь тэнцүү байна. Орлын зохистой өргөнийг ордын дундаж үзүүлэлт, ажиллах экскаваторын овор хэмжээсийг үндэслэн тооцов.


Хөрсийг түр гадаад овоолгоор байршуулсаны дараа элсийг олборлон ул чулуулагт хүргэж дотоод овоолго хийх ажлын талбай гармагц дотоод овоолгод хөрсийг хурааж ажиллах юм. Хөрс хуулалтын ажлын догол мөргөцөг нь 4-15 м хүртэл өндөртэй байна. Ил уурхайн уулын ажлын эхэн үед бульдозераар үржил шимт хөрсийг газрын гадаргаас ойролцоогоор 0.3 метрийн зузаантайгаар хуулж шимт хөрсний овоолгод байршуулсаны дараа



эксковатораар хөрсийг хуулж уурхайн гадна болон дотоод овоолго хийх ажил хийгдэнэ.

**Хүснэгт 16. Хуулах шимт хөрс хуулах талбайн хэмжээ ашиглалтын жилд**


Ашиглалтын жилүүд	Ил уурхай, БУ-н эвдрэлд өртөх талбай, м2	Зам, талбай, м2	Тосгон, м2	Бусад 5%	Нийт эвдрэлд өртөх талбай, м2	Хуулах шимт хөрсний хэмжээ, м3
1	65,600	22,400	10,000	5000	103,000	30,900
<b>НИЙТ</b>	65,600	22,400	10,000	5000	103,000	30,900




**Хүснэгт 17. Овоолгын төлөвлөлт**

Үзүүлэлт	Нэгж	Ашиглалтын жил	
		1 жил	Нийт
Нийт хуулах хөрс	мян.м3	563.79	563.79
Сийрэгжилт	-	1.3	1.3
Овоолгын эзлэхүүн	мян.м3	732.93	732.93
Гадаад овоолго буюу шимт хөрсний эзлэхүүн	мян.м3	25.61	25.61

Ил уурхайн ашиглалтын хугацаанд уурхайгаас сийрэгжилт тооцсоноор 25.61 мян.м<sup>3</sup> шимт хөрсийг уурхайн хүрээ дагуулан овоолж байршуулахаар байна.




Зураг 5. Тусгай зөврөөлийн хил



Зураг 6. Ил уурхайн дизайн

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024



**Зураг 7. Уурхайн эцсийн байдал /нөхөн дүүргэлт хийснээр/**

Уурхайн хөрс болон шимт хөрс хуулалт нь 732.93 мян.м.куб бөгөөд нийт олборлолтын явцад 813.77 мян.м.куб ухаш үүснэ. Олборлолт дууссаны дараа уурхайн ухашийг нийт хөрсөөр дүүргэлт хийж нөхөн сэргээлт хийнэ.

### **III.6. Үндсэн процесст ашиглах техник, тоног төхөөрөмж**

Тус ордыг 1 жилийн хугацаанд ашиглах тоног төхөөрөмжийн сонголтыг уурхайн хүчин чадал, олборлолтын хэмжээ, ордын тогтоцоос хамааруулж дараах байдлаар сонгож бүтээлийн тооцоог сар тус бүрээр хийлээ.

**Хүснэгт 18. Уурхайд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмжүүд**

Д.д	Тоног төхөөрөмж	Марк	Техникийн үндсэн үзүүлэлт	Суурилагдсан чадал, кВт	Тоо хэмжээ
1	Экскаватор	DOOSAN DX-520	3.2 м <sup>3</sup>	232	1
2	Экскаватор	DOOSAN DX-300	1.27 м <sup>3</sup>	205	1
3	Бульдозер	Shantui-SD32	4 м <sup>3</sup>	230/320	1
4	Өөрөө буулгагч	Howo-371	25тн	290	4

#### **III.6.1. Ухаж-ачих процесс**

##### Хөрс хуулах ажил

Их хуурай алтны шороон ордын хуулах хөрсний дундаж зузаан 8.7 м, уурхайн хүрээ хязгаар дахь хөрс хуулалтын коэффициент нь 7.0 м<sup>3</sup>/ м<sup>3</sup> байна. Энэ нь ашиглалтын эхэнд тодорхой хэмжээний дотоод орон зай үүссэний дараа дотоод овоолгод хөрсийг овоолж ажиллана. Хөрс хуулах ажилд DOOSAN DX-520 маркийн экскаваторыг ашиглаж автосамосвалд ухаж ачих, дотоод овоолго үүсгэн хөрсийг хуулах юм. Хуулах хөрсний хэмжээ ашиглалтын жилд 544.1 мян.м<sup>3</sup> байна.

Үржил шимт хөрс хуулалт: Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.2 метрээс багагүй зузаантайгаар бульдозероор хуулж, блоккийн талбайн хажуу зах руу түрэн, техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн хүрээ, технологийн замын гадна талд 2 м-ээс дээшгүй өндөртэй овоолго байгуулна.

Элс олборлолт: Элс олборлох ажил нь элсийг уурхайгаас элсний агуулахад олборлон, ачиж,

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

тээвэрлэх, элсний агуулахаас угаах төхөөрөмжийг элсээр хангах гэсэн процессуудаас бүрдэнэ. Олборлолтын доголд элсийг DOOSAN DX-300 экскаватороор ухаж автосамосвалд ачиж тээвэрлээд угаах талбайд хураах ба баяжуулах процесст оруулна. Элсний давхаргын зузаанаас хамаараад олборлолтын доголын өндөр нь хувьсах бөгөөд элсний давхарга 0.4-1.6 м-ийн хооронд хэлбэлзэнэ. Элсний давхаргын зузаан дээр хамгаалалтын цамцны доод болон дээд хүрээ 0.10 м нэмэгдэж доголын өндрийг тодорхойлно. Алт агуулсан элсний давхаргыг олборлох явцад улны хяналт, дээж авалтын ажлыг сайтар зохион байгуулж, үнэт металл алтны хаягдал бохирдлыг төлөвлөсний дагуу бага байлгах улмаар байгалийн нөөцийг аль болох бүрэн гүйцэд ашиглахыг эрмэлзэнэ. Уурхайн хүрэн дэх алттай элсний нөөцийн тооцоонд авсан үзүүлэлтүүд:

- Бохирдол – 27.95%

Бохирдол үүсэх гол шалтгаан нь алт агуулсан элсний үе дээр хамгаалалтын ул, тааз, хажуугийн хөрсийг нэмж тооцсоноос үүсэж байна.

Ил уурхайг нээх буюу эхлэх үед хучаас хөрсийг экскаватораар хуулж, олборлолтын талбайн гадна овоолго үүсгэнэ. Хөрс хуулалт болон элс олборлолтын ажил хийж тухайн хэсэгт тодорхой хоосон орон зай үүсгэх ба элсний давхаргыг олборлосны дараа дотоод овоолго хийх замаар хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэнэ.

### **III.6.2. Хөрс хуулалт, элс олборлолтын ажил**

#### Хөрс хуулалтын ажил

Хөрс хуулалт доголын өндөр нь хайгуулын ажлаар тогтоогдсон хөрсний давхаргын зузаанаас шалтгаалан 4-15.12 м байна. Хөрс хуулалтын ажилд DOOSAN DX-520LS маркийн урвуу утгуурт гидравлик экскаватор болон 33.3 м<sup>3</sup>-ийн тэвшний багтаамжтай Howo маркийн автосамосвалыг ажиллуулна. Хөрсний овоолго дээр Santui SD-32 маркийн бульдорзер 1 ш ажиллана.

Ашиглалтын жилд хуулах хөрсний хэмжээ жилд сийрэгжилт тооцсоноор 707.3 гадаад, дотоод овоолгод байршуулна.

#### Хөрс хуулалтад ажиллах экскаваторын бүтээлийн тооцоо

Экскаваторын ажлын цагийн  $Q_{эц}$  (м<sup>3</sup> / цаг) бүтээлийг тодорхойлоход 213.3 м<sup>3</sup>/цаг болж байна.

$$Q_{эц} = \frac{3600 * E * K_{уд} * K_{м} * K_{уч} * K_{ма} * K_{Б}}{t_{эм} * K_{с}}$$

энд: E - экскаваторын утгуурын багтаамж, м<sup>3</sup>

$K_{уд}$  - экскаваторын утгуур дүүргэлтийн коэффициент

$K_{с}$  - экскаваторын утгуур дахь чулуулгийн сийрэгжилтийн коэффициент

$K_{м}$  - мөргөцөгийн нөхцлийг тооцох коэффициент

$K_{уч}$  - Операторын ур чадварыг тооцох коэффициент

$K_{Б}$  - Техникийн бэлэн байдлын тооцох коэффициент

$K_{ц}$  - Цаг ашиглалтыг тооцсон коэффициент


2. Экскаваторын ээлжийн  $Q_{эх}$  (м<sup>3</sup>/хоног) бүтээлийг тодорхойлоход 2175.6 м<sup>3</sup>/ээлж байна.

$$Q_{эх} = Q_{эц} * N_{э} * T_{э} * K_{эц}$$



## Хүснэгт 19. Хөрс хуулалт ажиллах Dooson DX520LC экскаваторын

## техникийн үзүүлэлт

Д/Д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Dooson DX520LC	Загвар	
Техникийн үзүүлэлт					
1	Утгуурын багтаамж,	м <sup>3</sup>	3.2		
2	Утгуурын төрөл		Урвуу		
3	Хөдөлгүүрийн чадал	кВт	245.0		
4	Овор хэмжээ Урт	мм	11430		
	Өргөн	мм	3900		
	Өндөр	мм	4200		
5	Дундаж түлш зарцуулалт	л/цаг	46.6		
6	Түлшний савны багтаамж	л	620		
7	Масс	тн	50.7		
Ажлын хэмжээс					
8	Ачилт хийх хамгийн их өндөр	м	9.60		
9	Утгалтын хамгийн их гүн	м	6.77		
10	Утгалт хийх хамгийн их радиус	м	10.10		
11	Асгах өндөр	м	6.72		
12	Хамгийн их хурд	км/цаг	5.0-3.1		

Элс олборлолтын ажил

Элс олборлолтын доголын өндөр нь хайгуулын ажлаар тогтоогдсон элсний давхаргын зузаанаас шалтгаалан 0.4-1.6 м байна. Олборлолтын ажлыг экскаватор, автосамосвалын хослолоор ухаж-ачин, тээвэрлэж, угаах төхөөрөмжийн дэргэд элсний овоолго үүсгэн хураана. Элс олборлолтын ажилд DOOSAN DX-300 маркийн урвуу утгуурт гидравлик экскаватор болон 33.3 м<sup>3</sup>-ийн тэвшний багтаамжтай Howo маркийн автосамосвалыг ажиллуулна. Элсний овоолго дээр LUIGONG 856H маркийн утгуурт ачигч 1 ш ажиллана.

Элс олборлолтонд ажиллах экскаваторын бүтээлийн тооцоо

Экскаваторын ажлын цагийн  $Q_{эц}$  (м<sup>3</sup> / цаг) бүтээлийг тодорхойлоход 61.3 м<sup>3</sup>/цаг болж байна.

$$Q_{эц} = \frac{3600 * E * K_{уд} * K_m * K_{уч} * K_{ма} * K_B}{t_{эм} * K_c}$$


энд: E - экскаваторын утгуурын багтаамж, м<sup>3</sup>  
 $K_{уд}$  - экскаваторын утгуур дүүргэлтийн коэффициент  
 $K_c$  - экскаваторын утгуур дахь чулуулгийн сийрэгжилтийн коэффициент  
 $K_m$  - мөргөцөгийн нөхцлийг тооцох коэффициент  
 $K_{уч}$  - Операторын ур чадварыг тооцох коэффициент  
 $K_B$  - Техникийн бэлэн байдлын тооцох коэффициент  
 $K_c$  - Цаг ашиглалтыг тооцсон коэффициент

2. Экскаваторын ээлжийн  $Q_{эх}$  (м<sup>3</sup>/хоног) бүтээлийг тодорхойлоход 625.2 м<sup>3</sup>/ээлж байна.

$$Q_{эх} = Q_{эц} * N_э * T_э * K_{эц}$$

### Хүснэгт 20. Элс олборлолтонд ажиллах Dooson DX300 экскаваторын техникийн үзүүлэлт

Д/Д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Dooson DX300	
Техникийн үзүүлэлт				
1	Утгуурын багтаамж,	м <sup>3</sup>	1.27	
2	Утгуурын төрөл		Урвуу	
3	Хөдөлгүүрийн чадал	кВт	205	
4	Овор хэмжээ			
	Урт	мм	10620	
	Өргөн	мм	3200	
	Өндөр	мм	3345	
5	Дундаж түлш зарцуулалт	л/цаг	35.5	
6	Түлшний савны багтаамж	л	500	
7	Масс	тн	29.6	
Ажлын хэмжээс				
8	Ачилт хийх хамгийн их өндөр	м	7.26	
9	Утгалтын хамгийн их гүн	м	7.36	
10	Утгалт хийх хамгийн их радиус	м	6.81	
12	Хамгийн их хурд	км/цаг	5.0	



### Хүснэгт 21. Хөрс хуулалт, элс олборлолтод ажиллах экскаваторуудын бүтээлийн тооцоо

Д/Д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жил	
			Хөрс хуулалт	Элс олборлолт
<b>Экскаваторын марк</b>			<b>DOOSAN DX-520</b>	<b>DOOSAN DX-300</b>
1	Утгуурын багтаамж, м <sup>3</sup>	м <sup>3</sup>	3.2	1.27
2	Циклийн хугацаа	сек	25	32
3	Утгуур дүүргэлтийн коэффициент		0.90	0.90
4	Утгуур дахь чулуулгийн сийрэгжилтийн коэффициент		1.3	1.3
5	Цаг ашиглалтын коэффициент		0.9	0.83
6	Операторын ур чадвар тооцох коэффициент		0.92	0.9
7	Мөргөцгийн нөхцөл тооцох коэффициент		0.95	0.9
8	Шилжилт хөдөлгөөнийг тооцсон коэффициент		0.85	0.85
9	Техникийн бэлэн байдлыг тооцсон коэффициент		0.9	0.9
10	Экскаваторын цагийн бүтээл	м <sup>3</sup> /цаг	213.3	61.3
11	Ээлжийн бүтээл	м <sup>3</sup> /ээлж	2175.6	625.2
12	Хоногийн бүтээл	м <sup>3</sup> /хоног	4351.3	1250.4
13	Жилд ажиллах боломжит хоногийн тоо	хоног	165	165
14	Жилийн бүтээл	мян м <sup>3</sup> /жил	718.0	206.3
15	Уурхайн жилд гүйцэтгэх ажлын хэмжээ	мян м <sup>3</sup> /жил	544.1	80.8
16	Экскаваторын тоо	ш	1.0	0.5

Тооцоогоор уурхайн хөрс хуулалтад 1 ширхэг экскаватор, элс олборлолтод 1 ширхэг экскаватор байхад уурхайн хүчин чадлыг бүрэн хангаж ажиллахаар байна.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024


**III.6.3. Уурхайн тээвэр**

Ордын хувьд хэвтээ, хэвгий уналтай тул тээвэртэй дотоод овоолготой ашиглалтын системээр уулын ажлыг явуулахаар төлөвлөсөн. Ашиглалтын эхнээс ашиглагдсан хоосон орон зайг хөрс болон элс угаан баяжуулах цехээс гарах эфель, гаалиар нөхөн дүүргэлт хийж, уулын ажилтай зэрэгцэн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэнэ. Элс тээвэрлэлтэд HOWO 371 маркийн автосамосвал ажиллана.

Уурхайгаас олборлосон элсийг тээвэрлэхдээ гогцоо орлоор экскаваторын мөргөцөгт ачуулан угаан баяжуулах хэсэгт өгөх юм. Элсний мөргөцгөөс элсийг түр овоолгод хураах бөгөөд элсний овоолго харьцангуй суурин байх ба тээврийн зай элс олборлолтоос шалтгаалан өөрчлөгдөнө.

Уурхайн замд хурдыг 35 км/цагаар хязгаарлах бөгөөд уруудаж байгаа үед хурдны хязгаар 25 км/цаг байна. Ашиглалтын хугацаанд уурхайн зам нь авто тээврийг бүтээлтэй ажиллахад нөлөөлөх гол хүчин зүйл болдог. Иймээс уурхайн замд засвар үйлчилгээг тогтмол хийх шаардлагатай. Тээвэрлэлтийн үед үүсэх замын тоосыг зам услах зориулалтын машинаар тогтмол усалж, тоосгүйжүүлэх арга хэмжээг авч ажиллана.

**Хүснэгт 22. Howo 371 маркийн автосамосвалын техникийн үзүүлэлт**

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тэмдэг лэгээ	Howo-371	Загвар
Техникийн үзүүлэлт					
1	Тэвшний даац	тн	q	50	
2	Тэвшний багтаамж	м³	V	33.3	
3	Хөдөлгүүрийн чадал	кВт	W	371	
4	Тэвшний хэмжээ Урт	мм	a	6100	
		мм	b	2480	
		мм	h	3668	
5	Дундаж зарцуулалт түлш	л/цаг	Q	38	
6	Түлшний багтаамж савны	л	B	350	
7	Масс	тн	m	25	
8	Дугуйн тоо	ш	n	10	
Ажлын хэмжээс					
9	Дээд хурд	км/цаг	v	90	
10	Эргэх хамгийн бага радиус	м	r	21.4	

Элс тээвэрлэлтийн ажилд ашиглагдах автотээврийн сонголтыг хийхдээ ухаж ачих төхөөрөмжийн шанаганы багтаамж, тээврийн зай зэргээс хамаарсан тэвшний оновчтой геометр эзлэхүүнийг тодорхойлж автосамосвалын сонголтыг хийлээ. Авто тээврийн бүтээлд ачаа тээврийн зай, замын өгсүүр, уруу зэрэг нь гол нөлөөтэй байдаг. Уурхайн дотоод тээврийн бүтээлийг тооцохдоо уурхайн төлөвлөлтөөр тодорхойлогдож байгаа ашигт малтмал тээвэрлэх зайг дунджаар тооцлоо.

1. Автосамосвалд ачилт хийх экскаваторын утгалтын тоо

а) Тэвшний багтаамжаар

$$n_v = \frac{V_a * K_0}{E * K_{уд}}$$

$V_a$ - тэвшний геометр багтаамж

$K_0$  – тэвш дүүргэлтийг тооцсон коэффициент

$K_{уд}$ - экскаваторын утгуур дүүргэлтийг тооцсон коэффициент  
б) Техникийн даацаар

$$n_k = \frac{q_T * K_c}{E * \gamma * K_{уд}}$$

$K_c$ - чулуулгийн сийрэгжилтийн коэффициент, 1.2

$\gamma = 2.1 \text{ тн/м}^3$ - чулуулгийн эзлэхүүн жин,

Автосамосвалд ачилт хийж буй экскаваторын утгалтын тоо  $n$ -г дээрх хоёр хувилбарын аль багыг сонгож авна.

2. Автосамосвалын бодит даац

$$q_б = \frac{E * K_{уд} * \gamma * n}{K_c}$$

Даац ашиглалтын коэффициент

$$K_d = \frac{q}{Q}$$

Тэвшний багтаамж ашиглалтын коэффициент

$$K_T = \frac{n}{n_1}$$

1. Автосамосвалыг ачаалах хугацаа.

$\frac{q_a}{\gamma * V_a} * K_c = \frac{25}{2.1 * 14} * 1.25 = 1.06 \geq 1$  тул тэвш ашиглалтыг нөхцлөөр

$$t_a = \frac{V_a}{E} * t_{эм} * \frac{K_o}{K_{уд}}$$

3. Автосамосвалын Рейсийн хугацаа

$$T_p = t_{ач} + t_{хө} + t_б + t_x + t_c$$

$t_x$ - ачуулах хугацаа

$t_{хө}$ - автосамосвалын хөдөлгөөний хугацаа

$t_б$ - ачаа буулгах хугацаа,  $t_б = 0.5 \div 1.5 = 0.5$  мин

$t_x$ - ачих буулгахад хүлээх хугацаа,  $t_x = 1 \div 2 = 1.5$  мин

$t_c$ -сэлгээ хийх хугацаа,  $t_c = 1$  мин

$t_{ц}$ -экскаваторын циклийн хугацаа

4. Автосамосвалын хөдөлгөөний  $t_{хө}$  (сек) хугацаа.

$$t_{хө} = t_{ая} + t_{хя}$$

$t_{ая}$ ,  $t_{хя}$  – ачаатай ба хоосон чиглэлд явах хугацаа, сек

Автосамосвалын бүтээлийг тооцохдоо төлөвлөлтийн зургууд дээр уурхайн дотоод тээврийн замыг элс тээвэрлэх гэж хувааж тээврийн дундаж зайг тооцов.

### Хүснэгт 23. Автосамосвалын бүтээл, ажиллах мото цагийн үзүүлэлт

Д/Д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жилд элс тээвэрлэлт	Ашиглалтын жилд хөрс тээвэрлэлт
1	Тээврийн дундаж зай 1 талдаа	км	0.45	0.3
2	Автосамосвалын даац	тн	50	50
3	Тэвшний эзэлхүүн	м <sup>3</sup>	33.3	33.3
4	Экскаваторын шанаганы багтаамж	м <sup>3</sup>	1.27	3.2
5	Экскаваторын утгалтын тоо	утгуур	26	10
6	Автосамосвалыг ачаалах хугацаа	мин	14.0	4.3
7	Автосамосвалын дундаж хурд	км/цаг	25	20
8	Хөдөлгөөний хугацаа	мин	2.2	1.8
9	Ачаа буулгах, сэлгээ хийх, ачилтанд орох хугацаа	мин	2	3

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024



10	Рейсийн хугацаа	мин	18.2	9.1
11	1 цагт хийх рейсийн тоо	мин	3.3	6.6
12	Хоногийн үргэлжлэх хугацаа	мин	1440	1440
13	Хоногийн бүтээл	м3	2643.4	5251.5
14	Бүтээл нөлөөлөх хүчин зүйлүүд			
	- Жолоочийн ур чадвар тооцсон коэффициент		0.85	0.85
	- Техникийн бэлэн байдлыг тооцсон		0.80	0.80
	- Цаг ашиглалтын коэффициент		0.80	0.80
15	Хоногийн ашиглалтын бүтээл	м3	1438.0	2856.8
16	Жилд ажиллах өдөр	хоног	165	165
17	Автосамосвалын жилд ажиллах хоног Nж.э=Nж.а*Кт.а	хоног	165	165
18	Автомашинны жилийн бүтээл	мян.м3	237	471
19	<b>Уурхайн жилд тэвэрлэх уулын ажлын хэмжээ</b>	<b>мян.м3</b>	105.1	707.3
20	Автомашинны тооцооны тоо	ширхэг	0.4	1.5
21	Автомашинны бодит тоо(K= 1.2)	ширхэг	1	2
22	Автосамосвалын тоог тэвэрээр хангах нөхцөлөөр шалгавал /1 экскаваторт ноогдох автоасмосвалын тоо/	ширхэг	0.8	1.5
23	<b>Нийт автосамосвалын жилд ажиллах цаг</b>	<b>мото.ц</b>	<b>1461.5</b>	<b>4952.0</b>
24	<b>Нийт гүйлт</b>		<b>4346.4</b>	<b>19504.1</b>

Автосамосвалын мөчлөгийн хугацаа, мөргөцөгт сэлгээ хийх хугацаа болон экскаваторын ачих хугацаанаас хамааруулан нэг экскаваторыг бүрэн ачаалалтай ажиллуулах автосамосвалын тоог тодорхойлоход элс олборлолтод 1 ширхэг, хөрс хуулалтанд 2 ширхэг автосамосвал хангалттай байхаар харагдаж байна.

### III.6.4. Овоолгын ажил

Автотээвэр бүхий ил уурхайд овоолго байгуулах үйл ажиллагаанд бульдозер зонхилох байдлаар хэрэглэгдэнэ. Бульдозерын овоолго дээр хүнд даацын автосамосвалуудаар хөрс буулгах учраас уурхайн хажуугийн тогтворжилт, хамгаалалтын зурвасын параметруудийг зохих түвшинд барьж ажиллах шаардлагатай. Мөн буулгасан хөрсийг бульдозероор түрж шилжүүлж овоолох, овоолго дээрх авто замын ашиглалтын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх зэрэг ажилбарууд явагдана. Бульдозерын овоолго нь энгийн, хялбар технологитой бөгөөд харьцангуй хямд өртөг зардалтай байдгаараа давуу талтай. Хөрсний овоолгод Shantui фирмийн SD32 маркийн бульдозер ажиллана. Төног төхөөрөмжийн бүтээл, хэрэгцээний тооцоог доорх хүснэгтүүдэд үзүүлэв.

#### Үржил шимт хөрсний овоолго

Уурхайгаас нийт 25.61 мян.м<sup>3</sup> үржил шимт хөрсийг бульдозероор түрж овоолон уурхайн хилийн гадна уурхайн хүрээ дагуулан овоолно. Шимт хөрсний овоолгын өндрийг 2.0 м-ээс ихгүйгээр байгуулах ба стандартыг баримтлан ажиллана. Техникийн нөхөн сэргээлт хийсний дараагаар уурхайн олборлогдсон талбайн гадаргууд түрж тэгшлэн тарааж, нөхөн сэргээлтийн арга хэмжээг авч ажиллана.

#### Хөрсний овоолго

Төслийн ашиглалтын хугацаанд нийт 544.1 мян.м<sup>3</sup> хөрс хуулж дотоод овоолгууд үүсгэж ажиллана. Уурхайн ашигласан орон зайд дотоод овоолгыг үүсгэхдээ ахилтын араас

элсний давхаргыг дарахгүй байхаар асгалт болон шидэлт хийж явна. Энэ нь техникийн нөхөн сэргээлтийн ажлыг уулын ажилтай давхар явуулах боломж олгоно.

## Хүснэгт 24. Овоолгын төлөвлөлт

Үзүүлэлт	Нэгж	Ашиглалтын жил	Нийт
Хуулах хөрс	мян.м3	563.79	563.79
Сийрэгжилтийн коэфф	-	1.3	1.3
Овоолгын эзлэхүүн	мян.м3	732.93	732.93
Үүнээс: Гадаад овоолго буюу шимт хөрсний эзлэхүүн	мян.м3	25.58	25.58

Хөрсийг экскаватораар хуулж дотоод овоолгод шидэх бөгөөд түүнийг түрж тэгшлэх, дагтаршуулах ажлыг SD-32 Shantui маркийн бульдозероор гүйцэтгэнэ. Мөн хаягдал багатай олборлох үүднээс алттай элсийг олборлож дууссан талбайн улыг түрж бөөгнүүлэх, тээвэрлэгдэн ирсэн эфель гаалийг түрэх, туслах тоног төхөөрөмжүүдийг шилжүүлэн зөөх, уурхайн дотор зам засах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

## Хүснэгт 25. SD-32 Shantui маркийн бульдозерийн техникийн үзүүлэлт

Д/Д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	SD-32	Загвар	
Техникийн үзүүлэлт					
1	Хусуурын төрөл	-	SU		
2	Хөдөлгүүрийн чадал	кВт	235/320		
3	Овор хэмжээ Урт	м	6.88		
	Өргөн	м	4.13		
	Өндөр	м	3.725		
4	Хусуурын өргөн	м	4.13		
5	Хусуурын өндөр	м	1.59		
6	Ухах гүн	м	0.31		
7	Дундаж түлш зарцуулалт	л/цаг	14		
8	Түлшний савны багтаамж	л	600		
9	Масс	тн	38		
10					
Ажлын хэмжээс					
11	Хусуурын хамах чадвар	м³	4.03		
12	Ажиллаж болох налуу	градус	30		
13	Хөдөлгөөний хурд, хойшоо/урагшаа	км/цаг	6.6/7.8		

## 1. Овоолгын бульдозерийн цагийн бүтээл

$$Q_{бц} = \frac{60}{t_T} * S_{тп} * l_x * K_{ТТ} * K_c * K_x$$

$S_{тп}$  – түрэх призмийн хөндлөн огтлол, м<sup>2</sup> - 0.64

$t_T$  – түрэлт хийх хугацаа, мин - 1.2

$l_x$  – хусуурын урт, м - 3

$K_{ТТ}$  – түрэлт ашиглалтын коэффициент - 0.83

$K_c$  – сэлгээг тооцох коэффициент  $K_c = 0.8 \div 0.9 - 0.8$

$K_x$  – хаягдал тооцох коэффициент  $K_x = 0.94 \div 0.96 - 0.95$

Ээлжинд ажиллах цаг, цаг - 10

Хоногт ажиллах ээлж, - 2

Жилд ажиллах хоног -130

## 2. Овоолгын бульдозерийн ээлжийн бүтээл

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

$$Q_{бэ} = T * K_{ца} * Q_{бц}$$

$K_{ца}$  – Цаг ашиглалтын коэффициент

1. Овоолгын бульдозерийн хоногийн бүтээл

$$Q_{бх} = Q_{бэ} * n_э$$

- $n_э$  – Хоног дахь ээлжийн тоо

2. Овоолгын бульдозерийн жилийн бүтээл

$$Q_{эж} = Q_{эх} * n_ж$$

- $n_ж$  – жилд ажиллах хоногийн тоо

### Хүснэгт 26. Шимт хөрс хуулах, овоолго дээр ажиллах бульдозерийн бүтээлийн тооцоо

Д/Д	Үзүүлэлт	Х.н	Овоолго дээр	Шимт хөрс түрэх
1	Нэг цагийн турш овоолго дээр ачаа буулгах автосамосвалын тоо	ш	7	
2	Уурхайн нийт хөрс хуулалтын хэмжээ	мян м3	727.0	19.7
3	Цагт ногдох хөрс хуулалтын хэмжээ	м3/цаг	214.3	33.3
4	Овоолго дээр автосамосвал буулгалт сэлгээ хийх хугацаа	мин	1.2	1.2
5	Автосамосвалууд ачаагаа саадгүй буулгах овоолгын хэсгийн урт	м	25	25
6	Овоолгын фронтын нийлбэр урт	м	50	50
7	Автосамосвалын тэвшний өргөн	м	2.3	2.3
8	Автосамосвалаас буух чулуулгийн эзэлхүүн	м3	33.3	4.0
9	Овоолго дээр асгалтын дараа үлдэх үлдцийг тооцох итгэлцүүр	%	30%	100%
10	Асгацын хөндлөн огтлолын талбай	м2	14.493	1.739
11	Үлдэгдэл асгацад хамаарах чулуулгийн хөндлөн огтлолын талбай	м2	4.348	1.739
12	Дотоод овоолго дээр буух хөрсний хэмжээ	м3/цаг	214.3	33.3
13	Дотоод овоолго дээр гүйцэтгэх цагийн ажлын хэмжээ	м3/цаг	64.3	33.3
14	Сэлгээг тооцох итгэлцүүр	-	0.85	0.85
15	Хаягдал тооцох итгэлцүүр	-	0.85	0.85
16	Техникийн бэлэн байдлыг тооцсон итгэлцүүр	-	0.8	0.8
17	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.83	0.83
18	Операторын ур чадварыг тооцох итгэлцүүр	-	0.9	0.9
19	Түрэлт ашиглалтыг тооцох итгэлцүүр	-	0.8	0.8
20	Бульдозерийн шилжилт хөдөлгөөнийг тооцох итгэлцүүр	-	0.7	0.7
21	Овоолго дээр ажиллах бульдозерийн цагийн бүтээл	м3/цаг	476.2	247.5
22	Шаардлагатай бульдозерийн тоо /тооцооны/	ш	0.14	0.13
23	Шаардлагатай бульдозерийн тоо /бодит/	ш	1	1
24	<b>Шаардлагатай мото цаг</b>	<b>цаг</b>	<b>458.0</b>	<b>79.5</b>

Тооцоогоор шимт хөрс болон овоолго дээр 1 ширхэг бульдозерийг ажиллуулахад хангалттай байна.

#### III.6.5. Элс овоолох (агуулахын) ажил

Алттай элсийг угаах төхөөрөмжийн хажууд хураах бөгөөд, хураасан элсийг 3 м<sup>3</sup> утгуурын багтаамж бүхий Luigong 856H загварын утгуурт ачигчаар угаах төхөөрөмжийн хүлээн авах бункерт шууд өгнө. Утгуурт ачигчийн бүтээл болон элсний хэмжээнээс хамааруулан хэрэгцээний тооцоог хийхэд бункер дээр нэг утгуурт ачигч ажиллахад хангалттай гэж үзсэн.

#### Элс угаах процессын түслэх ажил

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

Угаах төхөөрөмжинд өгөгдсөн элс шигшүүрт орж угаан ангилагдах бөгөөд торны дээрх (+20 мм) хоосон чулуулаг нь конвейероор дамжиж том ширхэгтэй чулуулаг /галь/-ийн овоолгод хураагдана. Торны доорх (-20мм) ширхэглэлтэй алт агуулсан элс нам дүүргэлтийн шлюзэнд баяжигдана. Элсийг шлюзээр баяжуулж, хүнд металл шлюзийн ховилд тунаж, ялгаран гарах хөнгөн материал эфелийг тунаах нуур руу урсгах ба эфель урсах суваг шуудууг байнга засварлаж ажиллана.

Элсний овоолгыг шуух, эфель урсах сувгийг засах, эфель, гаалийг түрэх зэрэг ажлыг утгуурт ачигчаар гүйцэтгэнэ.

### Хүснэгт 27. Баяжуулах хэсэгт Luigong 856H ажиллах утгуурт ачигчийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Х.н	Үзүүлэлт
1	Хөдөлгүүрийн чадал	кВт	207
2	Масс	тн	17.2
3	Утгуурын багтаамж	м <sup>3</sup>	3.0
4	Хөдөлгөөний их хурд, хойшоо/урагшаа	км/цаг	38-25
5	Утгуурын өргөн	м	2.97
6	Ачигчийн урт	м	8.39
7	Ачигчийн өндөр	м	3.5
8	Асгах их өндөр	м	2.97
10	Асгах зай	м	1.2
11	Эргэлтийн радиус	м	6.2
12	Ухах гүн	м	0.05
13	Түлшний банк	л	280



### Хүснэгт 28. Luigong 856H маркийн утгуурт ачигчийн бүтээлийн тооцоо

Д/Д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жил
1	Ачигчийн утгуурын багтаамж	м <sup>3</sup>	3
2	Утгуур дүүргэлтийн коэфф	-	0.95
3	Нэг цикл хийх хугацаа	сек	35
4	Нэг циклд хийх бүтээл	м <sup>3</sup>	2.9
5	1 цагт хийх циклийн тоо	цикл	102.9
6	Техникийн цагийн бүтээл	м <sup>3</sup> /цаг	293.14
7	Цагийн ашиглалтын бүтээл	м <sup>3</sup> /цаг	168.9
8	Бүтээл нөлөөлөх хүчин зүйлүүд		
	- Жигд бус ажиллагааг тооцсон коэффициент	-	0.85
	- Техникийн бэлэн байдлыг тооцсон коэффициент	-	0.8
	- Операторын ур чадварыг тооцсон коэффициент	-	0.9
	- Цаг ашиглалтын коэффициент	-	0.8
9	Хоногийн бүтээл	м <sup>3</sup> /хоног	3377
10	Жилд ажиллах хоног	хоног	130
11	Утгуурт ачигчийн жилд ажиллах хоног	хоног	83
12	Жилийн бүтээл	мян.м <sup>3</sup>	280
13	Уурхайн жилийн ажлын хэмжээ	мян.м <sup>3</sup>	105.1
14	Ачигчийн тооцооны тоо		0.4
15	Ачигчийн д (Ē=1.2)		0.5
16	Ачигчийн жилд ажиллах цаг	мото.цаг	622

Элс угаах төхөөрөмжийг тэжээхэд Luigong 856H маркийн утгуурт ачигчийг ажиллуулна.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024



**Хүснэгт 29. Нийт мот.цагийн тооцоо**

Д/Д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жилийн
1	Уулын цул	мян.м <sup>3</sup>	624.9
2	Хөрс хуулалт	мян.м <sup>3</sup>	544.1
3	Элс олборлолт	мян.м <sup>3</sup>	80.8
4	Хөрс хуулах экскаваторын ажиллах шаардлагатай мото цагийн үзүүлэлт	мото цаг	3316.3
5	Элс олборлох экскаваторын ажиллах шаардлагатай мото цагийн үзүүлэлт	мото цаг	1714.5
6	Элс угаах төхөөрөмж тэжээх ажиллах шаардлагатай мото цагийн үзүүлэлт	мото цаг	622
7	Хөрсний овоолго дээр ажиллах бульдозерийн мото цаг	мото цаг	458.0
8	Шимт хөрс хуулах бульдозерийн мото цаг	мото цаг	99.4

**III.6.6. Хаягдлын сан /Тунаах болон цэвэр нуур байгуулах ажил/**

Ордын уул техникийн нөхцөлд тохируулан тунаах далан болон цэвэршүүлэх даланг байгуулахаар төлөвлөсөн. Далан тус бүрийг хөрсөөр тусгаарлаж хуучин уурхайн ухаш үүсэн газрыг ашиглан тунаах далангаас ус цэвэршүүлэх далан руу урсан орохоор төлөвлөлөө. Тунаах болон цэвэршүүлэх далангийн гүн дунджаар 2.5-3 м байна.

Нууруудын далангийн хана /их бие/-г хөрсний дотоод овоолгоор буюу хөрсний чулуулгийн асгалтаар хийх, ингэхдээ далангийн дотор шаварлаг материалаар хийх шаардлагатай.

Галь болон эфельд зарцуулах усны алдагдал, ууршилт зэргийг тооцож тунаах болон цэвэршүүлэх далангийн усны нийт нөөцийг 10 хоногийн нөөцтэйгээр тооцож далангийн талбайг тооцсон.

- Тунаах нуур-1 далангийн талбай = 2000 м<sup>2</sup>
- Тунаах нуур-2 далангийн талбай = 3500 м<sup>2</sup>
- Цэвэршүүлэх далангийн талбай = 3900 м<sup>2</sup>

**БҮЛЭГ IV. БАЯЖУУЛАЛТЫН ТЕХНОЛОГИ****IV.1. Ордын элсийг угаан баяжуулсан технологийн туршилт**

Дэнжийн хэсэг, Хуурай, Чулуут алтны шороон ордоос Оюут цахир уул ХХК-аас ирүүлсэн алтны шороон ордын 267 кг дээжинд хийсэн петрограф, физик механикийн шинжилгээний үр дүнд үндэслэн гүйцэтгэсэн алт агуулагч элсний баяжигдах чанарын технологийн туршилтууд, түүний бүтээгдэхүүнд хийсэн шинжилгээний үр дүнг нэгтгэн дүгнэлт гаргасан байна. Үүнд:

1. Бодисын найрлагын судалгаа, дүгнэлт
2. Гравитацийн аргаар баяжигдах чанарын туршилт шинжилгээ дүгнэлт хийсэн байна.

**IV.1.1. Бодисын найрлагын судалгааны дүгнэлт**

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших “Их хуурай” алты шороон ордын дээжийн бодисын найрлагын судалгаанаас харахад дараах дүгнэлт гарч байна. Үүнд:

1. Хуурайгийн дээд хэсгийн алтны шороон талбайд хийсэн хээрийн судалгаагаар +

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

100 мм -ээс +3 мм хүртлэх ангилалд боржингийн бүлгийн чулуулгууд, боржин, боржин-диорит, габбро-диорит; занар, элсэн чулуу, алевролит зэрэг чулуулгийн хэмхэдэс зонхилж байгаа бол +2.5 мм-ээс доошхи ангилалд хээрийн жонш, кварц зэрэг эрдэсийн хэмхэдэс зонхилж байна.

- Алт нь: Алтан шаргал өнгөтэй аяа ногоовтор шар туяатай, зонхилох мөхлөг нь дунд зэрэг мөлгөржилттэй, алтны ихэнх мөхлөгийн гадаргуу тэгшивтэр, хааяа овон товон, нүх сүвэрхэг бөгөөд зарим мөхлөг кварц болон төмрийн усан исэлтэй ургалт үүсгэсэн, төмрийн усан ислээр хучигдсан байх тохиолдол ажиглагдана.

*Мөхлөгийн хэмжээ:* Алтны мөхлөг нь 0.1x0.1; 3x1.5 мм зэрэг янз бүрийн хэмжээтэй мөхлөгтэй боловч 3x1.5 мм-ийн хэмжээтэй мөхлөг зонхилдог болох нь тогтоогдсон байна. Орд нь бага гүний ордод хамаарах ба геологийн тогтоц, гарал үүсэл, ашиглалт явуулах нөхцөлөөрөө Хуурай чулуутын алтны ордтой адилхан ба III бүлгийн орд юм.

#### IV.1.2. Алт агуулсан элсний угаагдах шинж чанар

Алтны шороон ордын элсний угаагдах чанарыг тодорхойлоход ОХУ-ын ЦНИГРИ-д боловсруулсан аргачлалыг ашигласан байна. Элсний угаагдах чанарыг дараах томъёогоор тодорхойлно.

$$E = \frac{K\gamma_1}{\gamma_2 W}$$

- энд: К - сорьцон дахь-0.125 мм-ийн хэсгийн уян налархайн тоо;  
 $\gamma_1$  - сорьцон дахь -0.125 мм-ийн ширхэгтэй хэсгийн гарц;%  
 $\gamma_2$ - сорьцон дахь +20 мм-ийн ширхэгтэй том хэсгийн гарц; %  
 W - анхдагч элсний элслэг хэсгийн чийглэг, %-иар;

Төрөл бүрийн алттай элс угаагдах чанараараа

$K < 1$  бол хялбар угаагдах,

$1 \leq K \leq 1.5$  бол дунд зэргийн угаагдах,

$K > 1$  бол хүнд угаагдах шинж чанартай хэмээн ангилагддаг.

Тус ордын элсний сорьцын угаагдах чанарыг дараах хүснэгтэнд харуулав.

#### Хүснэгт 30. Элсний сорьцын угаагдах шинж чанарын үзүүлэлтүүд

№	Сорьцын физик- механикийн үзүүлэлтүүд	Үзүүлэлтүүдийн хэмжээ
1	K	0
2	$\gamma_1$	2.01
3	$\gamma_2$	16.53
4	W	7.44
5	E	0

Сорьцын угаагдах шинж чанарыг тодорхойлох коэффициент  $1 < K$  байгаа нь ордын алт агуулсан элс сайн угаагдах ангилалд хамрагдаж байна.

#### IV.1.3. Алт агуулсан элсийг баяжуулсан технологийн туршилтын үр дүн

Их хуурай алтны шороон ордын элсний баяжигдах чанарын судалгааны туршилтыг гравитацийн аргаар баяжуулах туршилт явуулсан байна. Алтан шаргал өнгөтэй аяа ногоовтор шар туяатай, зонхилох мөхлөг нь дунд зэрэг мөлгөржилттэй, алтны ихэнх мөхлөгийн гадаргуу тэгшивтэр, хааяа овон товон, нүх сүвэрхэг бөгөөд зарим мөхлөг кварц болон төмрийн усан исэлтэй ургалт үүсгэсэн, төмрийн усан ислээр хучигдсан байх тохиолдол

ажиглагдана. Алт нь хэлбэрийн дараах байдлаар ангилагддаг.

- хумхиа хэлбэрийн алт 50%
- хуудаслаг хэлбэрийн алт 40%
- ялтаслаг хэлбэрийн алт 10%

Хуурай чулуутын алтны шороон ордын дээд хэсгээс хайгуулын үед авсан технологийн дээжийн алтны ширхэг мөхлөгийн судалгааг дараах хүснэгтүүдэд үзүүлэв.

Авсан газар	Хэмжих нэгж	Алтны мөхлөг ангилалаар /мм/					Бүгд
		-0.125	0.25+0.125	0.5+0.25	1.0+0.5	-2.0+1	
Тех	гр	15.0	212	257	206	84	794
туршилт	%	1.9	26.7	34.9	25.9	10.6	

Туршилтаар гарсан алтанд шигшүүрийн шинжилгээ хийхэд нийт алтны 88% нь  $+0.5-3$  мм-ийн ангилалд, жижиг мөхлөг болох  $-0.25$  мм нь 12% байна.

Уг ордын алтны элэгдлийн зэрэг нь сайн, том, дунд ширхэг мөхлөгтэй алт зонхилж, жижиг тоосонцор алт бага хувьтай байгаа болон шаварлаг хольц бага, усанд уусан задрах чанараар сайн байгаа явдал нь бидний хийсэн хагас үйлдвэрийн туршилтын үр дүн, алт агуулагч хурдасны бүтэц бүрэлдэхүүн зэргээс шалтгаалан Скруббер бутара 80 маркийн тоног төхөөрөмжийн тусламжтайгаар баяжуулалтаар олборлож болохыг үйлдвэрийн туршилтаар харуулж байна.

Алт агуулагч элс нь угаагдах чанараар сайн зэрэглэлд хамаарагдах ба уг ордын сэвсгэр хурдас нь уулын чулуулгын агуулагч давхаргад бул чулуу ховор тохиолдоно. Хучдас хурдсанд болон алт гольдролдоо гол, горхины усны татралт урсалтын нөлөөгөөр хэрхэн хуримтлагдан бий болсон байдал нь тод ялгагддаг. Уг хурдасны нягтралшилт сайн учир олборлолтын үед карьерийн хананд нуралт, гулсалт бага тохиолдох сайн талтай.

Иймд: Гравтацийн аргаар баяжуулахад  $-20$  мм-ийн ангиллын дээжийг шлюзээр баяжуулсан. Харин  $+20$  мм-ийн ангилалд бүхэл алт байгаа эсэхийг хянаж, усаар угааж шламыг нь  $-20$  мм-ийн ангилалд нийлүүлэн лабораторийн нөхцөлд зориулсан гар хийцийн шлюз ашиглан туршилтын ажлыг гүйцэтгэсэн болно. Шлюзын баяжуулалтаар баяжмал ба хаягдал гэсэн 2 төрлийн бүтээгдэхүүн гарган авсан. Шлюзны баяжмалыг сэгсрэх ширээгээр гүйцээн баяжуулж, гарсан баяжмалыг минералогийн хаягдал гэсэн 2 төрлийн бүтээгдэхүүн гарган авсан.

Шлюзны баяжмалыг сэгсрэх ширээгээр гүйцээн баяжуулж, гарсан баяжмалыг минералогийн шинжилгээнд өгч алтыг ялгуулан, шигшүүрийн шинжилгээ хийлгэн, ангилал тус бүрийн жинг авсан болно. Харин шлюзны хаягдлыг  $2$  мм-ийн шигшүүрээр шигшиж,  $-2$  мм-ийн ангиллыг сэгсрэх ширээгээр баяжуулан, хаягдалд алдагдсан алтыг ялган авч минералогийн шинжилгээ хийсэн. Туршилтын схемийг зураг 10-г, шлюз болон сэгсрэх ширээгээр баяжуулсан туршилтын үр дүнг



Зураг 8. Дээжийг шлюз болон сэгсрэх ширээгээр баяжуулах туршилтын схем

**Хүснэгт 31. Алт агуулсан анхдагч дээжийг шлюз болон сэгсрэх ширээгээр баяжуулсан туршилтын үр дүн**

Бүтээгдэхүүний нэр	Гарц,%	Алтны агуулга, гр/тн	Металл авалт,%
20 мм-ээс том ширхэглэлтэй анги	83.81	0.707	-
20 мм-ээс бага ширхэглэлтэй анги	16.19	0	100
<b>Бүгд</b>	<b>100</b>	<b>0.07</b>	<b>100</b>
<b>1. Тунахаар баяжуулах -20 мм</b>			
Шлюзны баяжмал	2.98	18.52	93.1
Хаягдал	92.07	0.04	6.9
20 мм-ээс бага ширхэгтэй хэсэг	95.05	0.71	100
<b>2. Шигшүүр 2 мм</b>			
+2 мм	1.43	0.14	0
-2 мм	29.05	0.89	92.6
<b>Шлюзны баяжмал</b>	<b>2.98</b>	<b>1.04</b>	<b>92.6</b>
<b>3. Сэгсрэх ширээ</b>			
Ширээний баяжмал	0.56	1000	92.6
Ширээний хаягдал	0.87	0	0.
- 2 мм	1.4		92.6

Хуурайн алт агуулсан элсийг шлюз болон сэгсрэх ширээ ашиглан баяжуулахад 0.14%-ийн гарцтай, 92.6% металл авалттай шлихийн алт гарган авсан байна.

**Дүгнэлт:**

1. Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут ам, Хуурайн дэнж, Хуурайн гүн алтны шороон ордын дээж нь цахиржиж, карбонатжсан кварц-хээрийн жонш-биотитот занар, метаморфжсон алевролитлог жижиг-дунд ширхэгт аркоз элсжингээс тогтжээ.
2. Тухайн ирүүлсэн дээж нь уян налархай чанаргүй байгаа учир сайн угаагдах ангилалд хамаарагдаж байна.
3. Технологи туршилтын ажлыг гравитацийн аргаар хийж гүйцэтгэсэн. Туршилтын

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024



үр дүнд 0.14%-ийн гарцтай, **92.6%** металл авалттай баяжмал гарган авч болохыг тогтоов. Алтны дундаж агуулгыг тооцон үзэхэд 0.59 г/т буюу 1.8 г/м<sup>3</sup> байна.

4. Туршилтаар гарсан нийт алтанд минералогийн шигшүүрийн шинжилгээ хийхэд алтны мөхлөгийн ихэнх нь -0.25+3 мм-ийн ангилалд байна.
5. Дээрхи туршилтын үр дүнг үндэслэн захиалагчид зураг 11-д үзүүлсэн скруббер болон шлюз, гүйцээн баяжуулалтанд сэгсрэх ширээ хосолсон схемийг санал болгож байна.
6. Захиалагчид санал болгож буй схемийг зураг дараах зурагт харуулав.



Зураг 9. Захиалагчид санал болгож буй схем

## IV.2. Баяжуулах технологийн сонголт, үндэслэл

Төсөлд элс угаан баяжуулах цехийн технологийн шийдлийг тусгахдаа элс олборлолтын төлөвлөгөө болон Геологийн төв лабораторид гүйцэтгэсэн технологийн туршилтын үр дүн болон угаах төхөөрөмж дээр хийгдсэн сорьцлолтын ажлын тайланд үндэслэсэн. Элс угаах төхөөрөмжийн хувьд хүндийн хүчний тоног төхөөрөмжүүдийг ашиглана. Монгол улсад ихээхэн ашиглагдаж байгаа хоригт цоргоны хослол болох Скруббер бутара 80 төхөөрөмжийг ажиллуулна.


### IV.2.1. Угаан баяжуулах элсний тооцоо ба хүчин чадал

Элс угаан баяжуулах үйлдвэр нь ашиглалтын жилд сийрэгжилт тооцсоноор 105 мян.м<sup>3</sup> элс угаан баяжуулах бөгөөд улирлын чанартай явагдана.

Угаан баяжуулах цех нь хоногт 12 цагаар 2 ээлжтэй 5 сарын 10-наас 10 сарын 15 хүртэл хугацаанд ажиллана.

### IV.2.2. Технологийн горим

Ил уурхайгаас ирэх алт агуулсан -20 мм ширхэглэлтэй элсийг Скруббер бутара 80 угаах төхөөрөмжөөр сайтар угааж, 20 мм ширхэглэлтэй тороор шигшиж, торны дээд бүтээгдэхүүнийг бул чулууны овоолгод, харин торны доорх бүтээгдэхүүнийг хоригт цоргоор баяжуулна. Цаашдын баяжуулалтанд хоригт цорго, баяжуулах ширээ, сэгсрэх ширээ, гар тэвш ашиглана.



**Зураг 10. Элс угаан баяжуулах технологийн схем**

Элс хүлээн авах бункер дахь алт агуулагч элсийг даралттай усаар буудан скрубберт оруулан скрубберт 20 мм-ээр ангилж, +20 мм -ийн ангиллыг галийн овоолгод хурааж, -20 мм-ийн ангиллын элсийг нам дүүргэлтийн хоригт цорго болон хяналтын хоригт цорго рүү тэжээнэ.

Хяналтын хоригт цорго дээр тогтсон баяжмалыг гүйцээн баяжуулна. Гүйцээн баяжуулахад ирсэн баяжмалыг баяжуулах ширээгээр баяжуулна. Баяжуулах ширээний баяжмалыг гар тэвшээр гүйцээн баяжуулжшлихийн алтыг авна.

Гүйцээн баяжуулах цехийн баяжуулах ширээний хаягдал өөрийн урсгалаар хаягдлын санд хуримтлагдана. Харин хоригт цорго болон хяналтын хоригт цоргын хаягдал нь тунаах даланд өөрийн урсгалаар урсан орно. Тунаах даланд хуримтлагдах эфелийн овоолгыг бульдозероор түрж эфелийн овоолго руу хураана. Тунаах нууранд тунасан усыг цэвэршүүлэх далан руу тунаан технологийн эргэлтийн ус болгон ашиглана.

#### **IV.2.3. Технологийн тооцоо**

Элс угаан баяжуулах технологийн тооцоогоор технологийн оновчтой горим, тоног төхөөрөмжийн хүчин чадал, тэдгээрийн сонголт, технологид зарцуулагдах усны хэмжээ, бүтээгдэхүүн гаргалтыг тооцоолов. Элс угаан баяжуулах цех нь уурхайн төлөвлөлтийн дагуу 80.8 мян.м<sup>3</sup> элс, сийрэгжилт тооцооноор 105 мян.м<sup>3</sup> элс угаан баяжуулах юм.

Элс угаах ажилд LUIGONG 856H маркийн утгуурт ачигчаар элсээ угаан баяжуулах Скруббер бутара СБ80 маркийн скруббер төхөөрөмжийг тэжээнэ. Элс угаах ажлын боломжит хоног, угаах төхөөрөмжийн ашиглалтын бүтээлийг харгалзан үзвэл:

Уурхайд ажиллах угаах төхөөрөмжийн цагийн хүчин чадал:

$$Q_{ц} = \frac{Q_{сар}}{T \cdot m \cdot n} = 38 \text{ м}^3/\text{цаг}$$

Энд:

- $Q_{жил}$  - Жилийн хүчин чадал, м<sup>3</sup>/сар  
 $T$  - Жилд ажиллах хугацаа, хоног  
 $m$  - Хоногт ажиллах ээлжийн тоо  
 $n$  - Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг

Баяжуулах технологи - хүндийн хүч /Скруббер, хоригт цорго, сэгсрэх ширээ, гар тэвш,  
 Баяжуулах хэсгийн ажиллах горимыг дараах хүснэгтэд харуулав.

### Хүснэгт 32. Баяжуулах хэсгийн ажлын горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Төслийн нийт хуанлийн өдөр	өдөр	159
2	Сул зогсолт	хоног	15
3	Жилд ажиллах бодит хоног	хоног	144
4	Өдрийн хуанлийн цаг	цаг	24
5	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
6	Өдрийн ээлж	ээлж	2
7	Цаг ашиглалтын коэффициент	%	80
8	Өдөрт ажиллах бодит цаг	цаг	19.2
9	Жилд ажиллах бодит цаг	цаг	2,765
10	Цагийн хүчин чадал, м <sup>3</sup> /цаг	м <sup>3</sup> /цаг	38.01
11	Хоногийн хүчин чадал, м <sup>3</sup> /хоног	м <sup>3</sup> /хоног	730
12	Жилийн хүчин чадал, м <sup>3</sup> /жил (сийрэгжилт тооцсоноор)	м <sup>3</sup> /жил	105,092

#### IV.2.4. Тоо-чанарын тооцоо

Технологийн тоо-чанарын тооцооллоор баяжуулах технологийн тоног төхөөрөмж бүр дэх бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлов. Тоо-чанарын тооцоог ордын элсийг угаан баяжуулсан технологийн туршилтын тайлан, сорьцлолтын ажлын тайлангийн үр дүнг ашиглан боловсруулав.

Тоо-чанарын схемийн тооцоог хийхэд дараах томъёог ашиглав.

- Баяжуулалтын бүтээгдэхүүний металл авалт:

$$\varepsilon_n = \frac{\gamma_n * \beta_n}{\alpha}$$

- Бүтээмж:

$$Q_n = \frac{Q_{цаг} * \gamma_n}{100}$$

- Бүтээгдэхүүний баланс:

$$\begin{cases} \gamma_{анх} = \gamma_{бая} + \gamma_{хая} \\ \gamma_{анх} \alpha = \gamma_{бая} \beta + \gamma_{хая} \theta \end{cases}$$

энд: n-үйлдлийн дугаар

$\varepsilon$ -металл авалт, %

$\gamma$ -гарц, %

Q-бүтээмж, м<sup>3</sup>/цаг


Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

$\alpha, \beta, \theta$ -анхдагч хүдэр, баяжмал, хаягдлын агуулга

Технологи туршилтын ажлыг гравитацийн аргаар хийж гүйцэтгэхэд ордын дээж нь 92.6% -ийн металл авалттай баяжмал гарган авах бөгөөд алтны сорьцыг 915.2 нэгж гэж тогтоосон.

Дэнж, Хуурай, Чулуутын алтны шороон ордын технологийн туршилтын үр дүнд металл авалт 92.6% байсан. Тоо-чанарын тооцоонд бүтээгдэхүүний гарц, бүтээгдэхүүний металл авалтыг технологийн туршилтын үр дүнгээс авсан. Технологийн тооцооллыг гүйцэтгэсний дараа гарц болон металл авалт, массын балансыг шалгахад гарц болон металл авалтын тэгшитгэл нь балансалж байна. Иймд скруббер-хоригт цоргоор баяжуулах ширээ гэсэн техник тоног төхөөрөмжийг төсөлд сонгон авсан





Элс баяжуулах технологийн тоо-чанарын схем

Технологийн тоо-чанарын тооцооны үр дүнг 33-р хүснэгтэнд харуулав.

**Хүснэгт 33. Ашиглалтын жилийн тоо-чанарын тооцооны үр дүн**

Орсон					Гарсан				
Бүтээгдэхүүний нэр	Q, м <sup>3</sup> /цаг	Au, г/м <sup>3</sup>	γ, %	ε, %	Бүтээгдэхүүний нэр	Q, м <sup>3</sup> /цаг	Au, г/м <sup>3</sup>	γ, %	ε, %
Скрубберээр угаан ангилалт									
Анхдагч элс	<b>38.01</b>	<b>456.077</b>	<b>100.00</b>	<b>100.00</b>	-20мм-ийн ангиллын бүтээгдэхүүн	31.86	544.18	83.81	100.00
					+20мм-ийн ангиллын бүтээгдэхүүн	6.15	-	16.19	-
Нийт	<b>38.01</b>	-	<b>100.00</b>	<b>100.00</b>	Нийт	<b>38.01</b>	-	<b>100.00</b>	<b>100.00</b>
Гүн дүүргэлтийн шлюзээр баяжуулах									
-20мм-ийн ангиллын бүтээгдэхүүн	31.86	544.18	83.81	100.00	Шлюзийн баяжмал	0.513	30,911.86	1.35	91.50
					Шлюзийн хаягдал	31.34	47.01	82.46	8.50
Нийт	<b>31.86</b>	-	<b>83.81</b>	<b>100.00</b>	Нийт	<b>31.86</b>	-	<b>83.81</b>	<b>100.00</b>
Нам дүүргэлтийн шлюзээр баяжуулах									
Шлюзийн хаягдал	31.34	47.01	82.46	8.50	Хяналтын шлюзийн баяжмал	0.46	1,136.31	1.20	2.99
					Хяналтын шлюзийн хаягдал	30.89	30.93	81.26	5.51
Нийт	<b>31.34</b>	-	<b>82.46</b>	<b>8.50</b>	Нийт	<b>31.34</b>	-	<b>82.46</b>	<b>8.50</b>
Сэгсрэх ширээгээр баяжуулах									
Шлюзийн баяжмал	0.51	30,911.86	1.35	91.5	Шлихийн алт	<b>0.0083</b>	<b>1,930,000</b>	<b>0.0218822</b>	<b>92.6</b>
Хяналтын шлюзийн баяжмал	0.46	1,136.31	1.2	2.989795918	Сэгсрэх ширээний хаягдал	<b>1.0</b>	-	<b>2.53</b>	<b>1.9</b>
Нийт	<b>0.97</b>	-	<b>2.55</b>	<b>94.49</b>	Нийт	<b>0.97</b>	-	<b>2.55</b>	<b>94.49</b>
Тунаах далан									
Хяналтын шлюзийн хаягдал	30.89	30.93	81.26	5.510204082	Тунаах даланд	31.85	40.28	83.79	7.40
Сэгсрэх ширээний хаягдал	0.96	-	2.53	1.89					
Нийт	<b>31.85</b>	<b>0.000</b>	<b>83.79</b>	<b>7.40</b>	Нийт	<b>31.85</b>	<b>40.280</b>	<b>83.79</b>	<b>7.40</b>

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024

**IV.2.5. Ус-булингийн тооцоо**

Элс угаан баяжуулах үйлдвэрийн технологийн ус-шлагын схемийн тооцоо нь технологийн шат дамжлага бүр дэх бүтээгдэхүүний чанарын болон тоон үзүүлэлтүүдийг тодорхойлж өгдөг бөгөөд тооцооны үр дүнд ажиллагаа бүрд нэмж өгөх усны хэмжээ, гаднаас авах цэвэр усны хэмжээ, технологийн ус ашиглалт зэрэг чухал үзүүлэлтүүдийг гарган авдаг. Бүтээгдэхүүний тоон үзүүлэлтэнд булингийн эзэлхүүн, бүтээгдэхүүн дэх ус болон элсний хэмжээ орох бол чанарын үзүүлэлтэнд бүтээгдэхүүний шингэн хатуугийн харьцаа, шингэрц, хатуулаг зэрэг ордог.

Элс угаан баяжуулах цехийн технологийн ус-булингийн тооцоогоор  $1\text{м}^3$  элс угаан баяжуулахад зарцуулагдах ус, технологийн шат дамжлага бүрт нэмэх ус, цэвэр усны хэмжээ, технологийн ус ашиглалтын коэффициент зэргийг тооцож гаргалаа.

Ус-булингийн тооцооны үр дүн нь угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмжийн тооцоо сонголтыг хийх үндсэн өгөгдөл болсон.

Ус-булингийн тооцоог доорх томъёонуудыг ашиглаж гүйцэтгэв:

- ▶ Бүтээгдэхүүний шингэрц,  $\text{м}^3/\text{цаг}$ 

$$R_n = \frac{(100 - S_n)}{S_n}$$
- ▶ Бүтээгдэхүүн дэх усны хэмжээ
$$W_n = R_n * Q$$
- ▶ Булингийн эзлэхүүн,  $\text{м}^3/\text{цаг}$ 

$$V_n = Q_n + W_n$$
- ▶ Бүтээгдэхүүний хатуулаг
$$S_n = \frac{100}{1 + R_n}$$

энд:  $R$  –  $1\text{ м}^3$  элсэнд нэмж өгөх усны хэмжээ


$S$  – Бүтээгдэхүүний чийглэг, %

$W$  - Үйлдэл тус бүрт нэмж өгч буй усны хэмжээ,  $\text{м}^3/\text{цаг}$

$V$  – Булингийн эзлэхүүн,  $\text{м}^3/\text{цаг}$

$n$  - Үйлдлийн дугаар

Технологийн ус-шлагын схемийн үр дүнг дараах нэгтгэсэн хүснэгт болон зурагт үзүүлэв.



Зураг 11. Элс баяжуулах технологийн ус-шлагын схем

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024



## Хүснэгт 34. Ашиглалтын жилийн ус шламын нэгдсэн хүснэгт

Орсон					Гарсан				
Бүтээгдэхүүний нэр	Q, тн/цаг	γ, %	W, м <sup>3</sup> /цаг	V, м <sup>3</sup> /цаг	Бүтээгдэхүүний нэр	Q, тн/цаг	γ, %	W, м <sup>3</sup> /цаг	V, м <sup>3</sup> /цаг
<b>Угаан баяжуулалтын хэсэг</b>									
<b>Анхдагч хүдэр</b>	38.01	100.00	6.7	29.1	-20мм-ийн ангиллын бүтээгдэхүүн	31.86	83.81	150.50	169
Угаах төхөөрөмжийн хатуулаг тохируулах ус	-		145	145	+20мм-ийн ангиллын бүтээгдэхүүн	6.15	16.19	1.5	5.2
<b>Нийт</b>	<b>38.01</b>	<b>100</b>	<b>152</b>	<b>174</b>	<b>Нийт</b>	<b>38.01</b>	<b>100</b>	<b>152</b>	<b>174</b>
-20мм-ийн ангиллын бүтээгдэхүүн	31.9	83.8	150.5	169.24	Шлюзийн баяжмал	0.51	1.35	0.627	0.93
					Шлюзийн хаягдал	31.3	82.46	149.88	168.31
<b>Нийт</b>	<b>31.9</b>	<b>83.8</b>	<b>150.5</b>	<b>169.24</b>	<b>Нийт</b>	<b>31.9</b>	<b>83.8</b>	<b>150.5</b>	<b>169.24</b>
Шлюзийн хаягдал	31.34	82.46	149.88	168.31	Хяналтын шлюзийн баяжмал	0.46	1.20	0.557	0.826
					Хяналтын шлюзийн хаягдал	30.9	81.26	149.3	167.49
<b>Нийт</b>	<b>31.3</b>	<b>82.5</b>	<b>149.9</b>	<b>168.3</b>	<b>Нийт</b>	<b>31.3</b>	<b>82.5</b>	<b>149.9</b>	<b>168.31</b>
<b>Гүйцээн баяжуулах хэсэг</b>									
Шлюзийн баяжмал	0.51	1.35	0.63	0.93	<b>Шлихийн алт</b>	<b>0.0083176</b>	<b>0.0218822</b>	<b>0.00066469</b>	<b>0.00555739</b>
Хяналтын шлюзийн баяжмал	0.46	1.20	0.56	0.83	Сэгсрэх ширээний хаягдал	0.96	2.53	3.88	4.44
Баяжуулах ширээний хатуулаг тохируулах ус			2.69	2.69					
<b>Нийт</b>	<b>0.969</b>	<b>2.55</b>	<b>3.88</b>	<b>4.45</b>	<b>Нийт</b>	<b>0.969</b>	<b>2.55</b>	<b>3.88</b>	<b>4.45</b>
Хяналтын шлюзийн хаягдал	31	81.26	149	167	Тунаах далангийн ус	-	-	139.55	139.55
Сэгсрэх ширээний хаягдал	0.961	2.53	3.88	4.44	Эфелийн овоолгод үлдэх ус	31.85	83.79	13.65	32.38
<b>Нийт</b>	<b>31.8</b>	<b>83.8</b>	<b>153.2</b>	<b>172</b>	<b>Нийт</b>	<b>31.8</b>	<b>83.8</b>	<b>153.2</b>	<b>172</b>
Тунаах далангийн ус	-	-	139.55	139.55	Эргэлтийн ус	-	-	118.6	118.6
					Эргэлтийн усан санд үлдэх ус	-	-	20.93	20.93
<b>Нийт</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>139.55</b>	<b>139.55</b>	<b>Нийт</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>139.55</b>	<b>139.55</b>

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024

**Хүснэгт 35. Ашиглалтын жилийн усны балансын тооцоо**

Усны балансын тооцоо				
№	Орсон		Гарсан	
	Үйлдэл	м <sup>3</sup> /цаг	Бүтээгдэхүүн	м <sup>3</sup> /цаг
1	Анхдагч элсэн дэх ус	6.71	Бүтээгдэхүүнд гарах ус	0.00066469
2	Скрубберт орох ус	145.34	Гальд гарах ус	1.538
3	Сэгсрэх ширээнд орох ус	2.692	Эфельд гарах ус	13.65
4			Эргэлтийн ус	118.61
5			Эргэлтийн усан санд үлдэх ус	20.93
<b>Нийт</b>		<b>154.74</b>		<b>154.74</b>
<b>Баланс</b>				<b>-</b>

Баяжуулах технологийн ус-булингын тооцооны үр дүнд технологид шаардагдах усны хэрэгцээг тооцов.

**Хүснэгт 36. Угаан баяжуулалтанд хэрэглэгдэх усны зарцуулалт**

Усны зарцуулалтын тооцоо(Скруббер)		
№	Үзүүлэлт	Утга
1	1 м <sup>3</sup> элс угаахад шаардагдах технологийн усны зарцуулалт, м <sup>3</sup>	<b>4</b>
2	1 м <sup>3</sup> элс угаахад шаардагдах цэвэр усны зарцуулалт, м <sup>3</sup>	<b>0.8</b>
3	Угаан баяжуулахад орж байгаа ус, м <sup>3</sup> /цаг	148.03
4	Угаан баяжуулахаас гарч байгаа ус, м <sup>3</sup> /цаг	118.61
5	Технологийн ус ашиглалтын коэффициент, %	<b>80.13</b>
6	Угаан баяжуулах үйлдвэрийн хэрэгцээтэй усны хэмжээ, л/сек	<b>8.17</b>

Хаягдлын цөөрөмд эфель тунаж, цэвэршсэн усыг эргүүлэн технологид ашиглана. Угаалга эхлэхэд технологийн усан хангамжийг Шарын голоос голоос бүрэн хангах ба үйлдвэрлэлийн явцад усан хангамжийн 80%-ийг эргэлтийн усаар хангаж, үлдсэн 20%-ийг усыг цэвэр усаар нөхөн сэлбэхээр тооцов.

Хэнтийн нуруунаас эх авсан Шарын гол нь Хуурай алтны шороон ордын урд талаар урсдаг, тайван урсгалтай 0.5-0.8м/сек, гольдролын өргөн нь 5.0м, гүн нь 0.6-1.0м, мөн түүний баруун цутгал болох Хуурайгийн гол нь түр зуурийн урсгалтай ба судалгааны талбайн зүүн өмнөд хэсгийг дайран өнгөрдөг бөгөөд цас борооны үед урсац нь 0.5-2.0м/сек хүрдэг. Хуурайгийн гол дээд эхэн хэсэгтээ байнгын урсгалтай ба дунд хэсэгтээ ирээд урсгал нь гүн руугаа шурган ордог ба манай тусгай зөвшөөрөлтэй талбайд байнгын урсгал байхгүй.

Ус нь цэнгэг эрдэсжилт нь 0.17-0.22г/л, хатуулаг нь 1.2-3.2 мг/экв, ундны ба техникийн усны шаардлагыг хангадаг. Иймд ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэгцээнд бүрэн ашиглах боломжтой юм.

Баяжуулах цех нь нийт 105.0 мян.м<sup>3</sup> элс угаан баяжуулна. Баяжуулах цех нь ашиглалтын хугацаанд нийт 81.3 мян.м<sup>3</sup> ус цэвэр ус ашиглахаар төлөвлөсөн. Баяжуулах цехийн усны хэрэглээг харуулбал:

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

**Хүснэгт 37. Элс баяжуулахад шаардагдах усны хэмжээ**

Ашиглалтын хугацаа, сараар	Баяжуулах элс, м <sup>3</sup>	Технологид шаардлагатай ус, м <sup>3</sup> /жил	Эргэлтийн ус, м <sup>3</sup> /жил	Зарцуулагдах цэвэр усны хэмжээ, м <sup>3</sup> /жил
1 жил	<b>105,092.00</b>	409,266.37	327,946.06	81,320.3
<b>Нийт</b>	<b>105,092.00</b>	<b>409,266.37</b>	<b>327,946.06</b>	<b>81,320.31</b>

Шлюзэн дээр тунасан баяжмалыг 24 цагт 1 удаа, тодорхой комиссын бүрэлдэхүүнтэйгээр (харуулын хяналтанд) султган авна.

Угаах төхөөрөмжөөс баяжмал авах ажлыг шлюзны доороос дээш секц тус бүрийн трафаретийг сөхөж, хуримтлагдсан баяжмал бүхий элсийг тусгай зориулалтын малтуур хүрээр хутган авч тусгай зориулалтын торхонд хийж, резинийг устай торхонд маш нарийн нямбай угааж баяжмалтай торхнуудыг машинд ачиж гүйцээн баяжуулах цех рүү хүргэх буюу шлюзийн дэвсгэрийг займчин зайлах замаар гар аргаар багасган бохир баяжмалыг ялгаж авдаг.

Шлюзнээс султган авсан бохир баяжмалыг харуулын хяналтан доор гүйцээн баяжуулах цехэд аваачиж, гар тэвшээр ялгаж, хар шлихийг соронздож, хатааж, үлээн алтыг гарган авна.

**IV.3. Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөлт**

Ил уурхайгаас олборлосон алт агуулагч элсийг угааж ангилан 20 мм-ээс дооших ангилалын элсийг нам дүүргэлтийн шлюзийн баяжмалын сэгсрэх ширээгээр угаан баяжуулж 92.6 %-ийн металл авалттайгаар шлихийн алтыг гаргана. Төслийн нийт хугацаанд 915.2 сорьцтой, элсэн дахь алтыг хими цэврээр 40.62 кг алт гаргана. Алт гаргалтын төлөвлөгөөг доорх хүснэгтэд үзүүлэв.

**Хүснэгт 38. Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө**

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
<b>Ил уурхайгаас</b>			
1	Олборлох элс, м <sup>3</sup> (Уулын цулаар)	мян.м <sup>3</sup>	<b>80.84</b>
2	Элсэн дэх алтны агуулга /шлихээр/	мг/м <sup>3</sup>	<b>592.96</b>
3	Элсэн дэх алт /шлихээр/	кг	<b>47.93</b>
4	Элсэн дэх алт /химийн цэврээр/	кг	<b>43.87</b>
5	Алтны сорьц		<b>915.20</b>
<b>Угаан баяжуулах үйлдвэр</b>			
6	Жилд ажиллах бодит цаг	цаг/жил	<b>2,764.80</b>
7	Угаан баяжуулах элс, м <sup>3</sup> (Сийрэгжилт тооцсоноор)	м <sup>3</sup>	<b>105.09</b>
8	Элсэн дэх алтны агуулга /шлихээр/	мг/м <sup>3</sup>	<b>456.08</b>
9	Элсэн дэх алтны агуулга /химийн цэврээр/	мг/м <sup>3</sup>	<b>417.40</b>
10	Элсэн дэх алт, кг (шлихээр)	кг	<b>47.93</b>
11	Элсэн дэх алт, кг (хими цэврээр)	кг	<b>43.87</b>
12	Алт авалт	%	<b>92.60</b>
13	Баяжуулсан алтны хэмжээ /шлихээр/	кг	<b>44.38</b>
14	Баяжуулсан алтны хэмжээ /хими цэврээр/	кг	<b>40.62</b>
15	Хаягдал дахь алт авалт	%	<b>7.40</b>
16	Хаягдал дахь алтны хэмжээ /шлихээр/	кг	<b>3.55</b>
17	Хаягдал дахь алтны хэмжээ /хими цэврээр/	кг	<b>3.25</b>

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

**IV.4. Хаягдал гаргалтын тооцоо**

Баяжуулах хэсгийн хаягдал нь төслийн нийт хугацаанд боловсруулалтаас гарч буй эфелийн нийт хэмжээ 153.33 мян.м<sup>3</sup> байна. Доорх хүснэгтэд төслийн нийт хугацаанд хаягдах хаягдлын хэмжээг тодорхойлов.

**Хүснэгт 39. Элсийг угаан байжуулах үйлдвэрийн хаягдлын хэмжээ**

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нийт
Угаах элсний хэмжээ (Сийрэгжилт тооцсоноор)	м3	105,092
Эфелийн гарц	%	83.79
Хаягдалд гарах эфелийн хэмжээ	м3	88,055
Хаягдал эфелд үлдэх усны хэмжээ	м3	65282
Хаягдал эфелийн нийт хэмжээ	м3	153,337

**Хүснэгт 40. Баяжуулах хэсгийн усны хэрэглээ**

Ашиглалтын хугацаа, сараар	Баяжуулах элс, м <sup>3</sup>	Технологид шаардлагатай ус, м3/жил	Эргэлтийн ус, м3/жил	Зарцуулагдах цэвэр усны хэмжээ, м <sup>3</sup> /жил
Ашиглалтын жил	105,092.00	409,266.37	327,946.06	81,320.3
<b>Нийт</b>	<b>105,092.00</b>	<b>409,266.37</b>	<b>327,946.06</b>	<b>81,320.3</b>


Алт агуулсан элс баяжуулалтаас гарч буй хаягдал нь +20 мм ширхэглэлтэй галь, -20 мм ширхэглэлтэй эфель байна. Уг ордын элсийг баяжуулахад ямар нэгэн химийн хортой бодис ашиглахгүй тул гарч буй шингэн хаягдлыг тунаах нуурын тусламжтай тунгааж цэвэршүүлэн, үйлдвэрлэлийн процесст эргэлтийн усны журмаар эргүүлэн ашиглана. Ордын

элсийг усаар задлахад гарах булингын тунах хурд хурдан, шаврын агууламж багатай.

**IV.5. Баяжуулах хэсгийн тоног төхөөрөмжийн сонголт, тооцоо**

Тоног төхөөрөмжийн тооцоо, сонголтыг хийхдээ ус-шлагын тооцооллын үр дүнд гарсан цагт ачааллах материалын хэмжээ, хатуу шингэний харьцаа, ширхэглэлийн шинжилгээний үр дүнг үндэслэн захиалагчаас санал болгосон одоо ажиллаж байгаа тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, технологийн шаардлагыг мөрдлөг болгосон.





Зураг 12. Баяжуулах технологийн тоног төхөөрөмжийн холболтын схем

Төсөл хэрэгжүүлэгчийн техникийн даалгаварт заасны дагуу Скруббер-бутара СБ80 маркийн скрубберийн иж бүрдэл 1 ширхэгийг ажиллуулахаар төсөлд тусгалаа.



Зураг 13. Скруббер-бутара СБ80 маркийн баяжуулах төхөөрөмж

**Хүснэгт 41. Хоригт цоргын ажиллын горим**

д.д	Үзүүлэлт	Нэгж	Нийт
1	Угаах элс	мян.м3	80.8
2	Сийрэгжилт тооцсоноор угаах элс	мян.м3	105.0
3	Скруббер иж бүрдэл	тн/цаг	80
4	Техникийн бэлэн байдлыг тооцсон коэффициент		0.85
5	Жилд ажиллах цаг	цаг	2765
6	Жилд ажиллах хоног	хоног	144

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

Скрубберын сонголтын тооцоо:

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Дэнж, Хуурай, Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордын элсийг Скруббер-бутара СБ80 маркийн шороон ордуудад хэрэглэдэг угаах төхөөрөмжийг ашиглана. Уг төхөөрөмж нь бункер, угаах агрегат, шлюз, насосны станц зэргээс бүрдэнэ. Угаах төхөөрөмж нь хоногт 20 цаг ажиллах ба Х:Ш= 1:4 харьцаагаар тохируулан баяжуулах үйл ажиллагаа явагдана. Угаах төхөөрөмжийн бункерыг утгуурт ачигчаар тэжээн, угаасны дараа +20 мм ангилалын бүтээгдэхүүн хаягдаж галийн овоолго үүсгэнэ. Харин -20 мм ангилал шлюзэнд орж баяжигддаг. Ийнхүү угаах үйл ажиллагаа тасралтгүй 24 цаг явагдсаны дараа шлюзийн баяжмалыг (ойролцоогоор 1 м<sup>3</sup>) авч гүйцээн баяжуулах цехэд ахин баяжуулж цэвэр металлыг гарган авна.

$$Q_{\text{цаг}} = \frac{Q_{\text{ж.мах}} \cdot k_{\text{ж}}}{T \cdot m \cdot n \cdot k_{\text{ц}}} = \frac{80.8 \cdot 1.25}{119 \cdot 2 \cdot 10 \cdot 0.85} = 49.92 \text{ м}^3/\text{цаг}$$

Үүнд:

$T$  - Жилд ажиллах хоног

$m$  - ээлжийн тоо

$n$  - ээлжийн үргэлжлэх хугацаа

$k$  - Тоног төхөөрөмжийн цаг ашиглалтын коэффициент

$Q_{\text{хүчин чадал}} = Q_{\text{ск}} \cdot k = 49.92 \cdot 0.85 = 42.43 \text{ м}^3/\text{цаг}$

**Хүснэгт 42. Хоригт цоргын техникийн үзүүлэлт**

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо утга	Зураг
Скруббер-бутара СБ80				
1	Барбаны диаметр	мм	1400	
2	Скрубберын налуу	градус	0-60	
3	Бүтээмж	тн/цаг	70-100	
4	Цахилгаан зарцуулалт	кВт	2-22	
5	Овор хэмжээ	мм	9800x2100 x3200	
6	Жин	тн	10.0	

Шлюзны сонголтын тооцоо:

Тэжээлийн ширхэглэл: -20 > мм

Материал тунах талбайг дараах байдлаар олно.

$$F = \frac{V}{A} = \frac{80}{1.14} = 70 \text{ м}^2$$

Энд:

$F$  -Тунах талбай м<sup>2</sup>

$V$  -Хатуу хэсгийн эзлэхүүнээр бодсон хүчин чадал, м<sup>3</sup>/цаг

$A$  - нэгж ховилын ёроолын талбайг хатуу хэсгийн эзлэхүүнийг үндэслэн хүчин чадал, м<sup>3</sup>/м<sup>2</sup> · цаг

$A$  нь туршилтын үзүүлэлт, шороон ордын алтыг баяжуулахад дундаж

$A = 0.5 \sim 1.25$

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

Тунах талбайг бодож гаргасны дараа шлюзны ховилын урт болон өргөнийг тооцоолон гаргана.

$$h = a \cdot d = 1.8 \cdot 20 = 36$$

Энд:  $a$  - урсгалын гүний коэффициент


$d$  - мөхлөгийн хамгийн том ширхэглэлийн хэмжээ, мм

#### Хүснэгт 43. Материалын ширхэглэлээс хамаарсан шлюзны тооцооны параметрууд

Үзүүлэлтүүд	Хамгийн том ширхэглэлийн хэмжээ, мм						
	6	6-12	12 - 25	25-50	50 -100	100-00	>200
Эзлэхүүнээр	6-8	8-10	10 -12	12-14	14-16	16-20	>20
Урсгалын хурд м/с	1-1.2	1.2 -1.6	1.4 -1.8	1.6-2.	1.8 -2.2	2-2.5	2.5-3.0
Урсгалын гүний коэффициент	2.5-3.0	2.0-2.2	1.7-2.0	1.5-1.7	1.3-1.5	1.2-1.3	1.0-1.2

Шлюзны налууугийн өнцөг алтны шороон ордыг баяжуулахад  $5-8^\circ$  хооронд байна

#### Хүснэгт 44. Нам дүүргэлтийн шлюзийн техникийн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга	Зураг
Тавцангийн талбай	м <sup>2</sup>	12.8	
Жин	тн	2.6	
Овор хэмжээ (өргөн, урт)	мм	1600x8000	
Тоо	ш	2	
Тавцангийн налууугийн өнцөг	градус	2- 16	

*Сэгсрэх ширээний сонголт, тооцоо:*

Сэгсрэх ширээг алт агуулсан 3–0.04 мм бүхэллэгтэй хүдэр /элс/ -т өргөн хэрэглэдэг. Тавцангийн налуу, угаах усны зарцуулалт, тавцангийн явалтын урт ба далайцын тоо, хүчин чадал зэргийг ширээ ажиллаж байх үед тохируулж болно. Сэгсрэх ширээнд цагт 0.01 м<sup>3</sup> материал очих ба захиалагчид байгаа СКО-0.5 сэгсрэх ширээг ашиглана. Баяжуулах ширээ нь шаардлагат хүчин чадлыг хангах эсэхийг доорх томъёогоор тодорхойллоо.

$$Q = 0.1 * \delta_{\text{хүдэр}} \left[ F * d \frac{(\delta_{\text{хүнд}} - 1)}{(\delta_{\text{хөн}} - 1)} \right]^{0.5}$$

Энд:  $Q$  -Баяжуулах ширээний бүтээмж,тн/цаг

$d_{\text{дун}}$  -Бүхэллэгийн дундаж диаметр,мм

$\delta_{\text{хүдэр}}$  -Хүдрийн нягт,г/см<sup>3</sup>

$F$  -Баяжуулах тавцангийн талбай,м<sup>2</sup>

$\delta_{\text{хүнд}}$  -Хүнд эрдсийн нягт,г/см<sup>3</sup>

$\delta_{\text{хөн}}$  -Хөнгөн эрдсийн нягт,г/см<sup>3</sup>

$$Q = 0.1 \times 1668 * \left[ 0.5 * 2 * \frac{19.3 - 1}{1.8 - 1} \right]^{0.5} = 1.098 \text{ тн/ц}$$

Хувийн бүтээмжийг ойролцоогоор дараах томъёогоор олно.

$$q = 0.2 \cdot d_{\text{max}} = 0.2 \cdot 2 = 0.4$$

#### Хүснэгт 45. Сэгсрэх ширээний техникийн үзүүлэлт

Д/Д	Үзүүлэлт	СКО-0.5
1	Бүтээл, тн/цаг	0.04- 4
2	Тэжээлийн ширхэглэл, мм	0.2-2.0


Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

3	Тавцангийн хэлбэр	трапец	
4	Тавцангийн талбай, м2	1.0	
5	Тавцангийн хөдлөх давтамж, мин-1	0.6-16.0	
6	Хөдөлгүүрийн чадал, кВт	1.1	
7	Эргэх давтамжийн тоо, мин-1	920	
8	ЛxВxН, мм	2625x690x420	
9	Жин, кг	207	
10	Ашиглагдах тоо, ширхэг	1	
11	Үйлдвэрлэсэн улс, он	Хятад, 2020	

Усан хангамжийн тоног төхөөрөмж сонголт, тооцоо:


Баяжуулах цехийн усан хангамжийн хэсэгт технологийн ус болон шаардлагатай цэвэр усыг шахах насосыг ажиллуулна. Шороон ордын угаах баяжуулах технологийн хамгийн гол төхөөрөмж нь насос юм. Усан хангамжид одоо ашиглагдаж байгаа насосуудыг үргэлжлүүлэн ашиглах бөгөөд тунаах, цэвэршүүлэх далангаас ус татах мөн цэвэр ус татахад ашиглана.

#### Хүснэгт 46. R150-ES-06 насосны техникийн үзүүлэлт

Д/Д	Үзүүлэлт	R150-ES-06	Зураг
1	Хүчин чадал, м3/цаг	20-38	
2	Өргөх өндөр, м	48-78	
3	Эргэлтийн хурд, эрг/мин	2850	
4	Хөдөлгүүрийн чадал, кВт	1.5	
5	Суурьлагдах тоо, ширхэг	2	

#### Хүснэгт 47. Эргэлтийн усны насосны техникийн үзүүлэлт

##### ЭЦВ12-250-105

Д/Д	Үзүүлэлт	ЭЦВ12-250-105	Зураг
1	Хүчин чадал, м3/цаг	250	
2	Өргөх өндөр, м	105	
3	Эргэлтийн хурд, эрг/мин	3000	
4	Хөдөлгүүрийн чадал, кВт	2*55	
5	Суурьлагдах тоо, ширхэг	2	

#### Хүснэгт 48. Баяжуулалтад ашиглах тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмжийн нэр	Төрөл	Хэмжих нэгж	Тоо, ш	Хөдөлгүүрийн чадал, кВт
1	Угаан баяжуулах төхөөрөмж	Скруббер-бутара СБ80	м <sup>3</sup> /цаг	1	11
2	Баяжуулах ширээ	СКО-0.5	-	1	-
3	Эргэлтийн усны насос	ЭЦВ12-250-105	-	2	55
4	Цэвэр усны насос	SB4x3-13	-	1	1.5

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024



## IV.6. Хаягдлын сан

Угаан баяжуулах цехийн хаягдал /шлам/ хадгалах тунаах, цэвэршүүлэх байгууламжийг байгуулах талбайн ургамлын өнгөн хөрсийг хуулж, зөөж овоолсны дараа далангийн суурийг сайтар тэгшилж, нягтруулж бэлдэнэ. Нуур далан байгуулах талбай нь харьцангуй тэгшивтэр буюу бага зэргийн хэвгий тул далангийн овоолго хийх хөрсийг сангийн эргэн тойронд тойруулан жигд тарааж тэгшлэх ба уг ажлыг далан нуурын ухашнаас гарсан хөрсөөр гүйцэтгэнэ. Далангийн овоолгод ашиглах хөрсний ширхэглэлийн хамгийн том хэмжээ нь 150 мм-ийн диаметртэй байна. Хаягдал /шлам/ хадгалах байгууламжийн сангийн ёроолоос шавар хөрсийг ялган авч, далангийн дээд ирмэгийн налуу дээр буулган, хэвтээ чиглэлд 5м өргөн, 0.3м зузаан үеэр тарааж нягтруулан шавар үеийг хийнэ. Далангийн дээд ирмэгийн налуу дээр хийх шавар үеийн зузаан нь далангийн налуутай перпендикуляр чиглэлт 1 м-ээс багагүй зузаан байна. Шавар үед ашиглах хөрсний хамгийн том ширхэглэл нь 5 мм-ээс бага байна.

Нуур даланг хавсралт зурагт заасны дагуу бохир усны /шламтай ус/, цэвэр усны гэсэн хэсэгтэй хийх ба дунд нь тусгаарлах далан байна. Тусгаарлах далан нь уурхай ашиглалтын жил ахих тусам өндөрлөгдөж явах ба далангийн тодорхой хэсэг усыг шүүх бүтэцтэй бүдүүн нарийн хайрга хийгдэнэ. Мөн тусгаарлах далад халианы хоолой суулгаж өгнө.

Хаягдлын усан сангийн эзлэхүүнийг тооцохдоо угаан баяжуулах цехийн үйл ажиллагааг тасралтгүй 7 хоног хангах боломжийг бүрдүүлэхээр төлөвлөсөн.

$$V_{\text{усан сан}} = W_{\text{ус}} * 7 = 8154.5 * 7 = 57081.5 \text{ м}^3$$

Цэвэр усны хоногийн усны хэрэглээ 1920 м<sup>3</sup> бөгөөд цэвэр усан сангийн багтаамж нь

$V_{\text{цэвэр усан сан}} = W_{\text{цэвэр ус}} * 7 = 11920 * 7 = 13440 \text{ м}^3$  буюу энэ хэмжээнээс багагүй байна. Уурхайн усан санг хуучин ухаш үүссэн хэсэг, тогтоцыг ашиглаж үүсгэнэ.

## БҮЛЭГ V. ДЭД БҮТЭЦ

“Оюут цахир уул” ХХК нь уурхайн барилга байгууламжийг контейнер, гэр сууц ашиглан байгуулна.

### V.1. Барилга байгууламж

Уурхайн барилга байгууламжид захиргааны байр, ажилчдын болон хоолны байр, агуулах, ШТС, харуулын байр багтана.

#### V.1.1. Уурхайн тосгон

Уурхайн тосгоныг ил уурхайгаас баруун хойд зүгт 1 км-т байрлана. “Оюут цахир уул” ХХК нь уурхайн захиргаа, ажилчдын сууц, цайны газар, харуулын байр, материалын агуулах зэргийг гэр болон контейнерээр барьж байгуулахаар төлөвлөсөн. Уурхайн тосгон нийт 0.5 га талбайг хамарна.

**Хүснэгт 49. Уурхайн барилга, байгууламж**

№	Байгууламж	Хийц	Тоо хэмжээ
1	Уурхайн захиргаа	контейнер	3
2	Материалын агуулах	контейнер	2
3	Ажилчдын сууц	Стандартын дагуу тохижуулсан контейнер	20
4	Цайны газар	контейнер	2
5	Халуун ус	вагончик	2

Ил уурхайд жижиг засварын газрыг барьж байгуулна. Уурхайн машин техник, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг өөрийн засварын мэргэжилтнүүд хийж гүйцэтгэнэ. Засварын хэсэгт дугуй засвар, гагнуур, компрессор зэргийг суурилуулна.

#### V.1.2. Машин техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, материалын агуулах

Үндсэн болон туслах үйлдвэрлэлийн хэрэгцээнд ашиглагдаж байгаа техник хэрэгслийг засварлахад чиглэгдэнэ. Энэ агуулах нь 2 ш контейнер байх ба уурхайн засварын талбайн баруун хэсэгт байрлана. Засварын газар нь уурхайн машин техник, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг өөрийн засварын мэргэжилтнүүд хийж гүйцэтгэнэ. Засварын хэсэгт дугуй засвар, гагнуур, компрессор зэргийг суурилуулна.



**Зураг 14. Сэлбэг, материалын агуулах**

### ***V.1.3. ШТМ-ийн агуулах***

Шатах тослох материалын агуулах нь Уурхайн тосгоноос 1 км-н зайд орших бөгөөд түлшний 25 тонны 1 ш ёмкост байна. Эдгээр агуулах байрлах газарт аянга зайлуулагчийг давхар суурилуулна. Тос, тосолгооны материалыг зориулалтын савтай нь агуулахад хадгална. ШТМ-ын гал аюулгүй байдлын шаардлага, норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.

### ***V.2. Холбоо дохиолол***

Уурхайн хэмжээгээр ажлын уялдаа холбоог сайжруулахын тулд хэсэг цехүүдийн дунд богино долгионуудын станцуудыг ашиглах ба уурхайг Дархан-Уул аймагтай холбохын тулд интернетийн холбоог ашиглана.

### ***V.3. Зам харилцаа***

Уурхайн зам харилцаанд Үйлдвэрийн газраас орон нутгийн замтай 3 км орчим зам засах, тосгоноос ил уурхайн хүртэлх, ил уурхайгаас технологийн шугам, баяжуулах цех, ШТМ-ийн агуулах руу явах зэрэг зам харилцаа багтана. Зам нь сайжруулсан шороон зам байна.

### ***V.4. Цахилгаан хангамж***

Одоогийн хэрэглэж байгаа тус “ Оюут цахир уул” ХХК нь өөрийн хэрэгцээний Yanmar YEG300 маркийн 300 кВт-ын чадалтай Дизель генератораас кабель шугам татан эрчим хүчээр хангаж ажиллана. Уурхайн үндсэн цахилгаан хэрэглэгч нь уурхайн гэрэлтүүлэг, алт угаах төхөөрөмж, усны насосууд байна.



***Зураг 19. Yanmar YEG300 маркийн Дизель генератор***

#### ***V.4.1. Уурхай, баяжуулах хэсэг, захиргааны цахилгаан хэрэглэгчид***

Дэнж, Хуурайн болон Чулуутын алтны шороон ордын цахилгаан хэрэглэгчид нь:

- Ил уурхайн гэрэлтүүлэг
- Баяжуулах хэсгийн тоног төхөөрөмжүүд
- Гүний худгийн насосууд
- Уурхайн тосгон (Ажилчдын байр, уурхайн захиргаа, халуун ус, хоолны газар, засварын газар, шатахуун түгээх станц, сэлбэгийн агуулах) байх бөгөөд тэдгээрийг цахилгаан эрчим хүчээр хангах шаардлагатай.

## Хүснэгт 50. Цахилгаан хэрэглэгчдийн суурь болон тооцооны актив

№	Хэрэглэгчийн нэр	Тоо	Ажлын заасан чадал		Тооцооны коэффициентүүд			Тооцооны чадал		Нийт чадал, кВт	Ажлын цаг		Цаг ашиглалтын коэффициент	Ашиглалтын жилийн цахилгаан хэрэглээ	
			Рном, кВт	∑Рном, кВт	кх	tga	Ка.а	Рт, кВт	Qt, кВар		Хоногт	Жилд		Wa, кВт	Wp, кВар
<b>Уурхайн</b>															
1	Ил уурхайн болон овоолгын гэрэлтүүлэг /ПКН-1500/	4	0.5	2	1	1	1	2.00	2.00	2.00	6	990	0.80	6336.0	6336.0
2	Тооцоологдоогүй / 10% /													633.6	633.6
	<b>Уурхайн дүн</b>		<b>0.5</b>	<b>2</b>										<b>6969.6</b>	<b>6969.6</b>
<b>Баяжуулах үйлдвэрийн бусад</b>															
3	Скруббер иж бүрдэл	1	22	22	0.9	1	0.80	19.8	15.8	20	24	2425	0.80	38413.4	30730.7
4	Технологийн ус тэжээх насос	1	37	37	0.8	1	0.80	29.6	23.7	30	24	2425	0.80	57426.1	45940.9
5	Цэвэр усны насос	1	1.5	1.5	0.8	1	0.80	1.2	1.0	1	24	2425	0.80	2328.1	1862.5
6	Эргэлтийн усны насос	2	55	110	0.9	1	1.00	99.0	99.0	198	24	2425	0.80	192066.9	192066.9
	<b>Үйлдвэрийн дүн</b>		<b>115.5</b>	<b>170.5</b>				<b>149.60</b>	<b>139.48</b>					<b>290234.5</b>	<b>270601.0</b>
<b>2. Бусад</b>															
7	Уурхайн тосгон	1	44	44	0.9		0.5	39.60	20.59	39.60	24	4752	0.5	94089.6	48926.6
8	Худгийн насос	1	1.5	1.5	0.9		0.5	1.35	0.70	1.35	25	175	1.5	354.4	184.3
9	Тооцогдоогүй хэрэглэгчид (5%)			4.4				3.96	2.0592					9409.0	4892.659 2
	<b>Бусад хэрэглэгчийн нийлбэр дүн</b>			<b>49.9</b>				<b>44.91</b>	<b>23.35</b>					<b>103852.9 35</b>	<b>54003.5</b>
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>224.8</b>				<b>198.47</b>	<b>164.89</b>					<b>401057.0</b>	<b>331574.1</b>

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө -2024



**Дизель станц**

Төвийн нэгдсэн эрчим хүчний системээс алслагдсан ба эрчим хүч хүрээгүй аймаг сум газруудад болон улсын нэн чухал объектуудад эх үүсвэр болгон дизелийн цахилгаан станцыг ашигладаг.

**Тооцооны бүрэн ачаалал:**

$$S_{\text{Тооц}} = \sqrt{P_{\text{Тооц}}^2 + Q_{\text{Тооц}}^2}$$

$$P_{\text{Тооцоо}} = K_{\text{хэр}} \cdot P_{\text{с}}$$

$$Q_{\text{Тооцоо}} = P_{\text{Тооцоо}} \cdot \tan \varphi$$

$S_{\text{Тооц}}$  - Тооцооны бүрэн ачаалал, кВА

$P_{\text{Тооцоо}}$  - Тооцооны актив ачаалал, кВт

$Q_{\text{Тооцоо}}$  - Тооцооны реактив ачаалал, кВар

$K_{\text{хэр}}$  - Хэрэглээний коэффициент

$P_{\text{с}}$  - Суурь хүчин чадал, кВт

$$S_{\text{Тооц}} = \sqrt{198.47^2 + 164.89^2} = 258 \text{ кВт}$$

Тооцоог үндэслэн одоо ашиглагдаж байгаа YEG300 маркийн 300 кВт-ын чадалтай Дизель генератор 1ш байхаар сонгож авлаа.

**Ү.4.2. Аянгаас хамгаалах байгууламж**

Шатах тослох материалын агуулах болон засварын талбайд аянга зайлуулагч төхөөрөмж, түүнийг ашиглах журмын дагуу аянгын хамгаалалт хийж өгнө.

Аянгын шууд цохилтоос хамгаалах зорилгоор аянга хүлээн авагч, гүйдэл зайлуулагч, газардуулгын голчтой савхан аянга зайлуулагчийг байрлуулан гүйцэтгэнэ. Аянга зайлуулагч нь өөр өөрийн газардуулгатай байна.

ШТМ-ын агуулах болон засварын талбай нь анхдагч болон хоёрдогч аянгын цохилтоос хамгаалагдсан байх ёстой. Анхдагч аянгын цохилтоос хамгаалах аянга зайлуулагч нь талбайгаас зайтай тусдаа газардуулгатай байх ёстой. Газардуулга нь  $\varnothing - 12$  мм, 5 м-ийн урттай төмөр хоолой буюу эсвэл  $50 \times 50 \times 5$  мм, 3 м-ийн урттай гурвалжин төмрөөр хийгдсэн байх ба газрын гүнд 0.8 м-т  $40 \times 4$  мм<sup>2</sup> төмөр туузан ил газардуулгатай холбогдсон байна.

**Анхдагч аянга зайлуулагч:**

Савхан аянга зайлуулагчийн хамгаалалтын бүс: Тооцоо бодолт: ШТМ-ын агуулах, ёмкосны өндөр  $H_a = 2.2$  м бөгөөд энэ тохиолдолд аянга зайлуулагчийн өндөр  $h = 16$  м байх ба бүх аянга зайлуулагчийг ижил өндөртэйгөөр авсан.

Аянга зайлуулагчийн хамгаалалтын конусын өндөр:

$$H_o = 0.83 \cdot h = 0.83 \cdot 16 = 13.28$$

Газрын гадарга дээр үүсэх хамгаалалтын тойрогийн бүсийн хэмжээ:

$$r_o = 1.5 \cdot h_o = 1.5 \cdot 13.28 = 19.92 \text{ м}$$

Засварын талбай, автомашины зогсоолын аянга зайлуулагчийн тооцоо:

Аянга зайлуулагчийн өндрийг 12 м-ээр авав.

Аянга зайлуулагчийн хамгаалалтын конусын өндөр:

$$h_o = 0.83 \cdot h = 0.83 \cdot 12 = 9.96 \text{ м}$$

Газрын гадрага дээр үүсэх хамгаалалтын тойргийн бүс

$$r_o = 1.5 \cdot h_o = 1.5 \cdot 9.96 = 14.9 \text{ м}$$

**V.5. Усан хангамж, усны хэрэглээ, төлбөр**

Алтны шороон ордыг ашиглахад ордын орчимд гадаргуугын усаар хангах боломжтой тул Шарын голын усыг ашиглаж элс угаах ажлыг явуулна.

Мөн хэрэгцээт цэвэр усыг Шарын голоос хангахаар төсөлд тусгалаа

Үйлдвэрлэлийн хэрэгцээ болон ахуйн хэрэгцээний усыг Шарын голоос хангахаар төсөлд тусгалаа. БОНХАЖ-ын сайдын 2015.07.30-ны А/301 тоот “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай” тушаалын 2-р хавсралтанд алтны шороон ордын 1 м<sup>3</sup> элсийг угаан баяжуулахад 4 м<sup>3</sup> ус хэрэглэнэ гэж нормчилсоны дагуу тооцов. Мөн ордын алтны хялбар угаагдах шинж чанар, ус шламын тооцооноос харахад технологийн нийт усны 20% нь цэвэр ус, 80% эргэлтийн ус байх бөгөөд нийт шаардагдах усны хэрэгцээг тооцоход төслийн хугацаанд 187,9 мян.м<sup>3</sup> болж байна.

**Хүснэгт 51. Шаардагдах усны хэмжээ**

№	Үзүүлэлт	Усны хэрэглээ, м3	Ашиглалтын жилд, м3
1	Ундын ус	970.2	970.2
2	Тоосжилт дарах, бусад	1,000	1,000
3	Үйлдвэрийн ус	186,022	186,022
4	<b>Нийт</b>	<b>187,992</b>	<b>187,992</b>

Хуурай, Дэнж болон Чулуутын алтыг баяжуулахад шинээр хаягдал усны далан байгуулах ажил хийнэ. Ашигласан усыг усан сан руу хоолойгоор дамжуулах ба булингийг тунаан дахин эргэлтээр ашиглана. Ингэснээр байгаль орчныг бохирдолоос хамгаалж, цэвэр усны нөөцийг хэмнэнэ. Угаах төхөөрөмжөөс гарч байгаа ус хоолойгоор дамжин урсаж 1,2-р хаягдлын санд орох ба тунасан ус, цэвэр усны санд хуримтлагдан цааш шахуургаар угаах төхөөрөмжинд хоолойгоор шахагдана.

Дэнж, Хуурай, Чулуутын алтны шороон ордын уурхай нь Хараа голын сав газарт хамаарагдах бөгөөд Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолын 1, 2-р хавсралтын дагуу усны нөөц ашигласны хувь хэмжээ, ашиглалтын итгэлцүүрийг тооцон технологийн усны үнэ 196 төг/м<sup>3</sup>, унд ахуйн усыг 87,32 төг/м<sup>3</sup> байхаар тооцлоо.

**Хүснэгт 52. 1 м3 ус ашигласны төлбөр**

Төрөл	ЭЭСҮнэлгээ, төг/м3	Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ, %	Ашиглалтын зориулалтаар тооцох итгэлцүүр	1м3 ус нөөц ашигласны төлбөр
<b>Үйлдвэрийн ус</b>				
гадаргын ус	2183	10%	0.9	196
Газар доорх ус	2764	20%	1.4	774
<b>Ундын ус</b>				
гадаргын ус	2183	10%	0.4	87.32
Газар доорх ус	2764	20%	0.3	165.84

**V.6. Дулаан хангамж**

Уурхайн газрын дээрх барилга байгууламж, уурхайн удирдлагуудын контор буюу ажлын өрөө, нярадын байр буюу ажлын зааварчилгаа авах өрөө, ажилчдын хувцас солих, усанд орох газар уурхайн ажиллагсдын цайны газар зэрэг барилга байгууламжууд нь уурхайн тосгонд байрлана. Дулааны улиралд ажиллах тул дулаан хангамж шаардлагаүй. Хүйтэрсэн

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024


нөхцөлд цахилгаанаар халаана.

## БҮЛЭГ VI. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ

### VI.1. Удирдлага, зохион байгуулалт

Ил уурхай болон угаан баяжуулах хэсгийн удирдлага зохион байгуулалтын бүтцийн орон тоо нь энгийн бөгөөд үр ашигтай байх зарчмыг баримтлана.

Ажилчдын орон тоог төсөл хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай техник технологи, төслийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн тоо нэг бүрээр уурхай болон үйлдвэрийн нөхцөл зэргийг харгалзан тооцлоо. Төслийн хүчин чадлаар ажиллахад бүрэн хангагдахаар орон тооны ажилчдыг тусгаж, цалин болон бусад зардлыг тусгаж өгсөн. Их хуурай алтны уурхай нь 2 ээлжээр ажиллах бөгөөд үргэлжлэх хугацаа 10 цаг байна. Уурхайн өдөр тутмын үйл ажиллагааг уурхайн дарга удирдан явуулна. Сум орон нутгийн иргэдийг ажилтай, орлоготой болгох, ажилчдыг аюулгүй таатай орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлж ажиллахыг зорьж ажиллана.



Зураг 15. Удирдлага, зохион байгуулалтын схем

### VI.2. Ажиллах хүчин, хүний нөөц

Уурхай болон баяжуулах хэсэгт ажиллах инженер техникийн болон ажилчдын тоог одоо ажиллаж байгаа ажилчдын тоотой уялдуулан, ижил төстэй үйлдвэрүүдэд мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хуваарийн дагуу вахтаар тооцсон.

Төсөл ашиглалтын хугацаанд шаардагдах хүнсний болон бусад боломжтой ханган нийлүүлэлтүүдийг орон нутгаас авч ажиллана. Уурхайд нийт 82 хүн ажиллах бөгөөд 22 ажлын байрны орон тоон дээр 30 вахтын ажилчид ажиллах юм

Үйлдвэрийн ажлын онцлог, хөдөлмөрийн нөхцөл, ажлын нягтралыг харгалзан ИТА -19, үйлдвэрийн ажилчид 38, бусад ажилчид 25 байхаар тооцсон.

Мэргэжилтний чадвар, дадлага туршлага төслийн хэрэгжилтэд шууд нөлөөлөх учир мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид зөвлөж байна.

Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

хоорондох алтны шороон ордыг ашиглах төслийн хүрээнд “Оюут цахир уул” ХХК-д 82 хүн ажиллах ба сарын дундаж цалин 4.2 сая төгрөг байна.

### Хүснэгт 53. Ажилчдын орон тоо

№	Үзүүлэлт	Орон тоо			Цалин, мян.төг		
		Ээлжинд	Хоногт	Нийт	Үндсэн цалин	Нэмэгдэл цалин	Нийт цалин
<b>Уурхайн захиргаа аж ахуйн ажилчид</b>							
1	Уурхайн дарга	1	1	2	6000	900	165600
2	Уулын инженер	1	1	2	5000	750	138000
3	ХАБЭА-н инженер	1	2	3	3500	525	72450
4	Маркшейдер	1	2	3	3500	525	60375
5	Геологи	1	2	3	3500	525	60375
6	Нягтлан бодогч	1	1	2	5000	750	69000
7	Нярав	1	2	3	3000	450	62100
8	Тогооч	2	4	6	2500	375	103500
9	Үйлчилгээний машины жолооч	4	4	8	2000	300	110400
10	Үйлчлэгч	1	2	3	1500	225	31050
11	Манаач	1	2	3	1500	225	31050
<b>Нийт</b>		<b>14</b>	<b>21</b>	<b>35</b>	<b>37000</b>	<b>5550</b>	<b>903900</b>
<b>Ил уурхайн ажилчид</b>							
12	Уулын мастер	1	2	3	4500	675	93150
13	Оператор экскаватор	2	4	6	4000	600	165600
14	Оператор /Howo автосамосвал/	4	8	12	4000	600	331200
15	Оператор /Бульдозер/	1	2	3	3500	525	72450
16	Механик	1	2	3	4500	675	93150
17	Туслах ажилчин	1	2	3	2000	300	41400
<b>Нийт</b>		<b>10</b>	<b>19</b>	<b>29</b>	<b>22500</b>	<b>3375</b>	<b>796950</b>
<b>Баяжуулах үйлдвэрийн ажилчид</b>							
18	Баяжуулагч инженер	1	2	3	4500	675	93150
19	Т.т-ийн оператор	1	2	3	3500	525	72450
20	Оператор /Дугуйт ачигч /	1	2	3	4000	600	82800
21	Угаагч	1	2	3	3500	525	72450
22	Цахилгаанчин, гагнуурчин	1	1	2	3500	525	48300
<b>Нийт</b>		<b>5</b>	<b>9</b>	<b>14</b>	<b>19000</b>	<b>2850</b>	<b>369150</b>
<b>Нийт дүн</b>		<b>30</b>	<b>52</b>	<b>82</b>	<b>78500</b>	<b>11775</b>	<b>2070000</b>

### Хүснэгт 54. Төслийн нийт ажилчдын тоо

	Ажилчдын бүтэц	Ашиглалтын жилд
1	Уурхайн захиргаа, аж ахуй	37
2	Ил уурхайн ажилчид	30
3	Баяжуулах үйлдвэрийн ажилчид	14
<b>Нийт</b>		<b>81</b>

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024



## **БҮЛЭГ ҮН. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ**

### **ҮН.1. Хөдөлмөрийн аюулгүй байдлын арга хэмжээ**

Дэнж, Хуурай, Чулуутын уурхайн ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааг явуулахдаа ордын геологи, уул-техникийн нөхцөл, уурхайн үндсэн хэмжээсүүд, механикжуулалт, технологийн онцлогт тулгуурлан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллана. Уг журам, зааварт “Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”, “Хөдөлмөр хамгааллын стандартууд”, “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм”, MNS OHSAS 18001:2012 -ийн заалтууд бүрэн хэмжээгээр тусгагдсан байна.

Үйлдвэрийн захиргаа нь ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцлийг хангаж, сургалтын хөтөлбөр гаргаж хэрэгжүүлнэ. MNS 4990-2000 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага” стандартыг мөрдөж ажиллана. Мөн MNS: 12.013-91 “Ажлын байрны бичил цаг уурын эрүүл ахуйн хэмжээ” стандартын шаардлага хангасан байна.

Эдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон аргачлал, зааврыг мөрдөн доор дурдсан үндсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажилласны үр дүнд уурхайн хэвийн ажиллагаа хангагдах ёстой. Үүнд:

- o Ажлын байрны аюулгүй ажиллагааны шаардлага;
- o Уурхайн хажуугийн тогтворжилтыг хангах;
- o Галын аюулаас урьдчилан сэргийлэх шаардлага;
- o Засвар механикийн аюулгүй ажиллагаа
- o Үйлдвэрийн осол гэмтэлтэй тэмцэх арга хэмжээ;
- o Уурхайн тоосжилтыг багасгах г.м.

#### Ажлын байрны аюулгүй ажиллагааны шаардлага:

Уулын ажлын технологийн удирдлага, хяналтыг мэргэжлийн түвшинд ерөнхий инженер хариуцаж уурхайн үндсэн ажиллагаа, ухаж ачих процесс, тээвэрлэх, өрөмдлөг тэсэлгээний ажил, овоолгын ажлыг паспортын дагуу ХАБЭА–н асуудлуудыг хатуу чанд мөрдөж явуулна.

Ажилтан ирэх буцах зам, аюултай хэсэг, аюул осол гарч болзошгүй газруудад Монгол улсын “Хөдөлмөр хамгааллын тэмдэг тэмдэглэгээ өнгө, дохионы” MNS 4643-98 стандартын дагуу боловсруулагдсан анхааруулах тэмдэг, зурагт хуудас болон машин тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны заавар санамжийг ил тод харагдах газарт ойлгомжтой бичиж тавина. Тэмдэг дохионы утга учрыг уурхайн бүх хүмүүс ойлгож мэдсэн байна. Уурхайн ухаж ачих механизм, авто, тээвэр ашиглалт хөдөлгөөний байдалд “Замын аюулгүй байдлын тухай” Монгол улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

Уурхайн дотоод дүрмийн дагуу хариуцсан ажлаа аюулгүй явуулах сахилга бат хөдөлмөрийн дүрмийг нарийн чанд мөрдөх, ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслэлийг аливч гамтай эдлэх, тоног төхөөрөмж багаж хэрэгслэлийг бүрэн бүтэн байлгах, өгсөн үүрэг даалгавар шийдвэрийг чанартай биелүүлэхийг ажиллагсдаас шаардаж ажиллахыг нэгж дээр ээлжийн мастер голлох үүрэгтэйгээр хариуцаж ажиллана.

Тухайн өдөр аюулгүй ажиллах зааварчилгаа, ажлын даалгаварыг нарядын хэлбэрээр

авч зохих хүснэгтэд ээлжийн мастер ажил гүйцэтгэгч нар он, сар, өдөр, цагийг тэмдэглэн гарын үсэг зурж ажил эхлүүлнэ. Ажил дууссаны дараа ажил гүйцэтгэгч, уулын инженер ажил дууссан цаг, он, сар, өдрийг бичиж гарын үсэг зурна. Онцгой тохиолдолд амаар ажлын даалгавар өгөхийг зөвшөөрнө.

Бүх ашиглагдаж байгаа техник хэрэгсэлд үзлэг шалгалтыг өдөр бүр ээлж эхлэхийн өмнө, ажил дуусахад оператор, машинистууд хийж тусгай журналд тэмдэглэж ээлж солилцоход хүлээлгэж өгөх илэрсэн зөрчлийг тухай бүрт нь арилгаж ажиллана.

Уурхайд ашиглагдах машин механизм нь техникийн хувьд бүрэн бүтэн, ар талыг харах толь, гэрлэн ба дуут дохио, гэрэлтүүлгээр бүрэн тоноглогдсон, тормос бүрэн ажиллагаатай байна.

Машин механизмыг ажиллуулах, тээврийн хэрэгслэлийг эзэмшихийн өмнө аюулгүй байдлыг анхааруулах гэрлэн болон дуут дохиог үзэгдэж сонсогдохоор өгнө. Дохионы утга учрыг уурхайд ажилладаг бүх хүмүүст тайлбарлаж таниулсан байна. Тоног төхөөрөмж бүр дээр дохионы утга учир, дагаж мөрдөх аргачлалыг харуулсан схем, дохио санамжийг хүмүүст мэдэгдэхээр ил тод бичиж тавина.

Ажлын байрны агаарын тоос, хорт хийн хэмжээ эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэх нөхцөл бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ тогтмол авч хэрэгжүүлнэ.

Ажиллагсдыг ажил үүргийн онцлог, техникийн гоо зүй, эргономикийн шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслэлээр хангана. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслэлийг цэвэршүүлэх ариутгах, засварлах үүргийг уурхайн хэсгийн мастер хариуцаж хэрэглэнд нь хяналт тавьж ажиллана.

#### Уурхайн хажуугийн тогтворжилтыг хангах:

Уурхайн хажуугийн нурж болзошгүй хэсгүүдийг цаг тухайд нь унагаж байхын зэрэгцээ нурах, гулсаж болзошгүй газруудад анхааруулах тэмдэг хадсан байх.

Уурхайн талбайг хур тунадасны уснаас хамгаалах арга хэмжээ авсан байх.

#### Галын аюулаас урьдчилан сэргийлэх шаардлага:

Уурхайн талбайд гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгаа, хяналтын ажил, гал гарсан үед түүнийг унтраах хэрэгслэлийн хангамж, галтай харьцах ажил гүйцэтгэх, цахилгаан тоног төхөөрөмж дээр ажиллах үед мөрдөх аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг МУ-ын “Галын аюулгүй байдлын тухай хууль” Аж ахуйн нэгж байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм”, Гал түймэрийн аюулгүй байдалтай холбогдуулан гаргасан тушаал, шийдвэрийн дагуу зохион явуулна.

Уурхайн талбайд галын аюулаас хамгаалах ажил, гал түймрийн хяналтын ажлыг уурхайн даргын тушаалаар баталсан ХАБЭА-н гишүүнээр ахлуулсан комисс байгуулж ажиллуулна. Энэ комисс нь галын аюулгүй байдлын талаар гарсан хууль, дүрэм журам, нормыг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, гал түймэр зөрчлийн талаар судалгаа, тоо бүртгэл хөтөлж, зөрчил гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн бодлого арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ.

Уурхайн нийт ажилтан, ажиллагсад галын аюулгүйн дүрэм зааврыг судлуулах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг улирал бүрт өгнө.

Ажлын байранд нарийн дэг журам тогтоож, тамхи татах тусгай байр, галтай ажил, хийн ба цахилгаан гагнуурын ажлыг аюулгүйн нөхцөлийн дагуу боловсруулсан журмын дагуу хийж, ил задгай гал гаргахгүй байх зарчмыг баримтлан эргүүл жижүүр зохион байгуулж ажиллуулна.

Гал унтраах анхан шатны болон суурин тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах засвар, үйлчилгээг цаг тухайд нь хийж, сар бүр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Уурхайн талбайд шатах тослох материалын, тоног төхөөрөмжийн агуулах, засварын газар орчим хамгаалалтын зурвас байгуулна.

Бүх экскаватор, автосамосвал нүүрстөрөгчийн галын хор, хүрз, хайрцагаар хангагдсан байна.

Гал унтраах багаж хэрэгслийн бэлэн байдалд нэгж тус бүрийн удирдах ажилтан өдөр бүр тогтмол хяналт тавьж илэрсэн дутагдлыг биечлэн засах, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Гал түймэр, галын зөрчилтэй холбогдсон галын аюулгүй ажиллагааны дүрэм тушаал шийдвэрийг зөрчсөн тухай бүрт захиргааны арга хэмжээ болон мөнгөн торгууль оногдуулах асуудал захиргаанд тавьж шийдвэрлүүлнэ.

Засвар механикийн аюулгүй ажиллагаа:

Засварын газар нь техникийн засвар үйлчилгээг календарь графикайн дагуу хийж гүйцэтгэнэ. Засварын газар нь гагнуур, дугуй засвар, агрегат засвар гэсэн бүрдлүүдтэй байна. Эдгээр нь өөрийн онцлогт тохирсон аюулгүй ажиллагааны заавартай түүний дагуу ажилладаг байна.

Засварын газар нь стандартын шаардлага хангасан агааржуулалт, гэрэлтүүлэгтэй ажиллах хүмүүсийн ая тухыг бүрэн хангасан байна.

Машин тоног төхөөрөмжинд засвар үйлчилгээ хийхдээ эд ангийн хөдөлгөөнийг бүрэн зогсоож, унаж болох, шилжих хэсгийг бэхэлж байж үзлэг үйлчилгээ, засварын ажил хийнэ.

Засварын ажлын явцад хий, шингэний даралт, цахилгааны эрчим хүч гэнэт залгагдах бүх боломжийг урьдчилан арилгасан байна.

Засварын газар нь галын аюулаас хамгаалах багаж, хэрэгслээр тоноглогдсон байна.

Үйлдвэрийн осол гэмтэлтэй тэмцэх арга хэмжээ:

Техник, аюулгүй ажиллагааны дүрмийг хатуу мөрдөж хүн бүрийг аюулгүй ажиллагаанд сургасан байх.

Уулын ажлыг уурхайн ашиглалтын мэргэжилтний удирдлага дор явуулна.

Уулын бүх машин техникүүд нь эмийн сантай байх ба шаардлагатай эмийн зүйлээр хангагдсан байна.

Цахилгаан машин, тоног төхөөрөмжинд ажиллах аюулгүй ажиллагааны дүрмийн бүх шаардлагыг хатуу чанд мөрдөн ажиллана.

Уурхайн тоосжилттой тэмцэх арга хэмжээ:

- Тоног төхөөрөмж ажиллаж буй талбай, мөргөцгийг тогтмол услах.
- Ажилтнуудыг тоосжилтоос хамгаалах хувийн хэрэгслээр хангах, ажилтнууд тэдгээрийг хэрэглэж занших.
- Ажилтнуудыг эмнэлгийн үзлэгт тогтмол оруулах.
- Авто замыг усалж тоосжилтыг багасгах г.м.

## **ҮИ.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зааварчилгаа**

ХАБЭА-н сургалтын гол зорилго нь ажил олгогч, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны аюулгүй ажиллах арга барилд сургах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн талаар мэдлэг олгон, осол эндэгдэлгүй, эрүүл ажиллах соёл, зан үйлийг төлөвшүүлэхэд оршино. ХАБЭА-н сургалтыг зааварчилгаа өгөх хэлбэрээр зохион байгуулна. ХАБЭА-н зааварчилгаа дараах хэлбэртэй байна.

- Урьдчилсан зааварчилгаа

- Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа
- Давтан зааварчилгаа:
  - Ээлжит
  - Ээлжит бус
  - Ажлын байран дахь өдөр тутмын

- Курсын сургалт

МУ-ын Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/53-р тушаалын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулж, шалгалт авч байхыг бүх аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч нарт үүрэг болгосонтой холбоотойгоор зохион байгуулагдаж байгаа сургалтуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэнг зайлшгүй суулгана.

### **VII.3. Аваар ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

Уурхай нь өөрийн онцлогт тохирсон “Гамшгийн аюулаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын дагуу боловсруулсан төлөвлөгөөтэй байна. Гамшгийн аюулаас хамгаалах төлөвлөгөөнд гал унтраах ажлыг хэрхэн зохион байгуулах тухай заавал тусгасан байна. Гамшгийн аюулаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар:

1. Ил уурхай нь энэ зааврын дагуу боловсруулж, баталсан аваарь устгах төлөвлөгөөтэй байх.
2. Аваарь устгах төлөвлөгөөнд дараах арга хэмжээнүүдийг заавал тусгасан байна. Үүнд:
  - Ил уурхай дээр гарч болзошгүй аваар осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөл (гал түймэр, усны аюул гэх мэт)-үүд тэдгээрийн байрлал, гарч болох газар;
  - Аваар осолд нэрвэгдсэн хүмүүсийг аврах арга хэмжээ;
  - Аваар ослыг гарсан даруйд нь буюу эхний үе шатанд устгах арга зам, аваар ослын үед инженер техникийн болон бусад ажилтны ажил, үүргийн хуваарь, зохион байгуулалт;
  - Аваарь осол устгах ба хүмүүсийн амь насыг хамгаалах, аврахад зориулсан хамгаалах баг, хэрэгслийн байрлал, тоо хэмжээ;
  - Осол аваар гарсан үед уул уурхайн аврах албаны аврагч, аврах ажлыг зохион байгуулах ажилтан нарын ажил, үүргийн хуваарь, аврах ажиллагаа зэрэг болно.
3. Ил уурхайн аваар устгах төлөвлөгөөг төсөл хэрэгжихээс өмнө боловсруулж, УУАА-аар хянуулан, мөрдөж эхлэхээс 30 хоногийн өмнө батлуулна.
4. Ил уурхайн аваар устгах төлөвлөгөөнд тусгагдах асуудлууд:
  - 4а. Шуурхай хэсэг
    - Гал түймэр унтраах материал хэрэгсэл, далан, шуудуу, хаалт хамгаалалт, ус хураагуур зэрэг бүх туслах байгууламжийн байршил, усны түвшинг үзүүлсэн уулын ажлын дэвсгэр зураг;
    - Уул, тээврийн үндсэн тоног төхөөрөмжийн байрлал, гарц орцуудыг үзүүлсэн тухайн жилийн ашиглалтын бүдүүвч зураг;
    - Гал унтраах шугам хоолойн бүдүүвч;
    - Гал унтраах болон цахилгаан хангамжийн бүдүүвч;
    - Аваарийн гэрэлтүүлгийн бүдүүвч;
  - 4б. Аваар устгах ажилд оролцох ажилтан тус бүрийн гүйцэтгэх ажил, үүргийн хуваарь.
5. Аваар осол гарсан тухай мэдэгдэх, заавал мэдэгдэх аж ахуйн нэгж, байгууллага, удирдах



болон хариуцлагатай ажилтны нэрсийн жагсаалт.

6. Аваар устгах төлөвлөгөө бүх хавсралтын хамт уурхайн ерөнхий инженер, УУАА-д байхаас гадна шуурхай хэсэг, уурхайн диспетчерийн ажлын байранд тус тус байвал зохино.

7. Аваар осол гарсан үед дуудагдах ажилтны нэрсийн жагсаалт үйлдвэр, уурхайн холбоон дээр байх ёстой.

8. Аваар устгах ажлын хариуцлагатай удирдагч нь ил уурхайн ерөнхий инженер байх ба хариуцлагатай удирдагчийг хүрэлцэн иртэл уулын ажлыг удирдан явуулж байгаа ажилтан орлоно.

9. Үйлдвэрлэлийн техник, технологийн горим, хөдөлмөрийн зохион байгуулалт шинэчлэгдэн, уулын үйлдвэр, уурхайн үйлдвэрлэлийн бодит байдал гамшгийн аюулаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсанаас өөрчлөгдвөл аваар устгах төлөвлөгөөнд 24 цагийн дотор зохих нэмэлт өөрчлөлтийг оруулж энэ тухай холбогдох хэсэг, цех, ээлж, инженер техникийн болон нийт ажилтанд танилцуулсан байх ёстой.

#### **VII.4. Ил уурхайн аюулгүй ажиллагаа**

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн зорилго нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажилтны эрүүл мэнд, хөдөлмөрийн чадварыг хэвээр хадгалж эрүүл, аюулгүй орчинд хөдөлмөрлөх нөхцөлөөр хангахад оршино.

Уурхайн уулын ажлыг явуулахдаа ордын нөхцөл, хэмжээснүүд, механикжуулалт, технологийн онцлогийг тусгасан “Баруун-Уртын хөндийн зүүн дэнжийн алтны шороон ордын аюулгүй ажиллагааны журам”-ыг боловсруулан баталгаажуулж мөрдлөг болгож ажиллана. Уг журамд “Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”, “Хөдөлмөр хамгааллын стандартууд”, “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн заалтууд бүрэн хэмжээгээр тусгагдсан байна.

Ажилд шинээр орж байгаа ажилтан бүр 3 өдрийн, урьд нь уулын үйлдвэрт ажиллаж байсан ажилтан 2 өдрийн батлагдсан хөтөлбөрийн дагуу урьдчилсан болон давтан сургаалтанд хамрагдаж хөдөлмөрийн хууль тогтоомж, үйлдвэрлэлийн дотоод журам, аюулгүй ажиллагааны дүрэм, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны арга барилыг судлуулан уурхайн даргаар ахлуулсан комисст шалгалт өгнө.

Ээлжид гарах ажилтан бүрд аюулгүй ажиллагааны зааварчилагаа, ажлын даалгаврыг бичгээр өгч гарын үсэг зуруулна. /Шаардлагатай үед зааварчлаг, шинэ даалгаврыг гарын үсэг зуруулж амаар өгч болно/. Нийт ажилчдад улиралд 1 удаа аюулгүй ажиллагааны давтан зааварчлаг өгнө. Уулын ажлын технологийн удирдлага, хяналтыг мэргэжлийн түвшинд явуулна. Ажилтан бүрийг ажлын онцлогт тохирсон тусгай хувцас, хамгаалах хэрэглэлээр хангана.

Ажлын байр, ажилтанд ажлын нард өгөх өрөө, ажилтны ирэх буцах зам, авто замын уулзвар, гүүр гарам, аюултай хэсэг болон аюул гарч болзошгүй газруудад “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө MNS 4643-98 стандарт”-н дагуу хийгдсэн хориглох, анхааруулах, заах, дохио тэмдэг, зурагт хуудас, санамжийг ил тод, нүдэнд харагдахуйц газар байрлуулж тавина. Ажлын байрны нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

Ажиллагсдыг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт оруулна. Уул тээврийн машин тоног төхөөрөмжийн операторч, туслах машинчаар зөвхөн тухайн мэргэжлийн дагуу мэргэжлийн сургууль төгсөж мэргэжил эзэмшсэн эрхийн үнэмлэх бүхий хүнийг ажиллуулна. Уурхайн ачих төхөөрөмж, авто тээвэр ашиглалт хөдөлгөөний байдалд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” Монгол улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх ба

машин механизм нь техникийн хувьд бүрэн бүтэн, ар талыг харах толь, гэрлэн ба дуут дохиоллоор бүрэн хангагдсан, хэт ачааллаас хамгаалах хэрэгсэл, агааржуулах систем, эмийн сан, галын хортой байна.

Уул тээврийн машин механизмын ажиллах зарчим тэдгээрийн уялдаа холбоог зохицуулсан дуут болон гэрлэн дохио хэрэглэнэ. Дохионы утга учрыг тодорхой харуулсан бүдүүвчийг ажиллаж буй машин техникт ойр, харагдах газарт байрлуулна.

Ажилтан бүр ажил эхлэхийн өмнө ажлын байр, машин тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, ажилд хэрэглэх багаж хэрэгсэл, дохиолол, гэрэлтүүлэг, хамгаалах хэрэгсэл, тоноглолын гэмтэлтэй эсэхийг шалган зөрчил илэрвэл шуурхай арилгаж ажлаа эхэлнэ. Арилгах боломжгүй бол удирдах ажилтандаа мэдэгдэж арга хэмжээ авч байж ажлаа эхэлнэ.

Машин механизмын ашиглалт техникийн бүрэн бүтэн байдалд ээлж бүрд машинч, 7 хоног, сар тутамд хэсгийн механик шалгалт хийж үр дүнг ээлж хүлээлцэх дэвтэр, техник ашиглалтын журналд тэмдэглэнэ. Бүрэн бус эвдрэл гэмтэлтэй хэвийн бус ажиллагаатай машин тоног төхөөрөмжийн гэмтлийг арилгаж ажилд оруулна. Удаан хугацаагаар ажиллахгүй тохиолдолд уул тээврийн тоног төхөөрөмжийг догол мөргөцгөөс зайлуулан аюулгүй газарт байрлуулан тавина.

Олборлолтын явцад тоос, хорт хий үүсэж хуримтлагдан хүмүүсийн эрүүл мэндэд муугаар нөлөөлж болзошгүй ажлын байруудаас агаарын сорьц аван агуулгыг тодорхойлж, эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэх, тэсрэх аюултай нөхцөл бий болгохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллана.

Уулын ажил:

- Урвуу утгуурт экскаватор ажиллуулах доголын өндөр нь экскаваторын утгалтын гүнээс хэтрэхгүй байх.

- Уурхайн ажлын доголын хажуугийн өнцгийн зөвшөөрөгдөх хэмжээ нь экскаватор ажиллах доголд 80° хүртэл байх.

- Уул тээврийн төхөөрөмж, зам байгууламж, цахилгааны шугам, бусад төхөөрөмжийг доголын нурах аюултай зурвасаас гадагш байрлуулна.

- Дээд ачилттай тохиолдолд тээврийн хэрэгсэл доголын нурах аюултай зурвас болох 2.5–3 метрээс гадагш экскаваторын машинчийн бүхээгээс чөлөөтэй харагдах бүсэд байрлаж ачуулна.

- Ил уурхайн хажуу, догол, траншей, овоолгын байдалд байнгын хяналт тавьж чулуулгийн шилжилт хөдөлгөөн (гулсалт, нуралт, суулт зэрэг) үүсэх шинж тэмдэг илэрвэл уулын ажлыг тухайн бүсэд зогсоож шуурхай арга хэмжээ авна.

- Уурхайн хажуу, догол, овоолгуудад гарч болох нурлыг илрүүлэх үзлэг, нарийн хэмжилтийн ажлыг тогтмол хэрэгжүүлж, бүртгэл судалгаа хийнэ.

- Догол дахь нурлын доод ирмэг эсвэл доголын доод ирмэгээс 2.5 м-ээс багагүй зайд зам байгууламжийг байрлуулж ажиллуулна.

Хөрсний овоолгын ажил:

- Хөрсний овоолго нь дотоод овоолгоор ухаш хэсгийг дүүргэж техникийн нөхөн сэргээлт хийгдэх байдлаар зохион байгуулагдана. Овоолгыг батлагдсан уурхайн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан уурхайн хил хязгаарын гадагш байрлуулахыг хориглоно.

- Мөргөцөгийн нуралт гулсалт гарч болзошгүй аюултай бүсэд инженерийн байгууламж, тоног төхөөрөмж байрлуулахыг хориглоно.

- Овоолго тэгшлэх бульдозер нь овоолгын ирмэгт зөвхөн хусуур талаараа дөхөж болно. Бульдозерыг араар нь овоолгын ирмэгт ойртуулахыг хориглоно. Овоолгын нурлын бүсээс гадагш (аюулгүй зайд) фронтын шугамыг дагасан хөдөлгөөнийг бульдозер хийж болно.

## **VII.5. Элс угаан баяжуулах хэсгийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй**

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

Шороон ордын баяжуулалтын аюулгүй ажиллагаа

- Угаагч хэрэгслийн конвейерын туузаас бул чулууг зайлуулахад тусгай тэвш байрлуулсан байна. Туузаас бул чулууг тусгай хэрэгсэлгүйгээр (гогцоо-барил) зайлуулахыг хориглоно. Бул чулууг овоолох газар хаалт хийгдсэн байна.

- Угаах хэрэгслийн бункерт асгасан элсийг даралттай усны урсгалаар буюу тусгай хэрэгслээр зайлуулахыг зөвшөөрнө. Бункерээс бул чулууг зайлуулахдаа зөвхөн конвейер болон тэжээгчийг зогсоосны дараа тусгай төхөөрөмжийн (блок трос ба бусад) тусламжтайгаар гүйцэтгэхийг зөвшөөрнө.

- Угаах төхөөрөмжийн ажлын байр нь элс үйрүүлэгч, хайргын овоолго, элсийг угаах төхөөрөмж нь сайн харагдах мөн түүнчлэн гидроэлеваторын ойролцоо орших бусад тоног төхөөрөмжийн ажиллагааны аюулгүй байдлыг хангана.

- Хүйтний улиралд ажиллах угаах тоног төхөөрөмжийг дулаалахдаа ажилтны аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн найдвартай байдлыг хангах арга хэмжээг авна.

Угаан баяжуулах цехийн хөдөлмөр хамгаалал:

Баяжуулах үйлдвэрийн хөдөлмөр хамгаалал гэдэг нь хөдөлмөрийн явцад хүмүүсийн эрүүл мэндийг хэвээр хадгалах, хөдөлмөрийн чадварыг бууруулахгүй байх, аюулгүй ажиллах нөхцөлийг хангахад чиглэсэн хууль тогтоомж, техник тоног төхөөрөмж, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээний нэгдсэн систем юм.

Баяжуулах хэсгийн ажилд орж байгаа ажилтан, албан хаагч бүр эмнэлгийн урьдчилсан үзлэг хийлгэсэн байх шаардлагатай бөгөөд үйлдвэрийн ажиллагсдыг улиралд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулна. Ажиллагсад хөдөлмөр хамгаалал, аюулгүйн техник, үйлдвэрлэлийн эрүүл ахуй болон галын аюулгүйн дүрэм, норм зааврын шаардлагыг чанд мөрдүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнүүдээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургаалтанд хамрагдана.

Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөс хамгаалах, урьдчилан сэргийлэхийн тулд ажилчдыг хувцас хамгаалах хэрэгслээр хангана.

Үйлдвэрийн гэрэлтүүлэг:

Угаан баяжуулах болон гүйцээн баяжуулах хэсэг, ажилчдын байр, оффисын ажлын байр, талбайг зөв гэрэлтүүлэх нь хөдөлмөр хамгаалал, эдийн засгийн чухал ач холбогдолтой. Шөнийн цагт үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг хангахын тулд баяжуулах хэсгийг гэрэлтүүлнэ. Гэрэлтүүлэг нь ердийн болон зохиомол хэлбэртэй байна. Угаан баяжуулах хэсгийн аль ч төрлийн байгууламж ердийн гэрэлтүүлгийг дээд зэргээр ашиглахаар төлөвлөгдсөн байх хэрэгтэй. Ердийн гэрэлтүүлэгч нь нар юм. Ажлын байрны зохиомол гэрэлтүүлэгчээр улайсалтын болон люминесцентийн ламптай гэрэлтүүлэгчийг хэрэглэх бол гадаад гэрэлтүүлэгт хийн шавхалтын болон улайсалтын лампыг ашиглана.

Үйлдвэрийн дуу шуугиан, доргион:

Өндөр, нам, чанга, сул, үелзэл, хүчээрээ адилгүй хослолыг шуугиан гэх ба хүчтэй шуугиан нь хүний сонсголын эрхтэн, мэдрэлийн системд нөлөөлж анхаарал сулруулах буюу дуут дохиог хүлээн авахад хүндрэл учруулах зэргээр бие организмд физиологийн болон сэтгэл санааны үйл ажиллагаанд өөрчлөлт оруулдаг. Шуугианыг дараах аргаар бууруулна. Үүнд:

- Үүсгэгчийн шуугианыг бууруулах

- Дуу шингээх ба тусгаарлах хэрэгсэл ашиглан шуугианы тархалтыг хязгаарлах

Доргионоос урьдчилан сэргийлэхдээ:

- Доргион хэмжээс зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн агрегаттай ажлын байранд доргионыг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулах зөөллүүр тавьж өгнө.

- Барилгын хийц хэсгүүдийг (багана, тулгуур г.м) төхөөрөмжийн суурьтай

холбохгүй байх.

### ***ҮИ.5.1. Угаан баяжуулах цехийн аюулгүй ажиллагаа:***

Аюулгүй ажиллагаа гэдэг нь үйлдвэрийн аюултай ба хортой хүчин зүйлүүд нөлөөлөхөөргүй хөдөлмөрийн нөхцөл юм. Үйлдвэрийн аюултай хүчин зүйлүүд ажилтны эрүүл мэндэд нөлөөлснөөр гэмтэл учруулах буюу эрүүл мэнд гэнэт муудахад хүргэнэ.

Иймд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар дараах ажлуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлнэ.
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар мөрдөх журам боловсруулж хэрэгжүүлнэ.
- Үйлдвэрийн хэмжээнд технологийн бүх процессуудыг паспортжуулж хэрэгжилтийг хангана.
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчлагаа, ажлын байр бүрийн холбогдол бүхий зааварчлагаар хангана.
- Галын аюултай тэмцэх бүх талын мэдлэг дадлага эзэмшүүлэх, тухайн ажлын байрны зааварчилгаа гаргана.
- Шатах тослох материалын хадгалалт байршлыг мөрдөгдөж буй журмын дагуу хангана.
- Цахилгаан хувиарлах хэсэг бусад хэрэглэгчдийн газардуулгыг зохих тооцооны үндсэн дээр хийнэ.

Угаан баяжуулах цехийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм заавруудыг үйлдвэрийн шинэ технологи, тоног төхөөрөмжтэй уялдуулан шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ.

Ажилд шинээр орж буй ажилчид, урьд нь баяжуулах хэсэгт ажиллаж байсан эсвэл дотроо нэг мэргэжлээс нөгөө мэргэжлийн ажилд шилжиж буй бол ажилчид тогтоосон программын дагуу үйлдвэрт ажиллахаас хоёр хоногийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгын сургаалтанд хамрагдаж, үйлдвэрийн ерөнхий инженер буюу түүний орлогчоор удирдуулсан комисст шалгалт өгнө. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу явуулна.

### ***ҮИ.5.2. Галын аюулгүй ажиллагаа***

Угаан баяжуулах хэсэг нь нь ойр орчны сууринуудын гал командтай харилцаатай байна. Шатах, тослох материалын агуулахыг зөв оновчтой газар байршуулж галын аюулгүй байдлыг хангана. Уг талбайд тамхи татах, шүдэнз зурах, гагнуур хийх зэрэг ил гал гаргахыг хатуу хориглоно. Уурхайн хүрээнд гарах гал, гаднын түймэр орж ирэх аюултай бүсийн хэмжээ зэргийг тогтоож галын аюулгүй зурвас татна.

Шороон ордын ашиглалт нь гал гарах боломжтой улиралд явагддаг тул ажлын талбай, ажилчдын дотуур байр зэрэг бүх газарт явахдаа гал гаргах нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд, галын хор хохирол, гал гарсан үед яаралтай унтраах талаар зааварчлага өгнө. Гал гарсан үед гал унтраах хэрэгслийг ашиглах, гэмтсэн осолдсон хүмүүст анхны тусламж үзүүлэх мэдлэг чадварыг ажилчид эзэмшсэн байна.

## **VII.6. Цахилгааны аюулгүй ажиллагаа**



Үйлдвэр дэх цахилгаан тоног төхөөрөмж нь “Цахилгаан тоног төхөөрөмжийн зохион байгуулалтын дүрэм”, “Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн ажиллах үеийн техникийн аюулгүйн дүрэм” –ийг хангасан байна. Зөөврийн дизель станцыг ажиллуулах хүн цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан гал гарах нөхцөл, аваар ослоос урьдчилан сэргийлж ажиллах шаардлагатай. Кабель шугамуудыг газардуулсан байна. Цахилгааны утасны гэмтэл, шалбарах зэргээс үүдэн гал гарах үед түүнийг шуурхай унтраах галын хорыг ажлын байруудад байрлуулсан байна.

#### **VII.7. Усан хангамжийн аюулгүй ажиллагаа**

- Хөрс, шавар бүхий устай хэсгийн дамжуулах хоолойг цахилгааны болон холбооны агаарын шугамаас 25 м-ээс багагүй зайд байрлуулна
- Ус дамжуулах хоолойн зөвхөн нэг гол шугам ашиглаж байгаа үед ус шахах шахуургын ажиллагаа зогсоогоогүй байхад даралттай байгаа хоолойн усыг хаахыг хориглоно.
  - Ус шахах шахуургын ажиллагааг бүрэн зогсоож дамжуулах хоолойн усны даралт шаардлагатай хэмжээнд хүртэл буурсан үед тэдгээрийн залгаас хэсгүүдэд засвар үйлчилгээ хийхийг зөвшөөрнө.
- Ус болон шаврын устай холимог хэсгийг хуримтлуулах малталт, хураагуурууд нь хүн унахаас сэргийлж торон сараалжин хаалт таглаатай байгаад 1 метрээс багагүй өндөртэй хашлагаар гурван талаас нь хаалт тавьсан үед таглаагүй байхыг зөвшөөрнө.
- Шугам хоолойнуудыг ивээс тулгуур дээр байрлуулна.
- Траншей болон суваг шуудуунд тавигдсан шугам хоолойн захын хэсгийг механик гэмтлээс хамгаалсан байвал зохино.

#### **VII.8. Ажилчдын нийгмийн асуудал, эрүүл мэндийг сахин хамгаалах**

Ажилд шинээр орж байгаа хүмүүс нь эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт орж магадлагаа гаргуулсан байна. Ажилчдыг эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын хувцас хамгаалах хэрэгслэлээр хангаж, хэрэглээнд нь хяналт тавина. Мөн ажилчдыг мэргэжлээс шалтгаалах аливаа өвчлөлөөс сэргийлэх үүднээс сургалт зохион байгуулна. Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалж ажиллахдаа доорх 2 арга хэмжээг авна.

##### Техник, технологийн арга хэмжээ:

Ажлын байранд гэрэлтүүлэгт тавих шаардлага MNS4996:2000, доргионы MNS4994:2000, шуугианы норм шаардлага MNS5002:2000, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа MNS4930:2000, ажлын байрны агаарын бүсэд тавих шаардлага MNS 5078:2001 стандартуудын заалтанд тохирсон арга хэмжээнүүдийг авч ажиллах ба зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллана. Зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн хор хөнөөлтэй ажлын байрыг битүүмжлэх, механикжуулах, автоматжуулах, алсын удирдлагатай болгох, шинэ техник технологи нэвтрүүлэх арга хэмжээнүүдийг тухай бүрт авч хэрэгжүүлж ажиллана.

Уурхайн үйл ажиллагааны явцад маш их хэмжээний тоос үүснэ. Ажлын явцад силикоз үүсч болзошгүй аюултай мөргөцөгөөс улиралд 2-с доошгүй удаа, бусад тоос үүсдэг ажлын байрнаас улиралд 1 удаа сорьц авч тоосжилтын шинжилгээ хийж арга хэмжээ авч ажиллана. Ажлын байрны тоосжилтонд MNS5010:2001 стандартыг барьж ажиллах ба уурхайн замын тоос багасгахад тос дарагч бодис /давсны уусмал, мананцар үүсгэх/ уурхайгаас гарсан усыг хэрэглэнэ. Зам усалгааг тогтмолжуулж, уурхайн дотоод замын

сүлжээг тогтоож, шинээр зам гаргахгүй байх журмыг мөрдлөг болгоно.

Бүх төрлийн тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгслүүдэд богино долгионы радио станцаар хангаж шуурхай холбоо барих ажлын нөхцлийг бүрдүүлж ажиллана.

Ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээ:

Ажлын байрны орчин эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2000 стандартын шаардлагыг хангасан орчин бүрдүүлж ажиллана.

Уурхайд цэвэр агаараар байнга сэлгэгдэж байдаг, дуу шуугианы нөлөөлөлгүй, тав тухтай тохилог 130 м<sup>2</sup> талбай бүхий хэмжээтэй амрах болон чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан өрөөг байгуулж ажиллана.

Ажлын байрнаас 300м-с доошгүй зайд эрүүл ахуйн шаардлага бүрэн хангасан сандал ширээ, уух ус, толь, өлгүүр, гар угаах угаалтуур, хогийн сав зэргээр тоноглогдсон түр амарч алжаал тайлах ахуйн байраар хангана.

Хооллох газрын эрүүл ахуйн шаардлага: Уурхайн ажилчдад зориулан эрүүл ахуйн шаардлагын хэм хэмжээний дагуу /нэг хүнд 1.2 м<sup>2</sup> суудал бүхий талбай ноогдож байхаар хэмжээтэй/ цэвэр тохилог тухтай хооллох газартай байна. Эрүүл мэндийн үзлэг хийлгэсэн, мэргэжлийн үнэмлэхтэй тогооч ажиллуулна. Ундны усыг хадгалах савыг тогтмол ариутгаж цэвэрлэсэн байна. Уурхайн хоолны газар нь халуун хоол хүнс хэрэглэхэд зориулсан тоног төхөөрөмж, хэрэгсэл, ширээ сандал, тавиур, хогийн сав, хоолны хэрэгслэлээр бүрэн тоноглогдсон байна. Ажилчдад зориулсан хоол нь бие махбодийн алдсан энергийг нөхөхүйц, чанар сайтай иж бүрдэл байна. Ажилчдын амрах байрыг стандарт шаардлагуудад нийцсэн байхаар засаж ая тухтай байдлыг бий болгоно.

Үйлдвэрийн ажилчдыг байр, гэрэл, цахилгаан, чөлөөт цагаа өнгөрүүлэх спортын талбай, зурагт, радио зэргээр хангаж, барилга байгууламжийг салхины чиглэлийн дээд талд зохих шаардлагын дагуу байрлуулна.

Ажилчдад өдөрт 3 удаа халуун хоол, цайгаар үйлчилнэ.

Үйлдвэрийн ажилчдын тосгонд халуун ус тогтмол ажиллуулна.

Ахуйн хог хаях, бие засах газруудыг тусгай цэгүүдэд байрлуулна.

Хувцас солих өрөөний эрүүл ахуйн шаардлага:

Хувцас солих өрөө нь эрэгтэй, эмэгтэй ажилчдынх гэж тус тусдаа байхаас гадна хувцас, эд юмсыг баттай хадгалахад зориулагдсан цоожтой, өргөн нь 50 см, гүн нь 35 см, өндөр нь 150 см-с багагүй хэмжээтэй хүн бүр хувцасны шүүгээтэй байна.

Хувцас солих өрөө нь тохилог суудал, толь, эд зүйлс тавих тавиур, хогийн сав зэрэг ахуйн хэрэгцээний тоног хэрэгслэлээр хангагдсан байна.

Ундны усны эрүүл ахуйн шаардлага:

Эрүүл ахуйн шаардлага хангасан шинжилж баталгаажуулсан ундны усыг ажлын байр амрах өрөөнд байрлуулна.

Ундны усны сав нь цэвэрлэж ариутгахад хялбар байх ба 7 хоногт 1-с доошгүй удаа зохих зааврын дагуу ариутгаж цэвэрлэж байна.

Бие засах, гар угаах, шүршүүрийн газрын эрүүл ахуйн шаардлага:

Уурхайд ба уурхай дээр улсын ариун цэврийн хяналтын байгууллагаас зөвшөөрсөн газруудад хаагддаг хаалгатай, нэг хүнд 1.2-2 м<sup>2</sup>-с багагүй талбай бүхий бие засах газрыг байгуулж өдөр бүр цэвэрлэж 7 хоногт 1 удаа ариутгал хийнэ.

Бие угаах газар нь халуун устай тосгууртай 45 минутанд усанд орж, хувцас солиод гарахаар, автомат гар хатаагуур, цаасан алчуур, тусгай савтай шингэн савангаар хангагдсан байна.

Ажилтан бүр ажлын нөхцөл, үүргийн онцлогт тохирсон MNS, ISO13688:2000 стандартын шаардлага хангасан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслэлийг заавар зөвлөмжийн дагуу тогтмол зөв хэрэглэнэ.

Хор саармагжуулах хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг сар бүр улирлын онцлогт тохируулан хангана.

Уурхайн усны асуудал:

Уурхайн орчимд бороо цасны усанд автахаас урьдчилан сэргийлсэн далан хаалт суваг байгуулна.

Уурхайгаас гарч буй усанд элдэв хорт хольц илэрвэл уурхайн удирдлага усыг хаах газрыг орон нутгийн ариун цэврийн хяналтын байгууллагатай зөвшилцсөн байна.

Уурхайгаас гадагш шахаж байгаа усанд хими бактерлогийн шинжилгээг жилд 2-с доошгүй удаа хийлгэнэ.

### VII.9. ХАБЭА хууль эрх зүйн орчин

ХАБЭА менежментийн хөтөлбөрийг хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн тухай, эрүүл ахуй, эрүүл мэндийн тухай, Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, галын аюулгүй байдал, гамшгаас хамгаалах тухай, нийгмийн даатгалын тухай гэх мэт хуулиуд болон ХАБЭА норм стандартуудыг баримтлан боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай. УИХ-аас 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр баталсан “ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ” ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ хуулийн заалт болон төсөл хэрэгжихтэй холбоотой ХАБЭА доор дурдсан стандарт шаардлагуудыг баримтлан ажиллах нь зүйтэй.

#### Хүснэгт 55. ХАБЭА -тай холбоотой стандартууд

№	Стандартын нэр	Стандартын тэмдэглэгээ
<b>Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй</b>		
1	ХАБЭА удирдлагын тогтолцоо	OHSAS 18001:2012
2	ХААЭА. Нэр томьёо, тодорхойлолт	MNS 4967 : 2000
3	ХААЭА. Ерөнхий шаардлага	MNS 4968 : 2000
4	ХААЭА. Уул уурхайн боловсруулах үйлдвэрлэл, Ерөнхий шаардлага	MNS 6437:2014
5	ХААЭА-н удирдлагын тогтолцоо. Шаардлага	MNS OHSAS 18001:2012
4	ХААЭА. Сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм	MNS 4969 : 2000
5	ХААЭА. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага	MNS 4990 : 2015
6	ХАБҮЭА. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ	MNS 5080 : 2001
7	ХААЭА. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага	MNS 5105 : 2001
8	ХАБҮЭА, Хөдөлмөрийн физиологи, мэдрэл сэтгэхүйн ачааллыг үнэлэх үзүүлэлтүүдийн норм	MNS 5106 : 2001
9	ХАБҮЭА, Хөдөлмөрийн физиологи, биеийн хүчний ажлын ачааллыг үнэлэх үзүүлэлтүүдийн норм тодорхойлох арга	MNS 5107 : 2001
10	ХАБХЭА. Ачиж буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 5076 : 2013
11	ХААЭА. Өргөх зөөх ачааны массын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.	MNS 4970 : 2000
12	Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө	MNS 4643 : 1998
13	Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага	MNS 4931 : 2000
<b>Цахилгаан</b>		
14	ХАБҮЭА. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага	MNS 5150 : 2002
15	ХАБҮЭА. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Нэр томьёо, тодорхойлолт	MNS 5151 : 2002
16	ХАБҮЭА. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Хамгаалах газардуулга тэглэлт	MNS 5146 : 2002
17	Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага	MNS 5390 : 2004
18	ХАБҮЭА. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Хүрэх хүчдэл ба гүйдлийн зөвшөөрөгдөх дээд түвшин	MNS 5145 : 2002

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

<b>Гал түймэр</b>		
19	Галын аюулгүй байдал. Нэр томъёо ба тодорхойлолт	MNS ISO 13943: 2016
20	Галын аюултай бүтээгдэхүүний ангилал, зэрэглэл	MNS 4999:2000
21	Хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага	MNS 4244 : 1994
22	Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм	MNS 5566 : 2005
23	Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага	MNS 5390 : 2004
24	Шатамхай тоосны тэсрэлт. Галын аюулгүй байдал. Ерөнхий техникийн шаардлага.	MNS 12.105 : 1994
<b>Хамгаалалтын хувцас</b>		
25	ХААЭА. Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага	MNS ISO 13688 : 2000
26	Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага	MNS 4931:2000
27	Толгой хамгаалах хэрэгсэл, сонсгол хамгаалах хэрэгсэл. /чихэвч, бөглөө/	MNS 5388 : 2004
28	Толгой хамгаалах хэрэгсэл, нүд хамгаалах хэрэгсэл, нүдний шил	MNS 5389 : 2004
29	Толгой хамгаалах хэрэгсэл. Дуулга	MNS 5621 : 2006
30	Толгой хамгаалах хэрэгсэл. Нүүрэвч /химийн хорт бодис, механик биет, дулаан гэрлээс хамгаалах нүүрэвч/	MNS 5624 : 2006
31	Амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл /хошуувч, шүүлтүүртэй баг, тусгаарласан агаартай бүтэн баг/	MNS 5620 : 2006
32	Гарын хамгаалалт бээлий. Ерөнхий шаардлага	MNS 5622 : 2011
33	Хөлийн хамгаалалт. Ажлын тусгай гутал	MNS 5623 : 2006
<b>Агаар, гэрэлтүүлэг</b>		
34	ХААЭА. Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага.	MNS 4996 : 2001
35	Ажлын байрны агаар: ажлын байрны агаарын урсгалын хурдыг хэмжих.	MNS 5077 : 2001
36	ХААЭА. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага.	MNS 5010 : 2001
37	Ажлын бүсийн агаар дахь хорт бодисын концентрацын хэмжих аргачлалд тавих шаардлага	MNS: 4991-2000
38	Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага	MNS 5078:2001
<b>Дуу шуугиан</b>		
39	ХААЭА. Ажлын байрны шуугиан, норм аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 5002 : 2000
40	ХААЭА. Шуугианыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага	MNS 5003 : 2000
41	Хэт өндөр дуу, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага,	MNS 12.1.016-1988
<b>Доргио, чичиргээ</b>		
42	ХААЭА. Ажлын байрны доргионы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 4994 : 2000
43	ХААЭА. Доргионыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага	MNS 4995 : 2000

Хуурай, Дэнж, Чулуутын алтны шороон ордыг эзэмшиж буй Оюут цахир уул ХХК дээр дурдсан шаардлага, стандарт норм дүрэм, журмыг баримтлан ажиллана.

### **ҮП.10. Аюулын үед хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх төлөвлөгөө**

Оюут цахир уул ХХК нь Их хуурай уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж ажиллана.

Гал түймэр, байгалийн гамшиг, уурхайн гулсалт нуралтыг аваар буюу онцгой

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024



байдлын үе гэж үзнэ. Уурхайн талбай ажлын байранд аваар осол гарсан тохиолдлын эхний үе шатанд нь хамгийн богино хугацаанд хохирол багатай даван гарч, хүмүүсийг аюул осолд учруулахгүй, нэрвэгдсэн хүмүүст тусламж үзүүлж тэдний амь биеийг аврах нь онцгой байдлын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөний үндсэн зорилт юм.

Уурхайн аваарын дохиолол ба түүнийг хэрэглэх журам:

Уурхайд аваар гарсан тохиолдолд дараах дохиоллыг өгнө. Аваар гарсныг мэдээлэхэд : Урт дуут дохиог 1 удаа

I. Онцгой байдлын үед хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгагдах асуудлууд:

1. Шуурхай хэсгийн хийх ажил
2. Уурхайд гарч болзошгүй аваар осол болох гал түймэр, үер ус, нурал гулсалтын үед ажилтан ажиллагсадын гүйцэтгэх ажил үүргийн хуваарь
3. Аваар устгах ба хүмүүсийн амь насыг хамгаалах аврахад зориулсан хамгаалах баг хэрэгслийн байрлал, тоо, хэмжээ
4. Осол гарсан үед Уул уурхайн аврах алба (УУАА)-ын аврагч, аврах ажлыг зохион байгуулах ажилтан нарын ажил үүргийн хуваарь

II. Төлөвлөгөөнд зайлшгүй байх баримт бичгүүд:

1. Шуурхай хэсэгт байх бичиг баримтууд
  - Уурхайн нутаг дэвсгэрийг бүхэлд нь харуулсан уулын ажлын тухайн жилийн дэвсгэр зураг
  - Уул тээврийн үндсэн тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн байршлыг харуулсан схем зураг
  - Цахилгаан хамгамжийн схем зураг
  - Гэрэлтүүлгийн схем зураг
  - Гал түймэр эсэргүүцэх материал хэрэгсэлийн байршлын схем зураг
2. Осол гарсан тухай заавал мэдэгдэх аж ахуйн нэгж байгууллага, удирдах болон хариуцлагатай ажилтны нэрсийн жагсаалт,
3. Онцгой байдлын үед ажиллах хариуцлагатай удирдагч нь уурхайн ерөнхий инженер байна. Хариуцлагатай удирдагчийн хүрэлцэн иртэл уулын ажлыг удирдан явуулж байгаа ээлжийн мастер үүрэг гүйцэтгэнэ,
4. Үйлдвэрлэлийн хэсэг дамжлага дээр ажиллаж байгаа бүх хүмүүст аваар осол гарсан тухай мэдэгдэх, дохио өгөх, аваар осол гарсан газраас хүмүүсийг аюулгүй зайд гаргах зам, чиглэл, уг ажлыг зохион байгуулж гүйцэтгэх инженер, техникийн ажилтнуудын үүргийн хуваарилалт ба үйл ажиллагааны дэгийг тогтоож өгнө,
5. Аваар осол гарсан үед Уулын цэрэгжүүлсэн аврах ангийн байлдагч (УЦАА)-н байлдагч дарга нарын үйл ажиллагааны хуваарилалт, аврах үеийн тээврийн зохион байгуулалт,
6. Аваарын үед гарах харуулуудын байрлал, онцгой даалгавар, арга хэмжээ нэг бүрийн биелэлтийг хариуцах ажилтнуудыг томилно,
7. Аваар осол гарсан хэсгийн цахилгаан хангамжийн горим, цахилгаан эрчим хүчийг салгах, залгах дэс дараалалыг тогтоох,

Аваарийн тухай яаралтай мэдэгдэх албан тушаалтан ба байгууллагын хаяг, утас, удирдах болон хариуцлагатай ажилтны овог нэр, хаяг, утасны жагсаалт гаргана.  
Жагсаалтанд:

- Уул уурхайн аврах анги

- Уулын үйлдвэр, уурхайн дарга
- Ерөнхий инженер, ерөнхий механик, ерөнхий цахилгаанч,
- Аваар гарсан хэсгийн дарга, инженер
- Аймаг, хот, орон нутгийн хөдөлмөрийн байцаагч
- Геологи, уул уурхайн улсын хяналтын асуудал хариуцсан байгууллага
- Удирдах газрын дарга
- Аймаг хот, орон нутгийн цагдаагийн газар зэрэг

**Аюулын үед хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд биечлэн оролцох хүн тус бүрийн үүрэг:** Аюулын үед хэрэгжүүлэх ажилд удирдахаар ба биечлэн зайлшгүй оролцох ИТА нар тус бүрдээ тодорхой үүргийг хүлээж, хүлээсэн үүргээ нарийн чанд шуурхай биелүүлэх арга хэмжээ авч ажиллана.

**1. Онцгой байдлын үеийн удирдагчийн үүрэг:**

- 1.1 Аваар устгах төлөвлөгөөний шуурхай ажлын хүрээнд тусгагдсан арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлж эхэлнэ. Эхний ээлжинд осолд өртсөн хүмүүсийг аврах ажиллагааг тавьж хэрэгжүүлэх ажлыг удирдах ба хяналт тавина.
- 1.2 Аврах анги, гал унтраах байгууллагад өгсөн дуудлага, түүний хэрэгжилтийг хяналтанд авна.
- 1.3 Аваарт өртсөн газарт буй хүмүүсийн тоог гаргана.
- 1.4 Аврах ангийн даргатай хамтран хүмүүсийг аврах ажиллагааны төлөвлөгөөг тодотгох ба үүнтэй уялдуулан хүмүүсийг аврах, аваарыг устгахад чиглэсэн заалтыг бичгээр боловсруулж баримт бүрдүүлнэ.
- 1.5 Аваар устгах ажлын шуурхай бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулна.
- 1.6 Аврах ажиллагааны явцын талаар мэдээлэл хүлээн авч шуурхай арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааг хянана.
- 1.7 Ослын газарт ажилтнуудыг томилж заагдсан байршлуудад ажиллуулна.
- 1.8 Шуурхай бүртгэлд бүх тушаал зааврыг бичиж оруулах ба тэдгээрийн хэрэгжилтийг хариуцна. Аваар устгах ажлын удирдагч ба аврах багийн удирдагч нарын санал зөрсөн тохиолдолд аваар устгах ажлын удирдагчийн шийдвэрийг дагаж биелүүлэх бөгөөд энэхүү шийдвэр аврах багийн дүрэмд харшилж буй бол энэ тухай шуурхай бүртгэлд тэмдэглэнэ.
- 1.9 Аваарыг устгасны дараа ажлыг зогсоох шийдвэрийг мэдэгдэх ба харуулуудыг буулгана.
- 1.10 Аваар устгахад ажилласан ажиллагсадад амрах зөвшөөрөл олгоно.

**ҮШ.11. Хамгаалах хэрэгсэл**

Ажлын байрнаас ажилчдын эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, хамгаалах хэрэгсэлд тоос шүүгч, хошуувч, хамгаалах хувцас, ажлын дулаан хувцас, халаалт, шуугианаас хамгаалах чихэвч, шуугианы эсрэг бөглөө, улирлын чанартай гутал, бээлий гэх мэт хамгаалалтын хэрэгслүүд орно.

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс уг төслийн ажилчдад доор дурдсан хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах хувцас, хэрэгслээр зайлшгүй хангана. Үүнд:

- Каск
- Зуны ажлын хувцас /жилд/
- Ажлын гутал /зуны жилд/
- Ажлын бээлий
- Нүдний шил
- Чихний бөглөө
- Гагнуурын бээлий
- Гагнуурын хувцас
- Гагнуурын баг
- Маск
- Хамгаалалтын бүс
- Галд тэсвэртэй бээлий, хувцас
- Хошуувч
- Цахилгаанчны бээлий
- Цахилгаанчны бойтог



Хувцас, хэрэгслийг нормын дагуу ажилчдын хийх ажлаас хамааран шаардлагатай тоогоор нь олгохоор тооцоог гаргасан. Уурхай, баяжуулах хэсэгт нийт 62 хүн ажиллах ба нэг хүнд жилд зарцуулах ажлын хувцас хэрэгслийн зардлыг дараах байдлаар тооцов.

**Хүснэгт 56. Нэг ажилтны ХАБЭА-ны хувцас, төг/жил**

№	Зардлын төрөл	Жилийн норм	1 бүрийн үнэ, мян.төг	Нийт үнэ, мян.төг
1	Каск	1	20	20
2	Нүдний шил	2	5	10
3	Ажлын хувцас	1	80	80
4	Борооны цув	1	30	30
5	Ажлын гутал	1	80	80
6	Усны гутал	1	15	15
7	Ажлын бээлий	100	0.5	50
8	Амны хаалт	1	6	6
	<b>Нийт зардал</b>			<b>291.00</b>

### ҮН.12. Үзлэг оношилгоо, сургалтын зардал

Уурхайн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор байнгын сургалт мэдээллийг хийх ба ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, мэргэжлээс шалтгаалсан өвчин эмгэгээс сэргийлэх, ажилчдыг эрүүл мэндийн шинжилгээнд хамруулан ажилчдын эрүүл мэндийн дэвтэр хөтлөж ажиллана.

Төсөл хэрэгжих хугацаанд ажилчдын эрүүл мэндийн үзлэг оношилгоог нэг хүнд 100 мян.төгрөг зарцуулагдахаар тооцоолоод байна.

### ҮН.13. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийт зардал

Уурхайн хамгаалах хувцас хэрэгслийг жилд 1 удаа тавьж өгч байх, үзлэг оношлогооны ажлыг жилд 1 удаа хийж байхаар төлөвлөлөө. Уурхайн ашиглалтын

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

хугацаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардалд нийт 91.5 сая.төг зарцуулахаар байна. Энэ нь нийт үйлдвэрлэлийн зардалд 2%-ийг эзлэж байна.

#### Хүснэгт 57. ХАБЭА-н нийт зардал, /сая.төг/

№	Үзүүлэлт	Нэгж	Ашиглалтын жилүүд
1	ХХАА-ны хувцас хэрэглэлийн зардал	сая ₮	17
2	Үүнд: Захиргаа, аж ахуй	сая ₮	4.2
3	Ил уурхай	сая ₮	8.7
4	Баяжуулах цех	сая ₮	4.1
5	ХХАА-н тэмдэг тэмдэглэгээ, галын булан тохижуулах	сая ₮	5.0
6	ХАБЭА-н сургалт мэдээлэлийн зардал	сая ₮	10.0
7	Үзлэг оншлогоо, эмчийн хяналтын зардал	сая ₮	18.2
8	Эрсдлээс хамгаалах зардал	сая ₮	2.5
9	Эрүүл мэндийн даатгал	сая ₮	41.4
	<b>Нийт</b>	сая ₮	<b>94.1</b>
10	Нийт үйлдвэрлэлийн зардалд эзлэх хувь		2.7
	Нэг ажилтны эрүүл мэндийн үзлгийн зардал		100000
	Эрүүл мэндийн даатгал цалингийн 2%		2%
	ХАБЭА-н зардал үйлдвэрлэлийн зардлын 1.5%-их байх		2%

#### ҮН.14. Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага

1. Баяжуулах үйлдвэрийн техник, технологи нь орчин үеийн шаардлагад нийцсэн, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлгүй байх;
2. Баяжуулах үйлдвэрт шаардлагатай ус, цахилгаан, дулаан хангамжийн эх үүсвэрийг бүрдүүлэх, холбогдох зөвшөөрлийг авч шаардлагатай тохиолдолд гэрээ байгуулсан байх;
3. Үйлдвэрийн гадаад орчин дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - Үйлдвэрийн хаяг, байршлын ерөнхий зургийг байршуулсан байх;
  - Зам, талбайг цардсан, анхааруулах болон мэдээлэх тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлэгтэй байх,
  - Тохижилт, эрүүл ахуйн шаардлага хангасан байх;
  - Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг түр хадгалах болон устгах, тусгайлан зассан цэг талбайтай байх;
4. Баяжуулах үйлдвэрийн ажлын байранд тавигдах шаардлага. Үүнд:
  - Ажлын байрны тодорхойлолттой байх;
  - Хүний нөөцийг мэргэжил дээшлүүлэх болон давтан сургалтад хамруулсан байх;
5. Баяжуулах үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэгдсэн дүрэмд нийцсэн байх;
  - Үйлдвэрийн доторх дэвсгэр зураг, орц, гарцын схемийг байршуулсан байх;
  - Ажлын байрны дүгнэлт гаргуулсан байх;
6. Баяжуулах үйлдвэр дээр дараах баримт бичгийг байлгана. Үүнд:
  - Хуулийн этгээдийн гэрчилгээ (хуулбар);
  - Үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл;
  - Баяжуулах үйлдвэрийн хаягдлын аж ахуйн зураг төсөл;



7. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө болон тайлан, сар, улирал, долоо хоногийн мэдээ;

- Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ;
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө;
- Газар ашиглах гэрээ;
- Ус ашиглах гэрээ;
- Цахилгаан ашиглах гэрээ;
- Ажил гүйцэтгэх зааварчилга;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилга, сургалтын бүртгэл;
- Баяжуулах үйлдвэрийн ажилчдын судалгаа (Мэргэжлийн боловсон хүчин, орон нутгаас ажиллагсдын мэдээлэл);
- Төлөвлөгөөт хяналт, сорьцолтын тайлан, хяналтын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийн тайлан.
- Баяжуулалтын технологийн хяналтын өдөр тутмын бүртгэл.
- Тоног төхөөрөмжийн ашиглалтын паспортыг хөтлөх.
- Хаягдлын аж ахуйн хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

## **БҮЛЭГ ҮШ. БАЙГАЛЬ ОРЧИН**

### **ҮШ.1. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгүүд**

Төслийг хүрээлэн буй орчны зохих стандартуудад нийцүүлэх, үйл ажиллагаа ба хаалтын явцад төлөвлөгдөөгүй байдлаар гарч ирэх ашиглалтын болон капитал зардлын улмаас үүсэх санхүүгийн эрсдэлийг бууруулахад туслах замаар хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллийг бууруулах стратегийг тодорхойлж, бий болгоход чиглэсэн арга хэмжээнүүдийг энэхүү ТЭЗҮ-д тусгаж өгсөн болно.

Төслийн байгаль орчны төлөв байдал, нарийвчилсан үнэлгээ, жил бүр байгаль орчныг хамгаалах талаар үйл ажиллагаа явуулах төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайланг байгаль орчны эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлж зохих байгууллагаар хянуулж батлуулж ажиллах үүрэгтэйгээр төслийн үйл ажиллагаа явагдана.

Оюут цахир уул ХХК нь уурхайн үйлдвэрлэл явуулах явцад хүрээлэн буй орчныг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, бохирдлын мониторинг, байгаль орчны менежментийн үйл ажиллагаанд дараах хууль, журам, стандартуудыг мөрдөн ажиллах шаардлагатай.

### **ҮШ.2. Байгаль орчныг хамгаалах удирдлагын тогтолцоо**

Дээр дурьдсан байгаль орчны төлөв байдал, нарийвчилсан үнэлгээ, тухайн жилийн төлөвлөгөө, тайлан болон байгаль орчинтой холбоотой баримт бичгийг гүйцэтгүүлэх, байгаль орчин хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагад танилцуулах, батлуулах

ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг юм.

Мөн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж нь хариуцлагатай уул уурхай, тогтвортой хөгжлийн чиг баримтлалыг хөгжүүлэх чухал хэрэгсэл болох ISO 14001-д нийцсэн удирдлагын тогтолцоог боловсруулан хэрэгжүүлэх зорилго тавин ажиллах нь зүйтэй. БОУТ-г хэрэгжүүлснээр төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүхий л бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлж буй болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг үе шаттайгаар хянах, гол нөлөөллүүдийг бууруулах, үйл ажиллагаагаа тогтмол сайжруулах, хууль эрх зүйн шаардлагуудыг биелүүлэн бизнесийн үйл ажиллагаагаа үр ашигтай тогтвортой үргэлжүүлэх боломж олгох юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчны удирдлагын тогтолцоо MNS ISO 14001:2005” буюу Олон улсын ISO 14001 стандартын шаардлагыг хангасан байгаль орчинд ээлтэй байгууллага болох зорилтын хүрээнд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын бүтэцтэйгээр ажиллахыг зөвлөж байна.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2014 онд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал” –ийн 4-р хэсэг болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгоно.

Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж байх юм.

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараахи гол зорилтуудыг тавин ажиллана. Үүнд:

- Байгаль орчны холбогдолтой хууль эрхзүйн акт, шаардлагуудын нарийвчилсан бүртгэлийг хийж, эрхзүйн хэрэгжилтийг сайжруулж, тэдгээрийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгоход анхаарч ажиллах,
- Байгаль орчны хяналт шинжилгээний ажилд нутгийн иргэдийг оролцоог хангах,
- Байгаль орчны удирдлагын тогтолоцооны стандарт ISO 14001 –д заасан баримт бичгүүдийг байгууллагын үйл ажиллагаа, онцлогтой уялдуулан боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх,
- Уурхайн усны ашиглалт, төлөвлөлтөнд дүн шинжилгээ хийж сайжруулан ажиллах,
- Үйл ажиллагааны улмаас төсөл хэрэгжих нутгийн экосистемийн бүрэлдэхүүн хэсэг бүрт үзүүлэх байгаль орчны эрсдлүүдийн бүртгэл үнэлгээг олон улсын стандартын дагуу хийж, тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах улмаар арилгах шат дараатай үйл ажиллагааны төлөвлөлт хийн, арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Төслийн нийт ажилчдын байгаль орчны соёлыг өөрчлөх, экологийн мэдлэгийг дээшлүүлэх, тэднийг байгаль хамгаалах үйлст татан оролцуулах, компанийн байгаль орчны бодлого, хууль эрхзүйн дүрэм журмуудыг танилцуулах, нийт ажилчдыг хамарсан байгаль орчны сургалт, мэдлэг олгох зорилготой “Байгаль орчны сургалтын цогц хөтөлбөр”-г боловсруулан хэрэгжүүлж, байгаль орчинд ээлтэй эко-уурхай болох зорилт тавьж ажиллах,
- Төсөл хэрэгжих нутгийн биологийн олон янз байдлын цогц судалгааг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаараар хийлгэж, судалгааны үр дүнд тулгуурлан Биологийн олон

янз байдлыг хамгаалах урт хугацааны менежментийн хөтөлбөр, дүйцүүлэн хамгаалах стратеги боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллах,

➤ Төсөл хэрэгжих орчны агаарын чанарын нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, орчны агаарын чанарыг сайжруулах, тоосжилтыг бууруулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллах,

➤ Хог хаягдлын хэмжээ, түүний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор шат дараатай арга хэмжээ хэрэгжүүлж, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг дахин боловсруулах зах зээлд нийлүүлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх,

➤ Нефтийн бүтээгдэхүүний асгаралт бий болох нөхцөлийг арилгаж, бохирдсон хөрсийг эрүүлжүүлэх, саармагжуулах үйл ажиллагааг сайжруулах,

➤ Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, нөхөн сэргээлтийн ажилд нутгийн ургамлын үрийг ашиглах, энэ арга хэмжээнд нутгийн нөхөрлөлүүдийг татан оролцуулах үйл ажиллагааг үргэлжлүүлэх,

➤ Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрх бүхий төрийн байгууллагын үнэлгээгээр 90% -иас дээш дүнтэй хэрэгжүүлэх.

### ҮШ.3. Байгаль орчныг хамгаалах хууль эрх зүйн орчин

Байгалийн нөөцийг ашиглах болон байгаль хамгаалахад шаардлагатай Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зарим хууль, тогтоомжуудыг дараах хүснэгтэд жагсаан харуулав.

**Хүснэгт 58. Байгаль орчныг хамгаалах МУ-ын хууль, тогтоомжууд**

№	Хуулийн нэр	Батлагдсан огноо	Нэмэлт өөрчлөлт орсон
1	Ашигт малтмалын тухай хууль	2012.05.27	
2	Агаарын бохирдлын төлбөрийн тухай	2010-06-24	-
3	Агаарын тухай	2010-06-24	2012-05-27
4	Хог хаягдлын тухай	2003-11-28	2012-05-17
6	Амьтны тухай	2012-05-17	-
7	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай	2006.05.25	2012-05-17
8	Байгалийн ургамлын тухай	1995-04-11	2010.12.09
9	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай	2012-05-17	
10	Байгаль орчны хамгаалах тухай	1995-03-30	2010.07.08
11	Газрын тухай	2002-06-07	2005.07.01
12	Газрын хэвлийн тухай	1988-11-29	1995.04.17
13	Газрын төлбөрийн тухай	1997-04-24	2005.07.01
14	Соёлын тухай	1996-04-11	
15	Соёлын өвийг хамгаалах тухай	2001-06-08	2005.06.02
16	Ургамал хамгааллын тухай	2007-11-15	2011.01.20
17	Усны тухай	2004-04-22	2009.08.25
18	Ус бохирдуулсаны төлбөрийн тухай	2012-05-17	
19	Химийн хорт болон аюултай хорт бодисын тухай	2006-05-22	2011.10.06
20	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	2008-05-22	2011.01.20
21	Гамшгаас хамгаалах тухай	2012.05.17	
22	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай	2012.05.17	
23	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай		

Дээрх хуулиудаас гадна байгаль орчныг нөхөн сэргээх дараах стандарт, тушаалыг баримталж үйл ажиллагаа явуулна.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024

**Хүснэгт 59. Байгаль орчныг нөхөн сэргээх стандартууд**

Д/д	Стандартын тэмдэглэгээ	Стандартын нэр
<b>Нөхөн сэргээлт</b>		
1	MNS 5914:2008	БО. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
2	MNS 5915:2008	БО. Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал.
3	MNS 5916:2008	БО. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
4	MNS 5917:2008	БО. Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага
5	MNS 5918:2008	БО. Эвдэрсэн газрыг дахин ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
<b>Агаарын чанар</b>		
6	MNS (ISO) 4226:2000	Агаарын чанар: ерөнхий шаардлагууд, үзүүлэлт.
8	MNS 4585:2007	Агаарын чанарын параметрууд. ерөнхий шаардлагууд
9	MNS 5365:2004	Агаарын чанарын ерөнхий асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга
11	MNS 17.2.3.16:1988	Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам.
12	MNS ISO 4227:2002	Хүрээлэн буй орчны агаарын чанар хяналтын төлөвлөгөө
13	MNS 17.2.0.07:1979	Байгаль орчныг хамгаалах. Агаарыг бохирдуулах хаягдал
14	MNS 4585:2007	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
15	MNS 3113:1981	Агаар мандал. Агаарын бохирдуулах бодисыг тодорхойлох аргад тавих ерөнхий шаардлага.
16	MNS6342:2012	“Агаарын чанар, аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”.
<b>Хөрс</b>		
17	MNS 3473:1983	Байгаль орчин: Газар ашиглахтай холбоотой нэршил, нэр томьёо
18	MNS 17.5.1.18:1983	Байгаль орчны хамгаалал. Сэргээн сайжруулах. Эвдэрсэн газрын ангилал.
19	MNS 17.5.1.19:1992	Байгаль орчны хамгаалал. Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах ерөнхий шаардлага.
20	MNS 3473:1983	Байгаль хамгаалал. Газар. Газрын эдэлбэр. Газар ашиглалт. Нэр томьёо тодорхойлолт
21	MNS ISO 11277:2002	Хөрсний чанар. Эрдэс хөрсний найрлага дахь жижиг хэсгүүдийг тодорхойлох. Тунгаах ба шигших арга
22	MNS 5850:2008	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
23	MNS 5546:2005	Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага
24	MNS 5914 : 2008	Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт
25	MNS ISO 11074:2001	Хөрсний чанар. Хөрс хамгаалах бохирдлоос сэргийлэх холбогдох нэр томьёо, тодорхойлолт. Тайлбар толь.
<b>Ус</b>		
26	MNS 4585:1998	Усны байгалийн чанарыг тодорхойлох ерөнхий шаардлагууд
27	MNS 4586:1998	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
28	MNS (ISO) 4867:1999	Усны чанар. Хамгаалах, хадгалах тухай зөвлөмж
29	MNS 0899:1992	Усны эх үүсвэрийг сонгон авах ерөнхий шаардлага, эрүүл ахуйн нөхцөл.
30	MNS 0900:2005	Ундны ус: чанарын хяналт ба эрүүл ахуйн шаардлагууд
31	MNS 4943:2000	Усны чанар. Effluent стандарт
32	MNS 0900:2005	Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
33	MNS 3900:1986	Ундны ус. Амт, үнэр, өнгө, булингарыг тодорхойлох арга

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Чулуут амны алтны шороон ордын хайгуулын шугам 10-20, Хуурайн алтны шороон ордын татмын хэсгийн хайгуулын шугам 27-28, Дэнжийн хэсгийн 25-34 хайгуулын шугамын хоорондох алтны шороон ордыг ил аргаар ашиглах төлөвлөгөө - 2024



34	MNS ISO 0017-1-1-10:1979	Усны ашиглалт, хамгаалалт. Нэр томъёо, тодорхойлолт
35	MNS 3342:1982	Байгаль орчны хамгаалал. Усан мандал. Газар доорх усыг бохирдлоос хамгаалах. Ерөнхий шаардлага
36	MNS ISO 5667-11:2000	Усны чанар. Дээж авах. 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж
37	MNS 3949:2011	Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус Ерөнхий шаардлага
38	MNS 4288:1995	Бохир ус цэвэршүүлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологийн түвшинд тавигдах ерөнхий шаардлага
<b>Байгаль хамгаалах</b>		
39	MNS 0017-0-0-06:1979	Байгаль орчны хамгаалах стандартын тогтолцоо
40	MNS 4191:1993	Байгаль орчны хамгаалах стандартын тогтолцоо. Монгол Улсын цаг агаар, гол үзүүлэлтүүд
41	MNS 4219:1994	Байгаль орчны хамгаалал. Аж ахуй нэгжийн экологийн паспорт. Үндсэн дүрэм
42	MNS 17.0.0.06:1979	Байгаль орчныг хамгаалах стандартын систем. Үндсэн дүрэм
43	MNS ISO 14001:2005	Байгаль орчны удирдлагын тогтолцоо - Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар
<b>Ургамал</b>		
44	MNS 6191:2010	Ховор ургамал тарималжуулах ерөнхий шаардлага
45	MNS 5664:2006	Эрдэс бордоонд фосфор, азотын агууламжийг тодорхойлох арга
